



# ССТБЭБС Хөтөлбөр

## Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын бодлогын баримт бичиг

**SRMI** Sustainable Renewables  
Risk Mitigation Initiative

*Эргэлзээтэй ойлголтууд үүссэн тохиолдолд ССТБЭБС Хөтөлбөрийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын бодлогын баримт бичгийн англи хувилбар нь хүчин төгөлдөр үйлчилнэ гэдгийг анхаарна уу.*

## АГУУЛГА

---

<b>1.</b>	4	
<b>2.</b>	4	
2.1	Үндэслэл	5
2.2	Хөтөлбөрийн зорилтууд	6
2.3	Хөтөлбөрийн ерөнхий хураангуй	6
2.4	БОН-ийн эрсдэлийн удирдлагын арга барил	7
<b>3.</b>	9	
3.1	БОН-ийн эрсдэл, нөлөөллийн магадлал	9
3.2	БОН-ийн стандартууд	9
3.3	Төслүүдийн БОН-ийн эрсдэл, сөрөг нөлөөллийн магадлал, тэдгээрийг арилгах нь	11
3.3.1	БОНС1	12
3.3.2	БОНС2	12
3.3.3	БОНС3	12
3.3.4	БОНС4	13
3.3.5	БОНС5	13
3.3.6	БОНС6	13
3.3.7	БОНС7	13
3.3.8	БОНС8	14
3.3.9	БОНС9	14
3.3.10	БОНС10	14
<b>4.</b>	17	
4.1	Төслийн бэлтгэл ажил	15
4.2	Төслийн хэрэгжилт	16
<b>5.</b>	19	
5.1	Оролцогч талуудын оролцоо, олон нийтэд мэдээлэх ажил	17
5.2	БОН-ийн санал, гомдол шийдвэрлэх механизм	18
<b>ХАВСРАЛТ 1: БОН-ИЙН АМЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЧИГЛҮҮЛЭГЧ ЗАГВАР</b>		<b>20</b>

<b>ХАВСРАЛТ 2: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ЖАГСААЛТ</b>	<b>29</b>
<b>ХАВСРАЛТ 3: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР</b>	<b>32</b>
<b>ХАВСРАЛТ 4: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ БА БОННУ, БОНМТ-ний ЖИШИГ ЗАГВАР</b>	<b>39</b>
<b>ХАВСРАЛТ 5: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР</b>	<b>45</b>
<b>ХАВСРАЛТ 6: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР</b>	<b>52</b>
<b>ХАВСРАЛТ 7: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДТЭЙ ХОЛБООТОЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР</b>	<b>55</b>
<b>ХАВСРАЛТ 8: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ АГУУЛАМЖ</b>	<b>61</b>
<b>ХАВСРАЛТ 9: ХӨДӨЛМӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖИШИГ ГОРИМУУД</b>	<b>63</b>
<b>ХАВСРАЛТ 10: ЖЕНДЭР</b>	<b>67</b>

## 1. ТАНИЛЦУУЛГА

---

Энэхүү баримт бичиг нь Сэргээгдэх салбарын тогтвортой байдлын эрсдэлийг бууруулах санаачилга (ССТБЭБС)-ын дагуу мөрдөх Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын бодлогын баримт бичиг (БОНТБББ)-ийг тодорхойлсон болно. Үүнд Байгаль орчин, нийгэм (БОН)-ийн менежментийн суурь стандарт, үйл явц, хэрэгслийг тодорхойлов.

Үүнд мөн ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд санал болгосон төслүүдэд шаардагдах байгаль орчин, нийгмийн баримт бичгийн суурь загвар, ерөнхий ойлголтыг багтаав.

Мөн Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн бодлогын баримт бичиг (БОНБББ)-т тодорхойлсон Банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-уудын хэрэгжилтийг хангах явцад төслүүдэд тулгарах байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд Зээлдэгчийн зүгээс авах гол алхмуудыг БОНТБББ-д тодорхойлов.

Энэхүү БОНТБББ нь ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд хоёр шатлалтай явагдах бөгөөд хөтөлбөрийн бүх төсөлд хүчин төгөлдөр үйлчилнэ. Эхний шатны төслүүд нь Ботсвана, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Кени, Мали, Намиби, Узбекистанд хэрэгжинэ. Хоёрдугаар шатны төслүүд нь Индонез, Вьетнам, Монгол, Тажикстанд хэрэгжих болно.

## 2. ХӨТӨЛБӨРИЙН УДИРТГАЛ

---

### 2.1 Үндэслэл

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл жил бүр өсөн нэмэгдсээр байгаа ч дэлхийн эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн өчүүхэн хувийг эзэлсэн хэвээр байгаа төдийгүй Парисын гэрээний зорилтуудыг хангахад шаардагдах түвшнээс хэт доогуур хэвээр байна. Хувьсах сэргээгдэх эрчим хүч (ХСЭЧ буюу VRE)-ийг оролцуулаад салхи, нар, биомасс, хаягдал эрчим хүч, газрын гүний дулаан, далай, бага оврын усан цахилгаан станцаас гарган авсан эрчим хүчний цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээ 2010 онд 6 хувь байсан бол 2018 оны байдлаар 12.9 хувь болж нэмэгдсэн. Эрчим хүчний аюулгүй, хүртээмжтэй байдлыг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын гэрээний хүрээнд дэлхийн дулаарлыг Цельсийн 2 градуст тогтоон барьж, хадгалахын тулд нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэлийг их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага тулгараад байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн (Дэлхийн эрчим хүчний төлөв 2018) Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгаснаар 2025 он гэхэд хөгжиж буй орнуудад нийт 950 гигаваттын нарны цахилгаан станц, 580 гигаваттын салхины цахилгаан станц байгуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл одоогийнх дээр нэмээд 690 гигаваттын нарны эх үүсвэр, 330 гигаваттын салхины эх үүсвэр суурилуулах шаардлагатай.

Харьцангуй хямд өртөгтэй болоод буй нар, салхины цахилгаан станцын суурилуулсан хүчин чадлын хэмжээ хөгжиж буй орнуудад хязгаарлагдмал байгаа нь эдгээр орнуудад зохицуулалтын, бүтцийн, техникийн саад бэрхшээл оршин буйг харуулж байна. Одоогоор олж тогтоосон гол саад бэрхшээлүүд нь (i) эрчим хүчний үйлдвэрлэл, цахилгаан дамжуулах шугам зэргийг төлөвлөх чадвар хязгаарлагдмал байгаа, (ii) тогтвортой байдалд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөдөлгөхөд саад болж буй бодлого зохицуулалт хангалтгүй, (iii) Эрчим хүч бие даан үйлдвэрлэгч (ЭХБДҮ)-ийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны хүчин чадал хязгаарлагдмал, (iv) тендерт ялсан компанийн санхүүгийн чадвар хязгаарлагдмал, (v) эрчим хүч дамжуулах сүлжээний хүчин чадал сул байгаагийн улмаас ХСЭЧ-ний сүлжээг нэгтгэхэд сорилтууд тулгарч байгаа, тэр дундаа өвөр Сахарын Африк.

Эрчим хүчний салбарын менежментийн дэмжлэгийн хөтөлбөрөөрөө дамжуулан Дэлхийн Банк эдгээр сорилтуудыг шийдвэрлэж, улс орнуудад санхүү, техникийн нэгдсэн дэмжлэг санал болгох үүднээс ССТБЭБС-ийг боловсруулсан болно. Дэлхийн Банкны ахалж, Францын хөгжлийн агентлаг (ФХА/AFD), Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (ОУСЭХА/IRENA), Олон улсын нарны эрчим хүчний холбоо (ОУНЭХХ/ISA)-той хамтран, COP 24-т зориулж 2018 онд эхлүүлсэн ССТБЭБС буюу анхандаа Нарны эрчим хүчний эрсдэлийг арилгах санаачилга хэмээн нэрлэгдэж байсан энэхүү хөтөлбөр нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлэх зорилготой бөгөөд үр дүнд нь энэхүү салбарын төсвийн санхүүжилтээс хараат байдлыг бууруулж, улс орнуудад нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг (эмэгтэйчүүдийг дэмжих чиглэл үүнд багтаж буй) нь нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

Covid-19-ийн хямралын энэ үед ССТБЭБС-ийн өвөрмөц, нэгдмэл, дахин ашиглах боломжтой байдал нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад хөшүүрэглэж, төрийн хөрөнгө оруулалтыг зорилтот салбарт нь чиглүүлэх замаар улс орнуудад ногоон эдийн засгийн татаас бий болгож, туслалцаа үзүүлэх боломжтой юм. ССТБЭБС нь хөгжлийн болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг санхүүжилтийг

дараах зүйлд санал болгохыг зорьж буй аж. Үүнд: (i) улс орнуудад ХСЭЧ-ийн зорилтуудыг нотлох баримтад суурилсан байдлаар боловсруулахад нь техникийн туслалцаа үзүүлэх; (ii) ХСЭЧ-ийг нэгтгэхэд шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалт, нар/салхины паркийн дэд бүтцийн санхүүжилтийг олгож, эрчим хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх; (iii) хувийн хэвшилд тулгарч буй бусад эрсдэлийг арилгах баримт бичгийг боловсруулахад оршино. Сэргээгдэх эрчим хүчний хөгжилд зориулсан энэхүү санхүүгийн дэмжлэг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих богино хугацааны тэтгэмж, иргэн бүрд олгох мөнгөн тусламж, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд тусгайлан олгож буй санхүүжилт зэрэг засгийн газрын эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүд хэрэгжиж буй одоогийн нөхцөлд илүү ач холбогдолтой болж буй юм.

ССТБЭБС Хөтөлбөрөөр нийт 10 улсад техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр зорьж байгаа. Эдгээр улсууд 2017 онд дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын 6 хувийг бүрдүүлж байсан ч business as usual (BAU) буюу одоогийн замналаараа 2017-2030 онд ялгарлын хэмжээ нь дунджаар гурав дахин нэмэгдэхээр байна. Энэхүү 10 улс нь олон улсын дэмжлэгтэйгээр хүлэмжийн хийн ялгарлын хэмжээгээ бууруулах чиглэлд, тэр дундаа хамгийн ихээр ялгаруулж буй эрчим хүчний салбарт анхаарч, асуудлыг шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Гэсэн ч улс орнууд одоогоор Covid-19-ийн хямралыг даван туулахаар яаралтай, онц байдлын арга хэмжээнд түлхүү анхаарч байна. Урт хугацааны замналаа тодорхойлж, Өөрийн орны санаачилгаар хувь нэмрээ оруулах баримт бичиг (ӨОНСХНОББ/NDC)-ийн зорилтууд баттай биелэх эсэхийг тодорхойлохын тулд эдийн засаг хэрхэн сэргэх вэ гэдгийг тодорхойлох нь чухал хэвээр байна. Засгийн газрууд эдийн засгийн дараагийн хямралд урьдаас бэлтгэж, нүүрсхүчлийн хийн ялгаралыг бага байлгах хөгжлийн стратеги, бодлого тодорхойлохгүй бол хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ дахин нэмэгдэж, 2030 он гэхэд өмнө тодорхойлсон түвшнээсээ ч давах боломжтой төдийгүй эдийн засгийн өсөлт нь илүү доогуур байх боломжтой.

Иймд бодитой өөрчлөлт бий болгохын тулд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөнгөлөлттэй санхүүжилт, дунд хугацааны дэмжлэгийн стратеги бүхий ногоон татаас бий болгоход нь бодлого тодорхойлогчдод дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

## 2.2 Хөтөлбөрийн зорилтууд

ССТБЭБС Хөтөлбөрийн зорилтууд нь:

- (i) Хөгжиж буй орнуудад хүлэмжийн хий бага ялгаруулах хөгжлийн замналыг сонгоход дутагдаж буй сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд чиглэсэн тогтвортой бөгөөд баттай санхүүжилтийн шугам бий болгох асуудлыг шийдвэрлэх
- (ii) Зорилтот улсуудад Covid-19-ийн дараах эдийн засгийн өсөлтөд суурь дэмжлэг үзүүлэх зорилгоор урамшууллын ногоон багц хөтөлбөрийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх юм.

ССТБЭБС Хөтөлбөрийн сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр нь хөгжиж буй орнуудын цахилгаан эрчим хүчний үндэсний бодлого, Эрчим хүч бие даан үйлдвэрлэгч (ЭХБДҮ/IPP)-ийг сонгон шалгаруулах ажлын ололт амжилт, алдаа, дутагдлаас олж авсан сургамжид тулгуурлах болно.

## 2.3 Хөтөлбөрийн ерөнхий хураангуй

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөшүүрэглэхийн тулд шийдвэрлэх шаардлагатай дараах гол саад бэрхшээлүүдийг одоогоор тодорхойлсон бөгөөд хоёр ерөнхий ангилалд хуваах боломжтой гэж үзэж байна: (i) барилга, үйл ажиллагаанаас өмнөх буюу хөгжүүлэлтийн шатанд тулгарах эрсдэлүүд; (ii) төслийг үйл ажиллагаанд оруулсны дараах эрсдэлүүд. Энэхүү хоёр төрлийн эрсдэл нь ЭХБДҮ болон зээлдэгчийн хөрөнгө оруулалтын зардалд багтаж байгаа. Одоогийн хямралд энэхүү эрсдэлүүд улам хүнд тусах магадлалтай төдийгүй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөшүүрэглэхийн тулд эрсдэлд зориулсан нэгдсэн дэмжлэг шаардлагатай болно.

Эдгээр эрсдэлийг арилгахын тулд ССТБЭБС Хөтөлбөр нь гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд явагдах үйл ажиллагааг дэмжинэ. Үүнд:

- a. **Бүрэлдэхүүн хэсэг 1: Техникийн туслалцаа** – хамгийн бага зардлаар эрчим хүч үйлдвэрлэх нэгдсэн, цогц төлөвлөлт гаргахад төвлөрнө. Үүнийг ХСЭЧ-ийн нэгдсэн сүлжээний дүн шинжилгээ, хууль, санхүү, худалдан авах ажиллагааны дэмжлэгтэй нэгтгэх бөгөөд нар, салхины паркийн цаашдын тендерүүдэд зориулж ЭХБДҮ-ийн сонгон шалгаруулалтыг өрсөлдөөнтэй байлгаж, гэрээ байгуулахад нь зөвлөж, техникийн болон БОН-ийн асуудлуудад дэмжлэг үзүүлнэ.
- b. **Бүрэлдэхүүн хэсэг 2: Төсвийн хөрөнгө оруулалт** – нар, салхины паркийн дэд бүтэц, ХСЭЧ-ийн сүлжээний шинэчлэл (төрийн өмчит цэнэг хураагуурын агуулах), дамжуулах сүлжээний уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал, хүн амыг цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбох ажилд төрийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэхэд төвлөрнө.
- c. **Бүрэлдэхүүн хэсэг 3: Эрсдэл бууруулахад чиглэсэн баримт бичгүүд** – дамжуулах сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй эсэхээс үл хамаарч сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх/хуримтлуулах шийдэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор эрсдэл бууруулах баримт бичгээр хангахад төвлөрнө.

Техникийн туслалцааны бүрэлдэхүүн хэсэг нь төлөвлөлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор тогтвортой сэргээгдэх эрчим хүчний зорилтууд хөгжүүлэхэд анхаарч, хүлэмжийн хий бага ялгаруулах хөгжлийн замналд зориулсан, нотлох баримтад суурилсан зорилтууд тогтоохын тулд улсын хэмжээний/макро түвшний эрсдэлд төвлөрч, ЭХБДҮ-ийн сонгон шалгаруулалтыг өргөн хүрээнд, нээлттэй явуулах замаар худалдан авах ажиллагааны эрсдэлийг бууруулж, засгийн газрын дотоод хүчин чадлыг нэмэгдүүлж, нар/салхины паркийн схемийг ашиглан ЭХБДҮ-үүдэд газар өмчлүүлж, тусгай зөвшөөрөл олгох замаар бүтээн байгуулалтын эрсдэлийг бууруулна. Төрийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг нь дамжуулах сүлжээ, дэд бүтцийн түвшний эрсдэлд анхаарах бөгөөд ХСЭЧ-ийг нэмэгдүүлсний улмаас сүлжээний тогтвортой байдалд үүсэх хязгаарлалт, эрсдэлийг хамгийн бага байлгаж, дамжуулах сүлжээний уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлж, ЭХБДҮ-үүдэд шаардлагатай нэгдсэн дэд бүтцийг санхүүжүүлж, хүн амын эмзэг бүлгийг цахилгааны шугамтай холбоход төвлөрнө. Эрсдэл бууруулах хэрэгслийн бүрэлдэхүүн хэсэг нь хувийн хэвшилд тулгарах бусад эрсдэлд анхаарна. Ингэхдээ дамжуулах шугамтай холбогдох, үл холбогдох сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд чиглэх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгахад төвлөрнө.

ССТБЭБС Хөтөлбөрөөс дараах гол үр дүнгүүд гарах төлөвтэй байгаа:

- a. Дамжуулах шугамд холбогдох, үл холбогдох сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж,, ХСЭЧ-ийн хүчин чадлыг сайжруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, ХСЭЧ-ийн нэгдсэн сүлжээ бий болгоно,
- b. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөшүүрэглэх замаар төсөвт учруулах дарамтыг бууруулна,
- c. нэгдсэн сүлжээ болон төслийг тойрсон орон нутгийн суурин газруудын тэсвэртэй байдлыг сайжруулна,
- d. институцийн болон зохицуулах байгууллагын хүчин чадлыг сайжруулна.

Хөтөлбөрийн гол зорилго нь хүлэмжийн хий бага ялгаруулах хөгжлийн замналд улс орнуудыг хөтөлж, хүн амыг илүү хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангахад оршино.

#### 2.4 БОН-ийн эрсдэлийн удирдлагын арга барил

ССТБЭБС Хөтөлбөрийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын баримт бичгийн эрсдэлийн удирдлагын арга барилын зорилго нь:

- байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг санал болгосон төсөл тус бүрд үнэлэх;
- тэдгээр эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулж, арилгах зохих арга хэмжээг санал болгох;
- төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг хянах;
- төсөл хэрэгжиж дуустал оролцогч талуудтай тогтмол холбоотой ажиллах;
- урьдчилан тооцоолоогүй, гэнэтийн нөхцөл байдалд удирдан зохицуулахад туслах;
- төслүүд болон оролцогч талуудын байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад оршино.

ССТБЭБС Хөтөлбөрийн бүх төсөлд Байгаль орчин, нийгэм (БОН)-ийн эрсдэл, нөлөөллийг Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн бодлогын баримт бичиг (БОНБББ)-ийн хүрээнд үнэлж, зохицуулна. БОНБББ-т заасны дагуу ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд санал болгосон төсөл тус бүрд Банк Зээлдэгчтэй тохиролцож, БОН-ийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ) батална. Төслүүдийг тодорхой хугацаанд БОНС-уудад нийцүүлэхэд шаардлагатай материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг БОНАТ-д тусгаж өгнө. Үүнд БОН-ийн тодорхий төлөвлөгөөнүүд, төсөлд зориулж тусгайлан хөгжүүлэх бусад баримт бичгүүдийг батана. Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчийн эрх үүргийг худалдан авах ажиллагааны баримт бичиг, гэрээнүүдэд тусгаж өгөх зэргээр БОНАТ-д заасан арга хэмжээ, үйл ажиллагааг Зээлдэгч тал хэрэгжүүлэх тухай шаардлагыг төсөл тус бүрийн хууль ёсны гэрээнд тусгаж өгнө.

БОНАТ-д тогтоосон цаг хугацааны дарааллын дагуу Зээлдэгчийг БОНАТ-д заасан арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь Банкны зүгээс туслалцаа үзүүлж, төсөлд хяналт тавьж, тайлан боловсруулах ажлын хүрээнд БОНАТ-ний хэрэгжилтийн явцыг дүгнэнэ. Төсөл тус бүрд үнэлгээ хийхээс өмнө БОНАТ-ний төслийг аль болох эрт олон нийтэд мэдээлнэ.

Санал болгосон төсөлд орох өөрчлөлт, урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүсэхэд уян хатан байдлаар удирдан зохицуулах боломжтой байх процессыг БОНАТ-д тусгасан байна. Тухайн



өөрчлөлт эсвэл нөхцөл байдлыг хэрхэн удирдан зохицуулж, тайлагнах, цаашлаад БОНАТ болон Зээлдэгчийн удирдлагын баримт бичгүүдэд оруулах шаардлагатай өөрчлөлтийн талаар БОНАТ-д тусгана.

Үүний адилаар Зээлдэгч нь төслийн хүрээнд Талуудын оролцоог дэмжих төлөвлөгөө (ТОДТ) боловсруулах шаардлагатай.

### 3. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНИЙ БОН-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АРГА БАРИЛ

---

#### 3.1 БОН-ийн эрсдэл, нөлөөллийн магадлал

Банкны БОНБББ-тэй холбоотойгоор ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд зохих шалгалтыг хийхдээ тооцох БОН-ийн эрсдэл, нөлөөллийн магадлал нь тухайн төсөлд тусгайлан зориулагдсан байх бөгөөд дараах зүйлсийг багтаана:

- a. Байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл. Үүнд: (i) Дэлхийн Банк Группын Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын зөвлөмжүүдэд (БОЭААБЗ) тодорхойлсон; (ii) оршин суугчдын аюулгүй байдалтай холбоотой; (iii) уур амьсгалын өөрчлөлт болон бусад хил дамнансан, эсвэл дэлхийд түлгамдаж буй эрсдэлүүд, сөрөг нөлөөллүүд (iv) ан амьтдын байгальд амьдрах орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах, сэргээх ажилд аюул учруулах аливаа материалтай холбоотой; (v) экосистемийн үйлчилгээ, загас, мод зэрэг байгалийн амьд нөөц баялгийн хэрэглээтэй холбоотой эрсдэл, сөрөг нөлөөлөл;
- b. Нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөлөл. Үүнд: (i) хувийн, харилцааны, эсвэл улс хоорондын зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэлийг хөхиүлэн дэмжих замаар хүний аюулгүй байдалд учруулах эрсдэл; (ii) хувь хүн эсвэл тодорхой нөхцөл байдлын улмаас эмзэг бүлэгт тооцогдож буй хүмүүс, эмзэг бүлгийнхэнд тэгш бус нөлөөлөх эрсдэл; (iii) бүтээн байгуулалтын нөөц бололцоо, төслийн ашиг тусыг хүртээхдээ аливаа хувь хүн, бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуулах эрсдэл; (iv) хүчээр газар чөлөөлөх эсвэл газар ашиглалтыг хязгаарлахтай холбоотой эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөлөл; (v) орон нутгийн газар ашиглалтын хандлага, эзэмшлийн зохицуулалт, газрын хүртээмжтэй, олдоцтой байдал, хүнсний аюулгүй байдал, газрын үнэлгээ зэргээс үүдэх төслийн нөлөөлөл, цаашлаад газар өмчлөл, байгалийн нөөц баялагтай холбоотой маргаан, өрсөлдөөнөөс үүдэх эрсдэл зэрэг аливаа (хамаарал бүхий) эрсдэл, байгалийн нөөцийн эзэмшил, ашиглалттай холбоотой эрсдэл, нөлөөлөл; (vi) ажилчид, төслийн нөлөөлөлд өртөх оршин суугчдийн эрүүл ахуй, аюулгүй байдалд учруулах нөлөөлөл; (vii) соёлын өвийн эрсдэлүүд хамаарна.

#### 3.2 БОН-ийн стандартууд

Энэ хэсэгт БОН-ийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дагаж мөрдөх бодлогын баримт бичгийг тодорхойлов. Энэхүү бодлого тодорхойлох хэсэгт тухайн улсын хууль эрх зүй, бодлогууд болон БОНБББ-ийн нэг хэсэг болох Дэлхийн Банкны БОНС-ууд багтана. Тухайн улсын хууль эрх зүй, бодлогууд болон БОНБББ давхцал үүссэн тохиолдолд БОНБББ-ийг дагаж мөрдөнө.

ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд санал болгох төслүүдийг оролцуулаад Банкны дэмжлэгтэй төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж, үнэлэх асуудлаар Зээлдэгчид тавих шаардлагыг БОНС-ууд тодорхойлно. Ядуурлыг бууруулж, байгаль орчин, хүн амд ач тустай, тогтвортой байдлаар илүү хурдацтай хөгжиж цэцэглэх Зээлдэгчийн зорилгыг дэмжихэд эдгээр стандартууд нь голлон төвлөрсөн бөгөөд энэ хүрээнд байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг тодорхойлж, зохицуулахад анхаарсан болно. Стандартууд нь: (a) Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын олон улсын сайн туршлагыг нутагшуулахад нь Зээлдэгчдэд

дэмжлэг үзүүлнэ; (b) Үндэсний болон олон улсын байгаль орчин, нийгмийн шаардлагаа биелүүлэхэд нь Зээлдэгчдэд тусална; (c) ялгаварлан гадуурхлаас ангид, ил тод, хүртээмжтэй байдал, хариуцлага, засаглалыг сайжруулна; (d) талуудын оролцоог хангах замаар төслүүдийн тогтвортой хөгжлийн үр дүнг сайжруулна. БОНС-ууд нь биет болон техникийн тусалцаанд хоёуланд нь хүчин төгөлдөр үйлчилнэ.

Байгаль орчин, нийгмийн арван стандарт нь ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд санал болгосон төслүүд хэрэгжиж дуустал дараах байдлаар үйлчилнэ:

- a. **Байгаль орчин, нийгмийн стандарт 1 (БОНС1): Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ.** БОНС1 нь БОНС-уудад нийцсэн байгаль орчин, нийгмийн үр дүнг биелүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтээр Банкны дэмжлэг үзүүлж буй төслийн бүх үе шатанд байгаль орчин, нийгмийн нөлөөлөлтэй холбоотой үнэлгээ, зохицуулалт, хяналт хийх Зээлдэгчийн үүрэг хариуцлагыг тодорхойлно.
- b. **Байгаль орчин, нийгмийн стандарт 2 (БОНС2): Хөдөлмөрийн нөхцөл.** БОНС2-т ажилгүйдлийг бүүруулж, эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад ажлын байр, орлого бий болгох шаардлагатай гэж үзсэн. Зээлдэгч нь төслийн ажилчдад ижил тэгш хандаж, аюулгүй, эрүүл ажиллах орчноор хангах замаар ажилчин-удирдлага хоорондын эрүүл харилцааг дэмжиж, төслийн бүтээн байгуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой.
- c. **Байгаль орчин, нийгмийн стандарт 3 (БОНС3): Нөөцийн үр ашигтай байдал, орчны бохирдлоос зайлсхийх, зохицуулах ажлууд.** БОНС3-т эдийн засгийн үйл ажиллагаа, хотжилтын улмаас агаар, ус, хөрсний бохирдол үүсэж, хязгаарлагдмал нөөцийн хэрэглээний улмаас орон нутаг, бүс, дэлхийн түвшинд хүмүүс болон экосистем, байгаль орчинд аюул учирдаг гэж үзсэн. Агаар мандал дахь хүлэмжийн хийн бөөгнөрлийн одоогийн болон зорилтод түвшин нь бидний болон ирээдүй хойч үеийн эрүүл мэндэд аюул учруулах хэмжээнд байгаа юм. Нөгөө талаасаа нөөцийн үр ашигтай, үр дүнтэй хэрэглээг хангасан, орчны бохирдлоос сэргийлж, хүлэмжийн хийн ялгарлыг бага байлгаж, бүүруулах технологи, түршлэгүүд бий болж илүү хүртээмжтэй, олдоцтой болсоор байна.
- d. **Байгаль орчин, нийгмийн стандарт 4 (БОНС4): Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал.** БОНС4-т Төслийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, дэд бүтэц нь олон нийтэд эрсдэл, сөрөг нөлөөллийг нэмэгдүүлнэ гэж үзсэн. Нөгөөтээгүүр уур амьсгалын өөрчлөлтөд аль хэдийн өртсөн байгаа нийгмийн бүлэгт төслийн үйл ажиллагаа илүү гүн, эрчимтэй нөлөөлөхөөр байна.
- e. **Байгаль орчин, нийгмийн стандарт 5 (БОНС5): Газар чөлөөлөлт болон газар ашиглалт, хүчээр нүүлгэн шилжүүлэлтэд тавих хязгаарлалт.** БОНС5-д төсөлтэй холбоотой газар чөлөөлөх, газар ашиглалтыг хязгаарлах арга хэмжээнүүд оршин суугчид, хүн амд нөлөөлнө гэж үзсэн. Төсөлтэй холбоотой газар чөлөөлөх, газар ашиглалтыг хязгаарлах үйл ажиллагааны улмаас албан шахалтаар шилжин суурьших (нүүлгэн шилжүүлэлт, оршин суугаа газар, сууцаа алдах), бизнесээ нүүлгэх (газар, хөрөнгө, эсвэл хөрөнгийн хүртээмжээ алдах, орлогын эх үүсвэр, эсвэл амьжиргааны бусад боломжоо алдах), эсвэл аль алиныг нь хийх шаардлагатай болсон хүмүүс байх боломжтой. “Албадан нүүлгэх” гэдэгт эдгээр зүйлс багтана. Нөлөөлөлд өртөх хувь хүн, оршин суугчид газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалтыг эсэргүүцэх эрхгүйн улмаас нүүх шаардлагатай болбол албадан нүүлгэлт гэж үзнэ.

- f. **Байгаль орчин, нийгмийн стандарт 6 (БОНС6): Биологийн олон янз байдлыг хамгаалж, байгалийн амьд нөөцийг тогтвортой байдлаар удирдан зохицуулах.** БОНС6 нь биологийн олон янз байдлыг хадгалж, байгалийн амьд нөөцийг тогтвортой байдлаар удирдан зохицуулах нь тогтвортой хөгжлийн үндэс суурь гэж үзсэн. Биологийн олон янз байдал нь бүх төрлийн гарал үүсэлтэй амьд организмууд, тэр дундаа хуурай газрын, далайн болон бусад усны экосистемүүд, экологийн цогцолборын нэгэн хэсэг болж буй амьтдын хувьсах чадвараар тодорхойлогддог; үүнд ан амьтдын төрөл зүйл, тэдгээрийн хоорондын харьцаа, экосистемийн төрөлжсөн байдал багтана. Биологийн төрөлжсөн байдал нь ихэнхдээ хүмүүсийн үнэ цэнээр тодорхойлогдох экосистемийн ажиллагаанд тулгуурладаг. Иймээс биологийн олон янз байдлын нөлөөлөл нь ихэнхдээ экосистемийн ажиллагааны ашиг тус, хүртээлд сөргөөр нөлөөлдөг.
- g. **Байгаль орчин, нийгмийн стандарт 7 (БОНС7): Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкийн хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил.** БОНС7 нь нийгмийн тодорхой бүлэг, соёлын иргэншилд хамаарна. Энэ төрлийн хүн амын бүлгийн нэршил нь улс улсаасаа хамаарч өөрөөр байх бөгөөд ихэнхдээ үндэсний хэмжээнд хөндөгддөг. БОНС7 нь “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкийн хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” нэршлээр энэ төрлийн бүлгүүдийг тодорхойлж, улсаас нь хамаарч өөр нэршлээр тэмдэглэсэн байж болно. Энэ төрлийн бүлэгт “Өвөр Сахарын Африкийн хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил”, “нутгийн уугуул иргэд”, “уугуул иргэд”, “уулын овог аймгууд”, “эмзэг, цөөнх бүлэг”, “үндэсний цөөнх”, “нүүдэлчин овог аймгууд”, “үндэстэн ястан”, эсвэл “хэсэг бүлэг овог аймаг” багтана. БОНС7-д заасан шалгуурт нийцэж байгаа энэ төрлийн бүх бүлгийг БОНС7 хамруулна. Энэхүү БОНС-ийн зорилгыг биелүүлэх үүднээс “Өвөр Сахарын Африкийн хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” гэх тодорхойлолтод бусад бүх нэршлийг багтаасан болно.
- h. **Байгаль орчин, нийгмийн стандарт 8 (БОНС8): Соёлын өв.** БОНС8-д соёлын өв нь биет болон биет бус байдлаар өнгөрснөөс, одоо, ирээдүйд уламжлагдан үлддэг гэж үзсэн. Энэ нь хүн төрөлхтний хувьсан өөрчлөгдсөн үнэ цэн, итгэл үнэмшил, мэдлэг, уламжлалын илэрхийлэл болдог. Олон төрлийн шинж, байдлаар илэрдэг соёлын өв нь шинжлэх ухаан, түүхийн мэдээллийн үнэтэй эх сурвалж, цаашдын хөгжилд эдийн засаг, нийгмийн чухал хөрөнгө болоод зогсохгүй, хүн амыг тодорхойлох таних тэмдэг, өв заншлын салшгүй хэсэг болдог билээ. Төсөл хэрэгжиж дуусах хүртэл хэрэгжүүлэх соёлын өвийг хамгаалах арга хэмжээнүүдийг БОНС8-д багтаасан болно.
- i. **Байгаль орчин, нийгмийн стандарт 9 (БОНС9): Санхүүгийн зуучлал.** БОНС9-д эдийн засгийг хөгжүүлж, өсөлтийг тэтгэж, ядуурлыг бууруулахад дотоодын хөрөнгийн болон санхүүгийн зах зээл, санхүүжилтийн хүртээмж зэрэг нь чухал нөлөөтэй гэж үзсэн. Санхүүгийн салбарын тогтвортой байдал, цаашдын хөгжил, дотоодын хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн үүрэг оролцоог сайжруулах чиглэлд Банк дэмжлэг үзүүлэхээр эрмэлзэж байна. БОНС9 нь ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээний хөтөлбөрүүдтэй холбогдох шаардлагагүй болно.
- j. **Байгаль орчин, нийгмийн стандарт 10 (БОНС10): Талуудын оролцоог хангаж, олон нийтэд мэдээлэх ажил.** БОНС10-д Зээлдэгч болон төслийн оролцогч талуудын нээлттэй, ил тод харилцаа нь олон улсын сайн түршлагын чухал хэсэг хэмээн тодорхойлсон. Оролцогч талуудтай үр дүнтэй тулж ажилласнаар төслүүдийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулж, төслийг хүлээн зөвшөөрүүлэх боломжийг нэмэгдүүлж, төслийн загварыг гаргаж, амжилттай хэрэгжүүлэх чухал нөлөөтэй.

БОНС1 нь дараах зүйлсийн ач холбогдлыг тодорхойлов: (a) Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн хүрээний бодлогын баримт бичгийн хүрээнд төслийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх; (b) төслийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох байгаль орчин, нийгмийн нэгдсэн үнэлгээ хийх; (c) төсөлтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө, санал гомдлын талаарх мэдээллийг түгээх замаар олон нийтийн оролцоог үр дүнтэй нэмэгдүүлэх; (d) төсөл хэрэгжиж дуустал Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн зохицуулалт. Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг БОНС1-ийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд шийдвэрлэхийг Банк шаарддаг.

БОНС2-10-д анхаарал хандуулах шаардлагатай болж мэдэх байгаль орчин, нийгмийн тодорхой эрсдэл, нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхэд Зээлдэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон болно. Эдгээр стандартууд нь тэдгээр эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулж, арилгахад шаардагдах зорилтууд, шалгууруудыг тогтоох бөгөөд сөрөг нөлөөллийн магадлал өндөр хэвээр байгаа тохиолдолд тэдгээртэй холбоотой нөхөн төлбөр, эсвэл нөхөн олговрыг тогтооход чиглэх болно.

### **3.3 Төслүүдийн БОН-ийн эрсдэл, сөрөг нөлөөллийн магадлал, тэдгээрийг арилгах нь**

БОН-ийн хүрээнд тооцсон гол хүчин зүйлсийг доор тоймлов. Гэхдээ ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээний төслүүд тус бүрд БОН-ийн үнэлгээг төслийн бэлтгэл ажлын явцад хийнэ. Зарим төслүүд нь ГВт гаруй ХСЭЧ-ийг дамжуулахын тулд 500 кВ-ын дамжуулах шугамыг санхүүжүүлэхээр зорьж буй тул эдгээр төслүүдийг УАНС-ийн ангиллын дагуу Хөтөлбөрийн хүрээнд А ангилалд тооцож, Дэлхийн Банкны БОНБББ-ийн ангиллын дагуу өндөр, чухал ач холбогдолтойд тооцно.

#### **3.3.1 БОНС1**

Төслүүд нь сэргээгдэх эрчим хүчний суурилсан хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар байгаль орчинд шууд байдлаар ихээхэн үр өгөөж хүртээхээр байгаа. Эрчим хүчний нийт үйлдвэрлэлд эзлэх сэргээгдэх эрчим хүчний хувь хэмжээг нэмэгдүүлэх нь хүлэмжийн хийн ялгарал, агаар, усны бохирдол, усны нөөцийн хэрэглээ талаасаа улс орнуудад ихээхэн ач тустай. Төслүүдийн нөлөөгөөр барилга, бүтээн байгуулалтаас авахуулаад хэд хэдэн салбарт ажлын байр ихээр бий болж, хэрэгжилтийн дараах үйл ажиллагаа, арчилгааны (YAA) ажлуудын хэрэгцээ бий болж, улмаар цөөн тооны урт хугацааны ажлын байр бий болох магадлалтай. Сургалт, татаас зэргээр эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломж ихээр бий болно.

Зөв зохистой удирдан зохицуулахгүй бол нар/салхины паркийн дэд бүтцийн хөгжил доройтох, сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станцуудын бүтээн байгуулалт, үйл ажиллагаа нь хөрсний орчинд нөлөөлөх (хөрс доройтуулах), ан амьтны амьдрах орчинг сүйтгэх, цөлийн бүсэд үйл ажиллагаа явуулснаар усны хэрэглээг хэт нэмэх, фотовольтаик нарны цэнэг хураагуур, салхины түрбин, нарны цэнэг хураагуурын үйлдвэрлэлийн хорт бодис хаягдах, ажилчид, оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул, заналхийлэл учруулах зэрэг эрсдэл үүсэх магадлалтай. Гэсэн ч болзошгүй сөрөг нөлөөллүүдийн ихэнх нь цар хүрээ/ач холбогдлын хувьд багаас дунд зэрэгт тооцогдохоор, жасаж залруулах боломжтой, байгальд байрлаж буй тул урьдчилан сэргийлэхэд хялбар. Тухайлбал төслийн талбайг БОНБББ-ийн шалгуурын дагуу сонгож, үйл ажиллагааны явцад аюулгүй байдлыг нь хангах замаар эрсдэлийг арилгах боломжтой.

### 3.3.2 БОНС2

Төслийн ажилтнууд бүх төсөлд дайчлагдах төлөвтэй байгаа. Зээлдэгч нь төсөл тус бүрд боловсруулах Хөдөлмөрийн зохицуулалтын журамд заасны дагуу БОНС2-ийн шалгууруудыг биелүүлэх шаардлагатай. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал (ХЭААБ)-ын төлөвлөгөөнүүдийг Дэлхийн Банк Группийн БОЭМАБЗ Зөвлөмжүүдийн дагуу боловсруулах шаардлагатай.

Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний улмаас хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, маргаан зэрэг хэд хэдэн сөрөг үр дагавар бий болох боломжтой. Энэ нь дан ганц төслийн ажилтнууд хооронд бус нутгийн оршин суугчдад ч хамааралтай. Эдгээр эрсдэлийг БОН-ийн үнэлгээний дагуу тодорхойлж, ХЭААБ болон бусад БОН-ийн баримт бичгүүдийн хүрээнд зохицуулна. Холбогдох бүх арга хэмжээг тендерийн санал, гэрээний баримт бичгүүдэд тусгана.

Төслийн ажилтнуудад зориулсан гомдол шийдвэрлэх тусгай механизмыг төсөл тус бүрд байгуулах шаардлагатай. Энэхүү механизм нь төслийн Гомдол барагдуулах ерөнхий механизмаас тусдаа байх болно.

### 3.3.3 БОНС3

Санал болгож буй Хөтөлбөр нь БОНС3-ийн зорилтууд, шаардлагуудаас ихээхэн хамааралтай. Иймд эрчим хүчний үр ашигтай технологийн, шат дамжлага, эрчим хүч хэмнэх хөрөнгө оруулалт, сэргээгдэх эрчим хүчний шилдэг туршлага, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын үр өгөөж зэргийг төслийн загвар, БОН-ийн хэрэгслүүдэд тусгана.

Усны хомстол үүсэх магадлал, (үлирлын чанартай усны нөөц, хэд хэдэн эрэлттэй хуримтлагдсан нөлөө) гадагшлуулах бохирдол, хаягдлын хэмжээ, хаягдал материалын зохицуулалт, аюултай хог хаягдал, оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөлөл, нөөц баялгийн үр ашигтай байдал зэргийг төсөл тус бүрд үнэлнэ. Гэсэн ч эдгээр болзошгүй сөрөг нөлөөллийн ихэнх нь цар хүрээ/ач холбогдлын хувьд багаас дунд зэрэгт тооцогдохоор, засаж залруулах боломжтой, байгальд байрлаж буй тул шийдвэрлэхэд хялбар.

Нар, салхины паркийн бүтээн байгуулалтын үе шатанд барилгын ажлын улмаас тоосжилт үүсэх, яндангийн утаа зэргийн улмаас агаарын чанар доройтох гэх мэт байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл дагуулж болзошгүй. Эдгээр сөрөг нөлөөллийг хязгаарлахын тулд зохих үнэлгээ, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү БОНС-ийн шаардлагыг биелүүлэх зорилгоор барилга, үйл ажиллагааны шатны хог хаягдал, бохирдлын менежментийн төлөвлөгөө боловсруулна.

### 3.3.4 БОНС4

Төсөл тус бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ БОНС4-ийн шаардлагыг биелүүлнэ. Нар/салхины цахилгаан станцын барилга, үйл ажиллагааны шатанд хэвийн үеийн болон гэнэтийн ослын эрсдэл учирч болох ч одоогоор эрчим хүчний бусад үйлдвэрлэлийн (жишээ нь усан цахилгаан станц) явцад

ийм осол, аюул гараагүй байна. Барилгын тоног төхөөрөмж, холбогдох тээврийн үйл ажиллагаанаас үүдэлтэй чанга дуу чимээ ялгаруулж, оршин суугчдад тавгүй байдал учруулах зэрэг сөрөг нөлөө бий болох магадлалтай. Эдгээр нөлөөллүүдийг хязгаарлахын тулд зохих үнэлгээ, зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Гэрээ гүйцэтгэгч нь төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад Замын хөдөлгөөний зохицуулалтын төлөвлөгөө боловсруулж, олон нийтэд учруулах саад бэрхшээлийг аль болох бага байлгах хариуцлага хүлээнэ.

Эдгээр эрсдэлээс гадна олон нийтийн эрүүл мэндэд учруулах бусад сөрөг нөлөө болон хөндлөнгийн зохицуулалт шаардлагатай зүйлсийг БОНС4-ийн хүрээний бие даасан төлөвлөгөө, аль эсвэл төслийн БОНМТ-ний нэг хэсэг болгон шийдвэрлэх боломжтой.

### **3.3.5 БОНС5**

Нар, салхины паркт шаардлагатай газар хангалттай бий. Аливаа газар чөлөөлөлт, эсвэл газар ашиглалтын хязгаарлалтаас үүдэх нөхөн төлбөрийн зардлыг бага байлгаж, бууруулж, нөхөн төлөх зорилгоор БОНС5-ын шалгуурын дагуу үнэлж, зохицуулна. Ингэхдээ БОНС5-ын зохих шалгалт, төлөвлөгөөнд суурилна.

Нүүлгэн шилжүүлэх бодлогын баримт бичгийн жишиг загварыг Хавсралт 5-д оруулав. Зээлдэгч нь БОНС5-ын шаардлагын дагуу төсөлд зориулсан нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хоёрын нэгийг эсвэл хоёуланг нь Банкны шаардлагад нийцсэн байдлаар боловсруулах үүрэгтэй.

### **3.3.6 БОНС6**

Санал болгож буй нар/салхины төслүүдийг шаардлагын дагуу боловсруулж, зөв зохистой байрлалд хэрэгжүүлээгүй тохиолдолд алдагдал учрах, хөрсний доройтол бий болох, эсвэл ан амьтдын амьдрах зохистой орчинг хөндөх, биологийн олон янз байдал, байгалийн амьд нөөц баялаг зэрэгт сөрөг нөлөөлөл учрах эрсдэлтэй. Энэ төрлийн төслүүдийн байгалийн амьдрах орчин, хуурай газрын, далайн экосистемүүд, амьтдын төрөл зүйлүүдэд учруулах нөлөөллийг үнэлж, зохицуулахад анхаарал хандуулах шаардлагатай. БОНС6-ийн шаардлагуудын бүрэн хангах арга хэмжээнүүдийг төсөл тус бүрд тусгаж өгнө.

### **3.3.7 БОНС7**

Төслийн талбайнуудад оршин суудаг, ихээр хамааралтай уугуул иргэд (УИ)-ийг тогтоож, тус улсын эрх баригчидтай зөвшилцөж, Банкаар баталгаажуулна. Баталгаажсан тохиолдолд БОНС7-ийн зорилтууд, шалгуурууд, уугуул иргэдэд зориулсан төлөвлөгөө, тухайн улсын нөхцөл байдал, төслийн агуулгыг тооцож гаргасан төлөвлөгөөнүүд зэрэг БОН-ийн бусад баримт бичгүүдийг боловсруулж, БОНС7-д заасан Үнэгүй, урьдчилсан, мэдээлэлтэй, зөвшөөрөгдсөн нөхцөлүүдийг төслийн загварт нэгтгэнэ.

### **3.3.8 БОНС8**

Төслийн талбайн зураглалыг гаргаж, соёлын биет болон биет бус өвд учрах нөлөөллийн магадлалыг төслийн хүрээнд үнэлнэ.

Төслийн талбайг сонгохдоо соёлын өвийг тооцож, төсөл тус бүрд БОНС8-ын хэрэгжилтэд үнэлгээ хийнэ. Барилгын ажлын талбайд урьдаас мэдэгдэж буй соёлын өв байхгүй тохиолдолд БОН-ийн хэрэгсэлд гэнэтийн олдворын талаарх үйл явцыг багтаана.

### 3.3.9 БОНС9

Санхүүгийн зуучлагчтай төсөл хэрэгжих төлөвгүй байгаа.

### 3.3.10 БОНС10

Оролцогч тал хэмээх ойлголтод төслийн нөлөөлөлд өртсөн оршин суугчид, хувь хүмүүс багтах бөгөөд тэдний томилсон албан болон албан бус төлөөлөл, төрийн ба орон нутгийн захиргаа, улс төрчид, шашны ба олон нийтийн байгууллагууд, ашиг сонирхол нийлж буй иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний салбарынхан, бизнесүүд мөн хамаарна. Төслийн нөлөөлөлд өртсөн талуудыг (хувь хүн эсвэл бүлэг хүмүүс) тодорхойлох ажилд тодорхой шалтгаантай, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийнхэн; жишээ нь төслийн улмаас сөрөг нөлөөлөлд өртөх магадлал илүү өндөр, төслийн ашиг тусыг ашиглах боломж нь бусдаас хязгаарлагдмал хүмүүсийг мөн хамруулна.

Төслийн нөлөөлөлд өртөх, төслийг сонирхсон талууд хооронд ил тод, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор төсөл тус бүрд ТОДТ-ийг боловсруулна. Талуудын оролцоог дэмжих арга хэмжээ, хэлэлцүүлгүүдийг төслийн тодорхой шатанд явуулна. Төслийн боловсруулалтын шатанд Төслийн загвар, нөлөөллийг хэлэлцэх уулзалтууд болон олон талт хэлэлцүүлгүүд үүнд багтана. ТОДТ болон бусад БОН-ийн баримт бичгүүд нь БОНС10-ийн хүрээнд явагдах хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх ажлуудыг хамрах бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад тогтмол шинэчлэх баримт бичгүүд юм.



## 4. ТӨСЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕИЙН БОН-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

---

Арван улсад хэрэгжих ССТБЭБС Хөтөлбөр нь зарим улсад төслийн шаардлага, хэрэгцээг тодорхойлох шатандаа яваа бол зарим улсад төслийн үзэл баримтлалыг тодорхойлж эхлээд байгаа. Өөрөөр хэлбэл улс улсад хөгжүүлэлтийн өөр өөр үе шатанд явж буй юм. Банкны Байгаль орчин, нийгмийн бодлого, Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн бодлогын хүрээнд төсөл тус бүрд хийгдэх БОН-ийн хянан шалгалтын гол үе шатуудыг доор танилцуулав.

### 4.1 Төслийн бэлтгэл ажил

Банкны зүгээс Хөтөлбөрийн хүрээнд Хөрөнгө оруулалтын санхүүжилтээр дамжуулан санал болгож буй төсөл бүрд байгаль орчин, нийгмийн шалгалт явуулдаг. Ингэхдээ өөрсдийн бодлого, журмыг баримталдаг. Санал болгож буй төсөлд дэмжлэг үзүүлэх эсэх, хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд төслийн үнэлгээ, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлтийн явцад байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох Банкны шийдвэр гаргах процессод дэмжлэг үзүүлэх нь Байгаль орчин, нийгмийн шалгалтын гол зорилго болно.

Банкны байгаль орчин, нийгмийн шалгалт нь төслийн шинж чанар, хамрах хүрээнд нийцсэн байх бөгөөд байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн түвшинтэй уялдана. Ингэхдээ нөлөөллийг бууруулах шатлалыг тооцно. Улмаар БОНС-уудын шаардлага хангагдсан, хэрэгжүүлж болох эсэхийг шалгалтаар үнэлнэ.

Банкны шалгалтын хариуцлагад дараах зүйл зохих хэмжээгээр хамаарна: (а) төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөлтэй холбоотой Зээлдэгчийн ирүүлсэн мэдээллийн дүн шинжилгээ хийх, шалгалтыг явуулахад Банканд саад болох аливаа зөрүү байгаа үед нэмэлт, холбогдолтой мэдээлэл хүсэх; (б) Зээлдэгчийг байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг БОНС-ийн хүрээнд шийдвэрлэх шаталсан арга хэмжээг хөгжүүлэхэд нь дэмжлэг болж, зөвлөх. Банк БОНТБББ-ийн хүрээнд байгаль орчин, нийгмийн шалгалт явуулах үүргээ биелүүлэхийн тулд Зээлдэгч нь холбогдох бүх мэдээллийг Банканд өгөх үүрэг хүлээнэ.

Төслийн үзэл баримтлалыг тодорхойлох шатанд Байгаль орчин, нийгмийн дүгнэлтийн тойм (БОНДТ) боловсруулж, олон нийтэд мэдээлэх замаар санал болгож буй төслийн төрөл, цар хүрээ, цаашид хийгдэх байгаль орчин нийгмийн үнэлгээний төрөл, цаг хугацааны дараал зэргийг олон нийтэд мэдээлнэ. Үүнд урьдчилан тогтоосон оролцогч талуудын талаарх мэдээлэл, тэдэнтэй холбогдох арга замыг багтаана. БОНДТ-ын үзэл баримтлалыг тодорхойлох шатанд Банк бүх төслийг БОНБББ-ийн дөрвөн ангилалд хувааж, ангилна:

- Өндөр,
- Ач холбогдолтой,
- Дундаж,
- Бага.

Эрсдэлийг зохих түвшинд нь ангилахдаа төслийн төрөл, байршил, эмзэг байдал, цар хүрээ зэрэг холбогдох асуудлууд; байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийн үндэслэл, давтамж; байгаль орчин, нийгмийн нөлөөллийг БОНС-ийн хүрээнд зохицуулах зорилгоор Зээлдэгчийн хүчин

чадал, үүрэг, амлалт (төслийн хэрэгжилт хариуцсан бусад этгээдүүд үүнд багтана). Тухайн төсөл, төслийн хөгжүүлэлтээс хамаарч байгаль орчин, нийгмийн эрсдэлийг арилгах арга хэмжээ, үр дагавар нь өөр төрлийн эрсдэл дагуулах магадлалтай.

Төслийн эрсдэлийн ангиллыг Банк тогтмол дүгнэнэ. Энэ нь хэрэгжилтийн явцад тогтмол хийгдэх бөгөөд төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн магадлалд нийцүүлэх үүднээс шаардлагатай үед эрсдэлийн ангиллыг өөрчилнө. Ангилалд оруулсан бүх өөрчлөлтийг Банкны веб хуудсаар мэдээлнэ.

Төсөл тус бүрд үнэлгээ хийхээс өмнө тухайн төслийн үнэлгээний шатны БОНДТ-ыг боловсруулж, төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээтэй холбоотой Зээлдэгчийн ил болгосон бүх баримт бичгийн төслийн хамтаар олон нийтэд мэдээлнэ. Баримт бичгүүдийн төслүүдэд төслийн байгаль орчин, нийгмийн гол эрсдэлүүд, нөлөөллүүдийг тодорхойлж, хангалттай хэмжээнд тооцно. Мөн ижил төрлийн эрсдэл, нөлөөллийн талаар холбогдох үнэн зөв мэдээллийг агуулсан байна. Үүнд мөн гол үр дүн, эрсдэлийг арилгахаар санал болгож буй арга хэмжээг тоймлоно. Баримт бичгийн төслийн тодорхой хэсгийг нь дараа боловсруулах шаардлагатай бол баримт бичгийн хүрээнд хийгдэх арга хэмжээний талаар оруулсан байна. Тухайлбал хүлээгдэж буй, БОНАТ-д нэмэгдэх аливаа судалгаа, үнэлгээ дүгнэлтүүд. Зээлдэгч нь үнэлгээнд зориулж төсөл тус бүрд БОНАТ, Талуудын оролцоог дэмжих төлөвлөгөө (ТОДТ) боловсруулж, олон нийтэд мэдээлнэ. Хүлээн зөвшөөрсөн арга хэмжээ, үйл ажиллагааны хөгжүүлэлт, хэрэгжүүлэлтэд шаардлагатай олон төрлийн менежментийн баримт бичгүүдийг БОНАТ-д тодорхойлно. Эдгээр баримт бичигт байгаль орчин, нийгмийн удирдлагын холбогдох төлөвлөгөөнүүд, байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны бодлогууд, үйл ажиллагааны гарын авлага, удирдлагын систем, журам, түршлага, капиталын хөрөнгө оруулалт багтана. БОНАТ-д заасны дагуу төсөл хэрэгжиж дуустал холбогдох хууль, тогтоомж, БОНС-уудын шаардлагуудыг биелүүлэх зорилгоор менежментийн бүх баримт бичигт эрсдэл бууруулах шатлал, арга хэмжээнүүдийг тусгана. Хоёр баримт бичгийн жишиг загварыг хавсралтаар оруулав. БОН-ийн бэлэн болсон бусад баримт бичгүүдийг мөн төслийн үнэлгээ хийхээс өмнө олон нийтэд мэдээлнэ.

#### 4.2 Төслийн хэрэгжилт

Банк нь БОНАТ зэрэг хууль ёсны гэрээний шаардлагын дагуу төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд хяналт тавьж, төслийн загвар, нөхцөл байдлаас шалтгаалж орсон өөрчлөлт зэрэг БОНАТ-ын аилваа өөрчлөлтөд дүгнэлт хийнэ. Банкнаас явуулах байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн хяналтын хамрах хүрээ, төрлийг тухайн төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн магадлалтай үялдүүлна. Банкны бодлого, Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн журамд заасны дагуу төслүүдэд Банк тогтмол хяналт тавина. Банкнаас төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлтэй холбоотой хэрэгжилтийн дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнд БОНАТ зэрэг хууль ёсны гэрээнд заасан шаардлагын дагуу Зээлдэгчийн боловсруулсан төслийн комплаенсийн хяналтын тайлан багтана.

## 5. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, ТАЛУУДЫН ОРОЛЦОГ ХАНГАХ, САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ

---

### 5.1 Талуудын оролцоог хангаж, олон нийтэд мэдээлэх ажил

Холбогдох мэдээллийг нийт хүн ам, нийгмийн тодорхой бүлэгт хүртээмжтэй үг хэллэг, хэлбэрээр түгээж, төслүүдийн улмаас тэгш бус, хоорондоо адилгүй нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын бүлэг, эсвэл аливаа нэмэлт мэдээлэл шаардлагатай болох (тухайлбал хөгжлийн бэрхшээл, бичиг үсгийн мэдлэг, хүйс, хэл, хүртээмжтэй байдал зэргээс хамаарч) хүмүүсийн тодорхой шаардлагыг тооцно. Төслийн эрсдэл, нөлөөллийг ойлгох боломжийг оролцогч талуудад олгох зорилгоор төслийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээж, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарах магадлалтай эрсдэл, нөлөөллийг онцлон харуулж, тэдгээрээс урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж, арилгах төрөл бүрийн арга хэмжээнүүдийг үүнд багтааж, тайлбарлана.

Төслийн нөлөөлөлд өртөх оршин суугчид, хувь хүмүүс, тэдний албан ёсны болон албан бус төлөөлөл, төрийн ба орон нутгийн захиргаа, улс төрчид, шашны ба олон нийтийн байгууллагууд, ашиг сонирхол нийлэх тодорхой иргэний нийгмийн байгууллагууд, судалгаа, шинжилгээний салбарынхан, бизнесүүд төсөлд оролцох боломжтой. Төслийн нөлөөлөлд өртөх бүлэгт (хувь хүн, бүлэг) тодорхой шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж, эмзэг бүлэгт хамрагдсан; тухайлбал төслийн улмаас сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай, эсвэл төслөөс хүртэх өгөөж нь бусдаас хязгаарлагдмал хүмүүс багтаж болно. Энэ төрлийн хувь хүн/нийгмийн бүлгийнхэн ихэнхдээ хэлэлцүүлэгт хамрагдаж, бүрэн оролцож чадалгүй өнгөрөх хандлагатай байдаг учир тодорхой арга хэмжээ, тусламж хэрэг болох магадлалтай. Төслийн талбайн оршин суугчдын оролцоог өргөн хүрээнд, хүртээмжтэй байдлаар баттай хангах нь чухал. Ингэхдээ зорилтод улсуудын шийдвэр гаргах явцад ихэнхдээ орхигддог эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд голчлон анхаарна. Оролцоог дэмжих энэ төрлийн арга хэмжээг соёлын талаас мэдрэмжтэй, илүү ач холбогдолтой байдлаар хэрэгжүүлж, БОНС7-д заасны дагуу уугуул иргэдэд сөрөг нөлөөлөл учирсан тохиолдолд Үнэгүй, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрсөн (ҮУМБЗ) нөхцөлөөр шийдвэрлэнэ. Оршин суугчдад төслийн үр өгөөжөөс хүртэх сонголт олгож, эмзэг бүлгийнхэнд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Төсөл тус бүрд оролцогч талуудыг тодорхойлох дүн шинжилгээ хийнэ. Энэхүү дүн шинжилгээний түвшинг тогтоохдоо тэдгээрт учрах эрсдэл, нөлөөллийн магадлалын түвшинг тооцно. Оролцогч талуудын дүн шинжилгээг төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд хийнэ.

Урьдчилсан үнэлгээнд үндэслэсэн ССТБЭБС-ийн төслүүдийн нөлөөлөлд өртөх оролцогч талууд нь дараах байдлаар тодорхойлогдох бөгөөд талуудын өргөн хүрээний ерөнхий тодорхойлолтыг дээр дурдсан болно:

- a. Төслөөс шууд болон шууд бус байдлаар өгөөж хүртэх хүмүүс, нийгмийн бүлэг, байгууллагууд. Энэхүү ашиг хүртэх талууд нь: (i) эрчим хүч дамжуулах шугам, хүн амыг цахилгаанд холбох төслүүдийн боломжит шинэ хэрэглэгчид (уугуул иргэдийн бүлэг үүнд багтана), (ii) төсөлд ажиллах боломжтой хүмүүс;

- b. Сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын бүлэгт: (i) нөлөөлөлд өртөх газар эзэмшигч/оршин суугчид, (ii) уугуул иргэд хамаарна. Орон нутгийн иргэд, оршин суугчдыг оролцоог дэмжих ажил нь оршин суугчдын төлөөллөөс (тосгоны удирдлага, овог аймгийн тэргүүн, шашны тэргүүн, орон нутгийн захиргааны төлөөллүүд, иргэний нийгмийн төлөөлөл) ихээхэн хамаарахаар байгаа үед тухайн хүмүүсийг тодорхойлоход хүчин чармайлт гаргах шаардлагатай болох бөгөөд энэ нь тухайн иргэд, оршин суугчдын үзэл бодлыг төлөөлж, зөв зохистой харилцахад хялбар болгоно.
- c. Ашиг сонирхлын бүлэгт: (i) орон нутгийн захиргааны агентлагууд, (ii) төрийн бус байгууллагууд/ТББ, Иргэний нийгмийн байгууллагууд/ИНБ, ХСЭЧ дээр ажиллаж буй бүтээн байгуулалтын бусад институцууд, (iii) уугуул иргэдийг төлөөлөх байгууллагууд, (iv) хувийн хэвшлийнхэн хамрагдана.
- d. Дэд төслүүдийн хэрэгжилтэд нөлөөлөх, шийдвэр гаргах институц, агентлагууд гэх тодорхойлолт нь хэрэгжүүлэгч агентлагууд болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг хариуцсан эрх бүхий агентлагуудыг хамарна. Үүнд: (i) засгийн газрын агентлагууд, (ii) орон нутгийн захиргаа хамаарна. Талуудын оролцооны түвшин нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага дахь хариуцлага, үүрэг оролцоотой уялдана.

## 5.2 БОН-ийн гомдол шийдвэрлэх механизм

ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд санал болгож буй төсөл тус бүрд тусгайлан боловсруулах төслийн хүрээний ТОДТ-ийн хүрээнд Гомдол шийдвэрлэх механизм (ГШМ)-ийг боловсруулж, хэрэгжүүлэгч агентлагт хүлээлгэж, хэрэгжүүлэлтийг нь хариуцуулах бөгөөд төслийн нөлөөлөлд өртсөн оршин суугчид, төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртсөн, төсөлд оролцох сонирхолтой хүмүүсийн санал, гомдлыг шийдвэрлэхэд хялбар болгоход төвлөрнө. ГШМ-ийн ийн ерөнхий зорилго нь (a) ашиг хүртэх талуудын хариуцлагыг бэхжүүлэх, (b) төслийн оролцогч талуудад төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол илэрхийлэх, мэдүүлэх арга хэрэгслийг бий болгох юм. ГШМ нь хүртээмжтэй, найдвартай механизм байх ёстой бөгөөд асуудлуудыг цаг алдалгүй, харилцан уялдаа холбоотой байдлаар тодорхойлж, шийдвэрлэх боломж олгогдох хэрэгтэй. Ингэхдээ одоо байгаа албан болон албан бус гомдол шийдвэрлэх механизмыг ашиглана. Механизм нь дан ганц санал гомдол хүлээн авч, бүртгэлжүүлэх бус, асуудлыг шийдвэрлэж, ил тод, хариуцлагатай байдлыг хангахын тулд шийдвэрлэлтийн явцын талаар эргэн мэдээлж, холбоотой ажиллах зорилготой болно.

ГШМ-д дараах зүйлс багтаж болно:

- a. Хэрэглэгчид олон төрлийн арга замаар санал, гомдлоо илэрхийлэх боломжтой байх хэрэгтэй. Тухайлбал биечлэн хүргүүлэх, утсаар, мессежээр, шуудан, и-мэйл, эсвэл веб хуудас г.м;
- b. Санал, гомдлыг бичгээр бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- c. Гаргасан санал хүсэлтийг хүлээн авч, хариу өгч, шийдвэрлэх хугацааг тодорхой болгосон журмыг олон нийтэд нээлттэй мэдээлнэ;
- d. Санал, гомдлын журам, захиргааны бүтэц, шийдвэр гаргагчдын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангана;
- e. Гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал нь хангалтгүй гэж үзсэн тохиолдолд шүүхэд гомдол гаргах үйл явцыг тусгана;
- f. Санал болгосон шийдлийг гомдол мэдүүлэгч хангалтгүй гэж үзсэн тохиолдолд цааш зуучилж өгөх.

### 5.3 Дэлхийн Банкны гомдол шийдвэрлэх үйлчилгээ

Дэлхийн Банкны дэмжлэгтэй төслийн (ССТБЭБС Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүд үүнд хамаарна) улмаас сөрөг нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй оршин суугчид, хувь хүмүүс төслийн түвшний гомдол шийдвэрлэх механизм эсвэл ДБ-ны Гомдол шийдвэрлэх үйлчилгээ (ГШҮ)-нд гомдол мэдүүлэх боломжтой. Төсөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор ГШҮ нь гомдлыг тухай бүрд нь цаг алдалгүй хүлээн авч, дүгнэлт хийдэг. ДБ өөрийн бодлого, журмаа мөрдөөгүйн улмаас хохирол учирсан эсэх, учирч болох эсэхийг тодорхойлдог ДБ-ний бие даасан Хяналт, шалгалтын зөвлөлд төслийн нөлөөлөлд өртсөн оршин суугчид, хувь хүмүүс гомдол гаргах боломжтой. Тухайн асуудлаар Дэлхийн Банкнад шууд хандсаны дараа хэзээ ч гомдол мэдүүлж болох бөгөөд Банкны удирдлагын багт хариу өгөх боломж олгогдоно. Дэлхийн Банкны ГШҮ-д хэрхэн гомдол гаргах талаарх мэдээлэл авахын тулд <http://www.worldbank.org/en/projects-operations/products-and-services/grievance-redress-service> хаягаар холбогдоно уу. Дэлхийн Банкны хяналт, шалгалтын зөвлөлд гомдол өргөн барих талаар мэдээлэл авахыг хүсвэл [www.inspectionpanel.org](http://www.inspectionpanel.org) хаягт холбогдоно уу.

## ХАВСРАЛТ 1: БОН-ИЙН АМЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР

---

[Зээлдэгчийн нэр/Төсөл хэрэгжүүлэгч этгээд]

[Төслийн нэр, дугаар]

[Төсөл/Хэлэлцсэн/Шинэчилсэн]

### БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АМЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНАТ)

[Огноо]

- [Зээлдэгчийн нэр] нь дараах яамд/агентлагууд/нэгжүүдтэй хамтран [нэр] Төслийг (Төсөл) [хэрэгжүүлнэ] [хэрэгжүүлж байгаа]: [Нэр] [оролцож буй бусад яамд/агентлагууд/нэгжүүдийг нэмнэ]. [Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк/Олон улсын хөгжлийн ассоциаци], (цаашид [Банк/Ассоциаци] гэх, Төсөлд зориулж санхүүжилт [олгохоор зөвшөөрсөн] [олгож байгаа] болно.
- [Зээлдэгчийн нэр] нь Төслийг Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-уудад нийцүүлэх зорилгоор материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. Энэхүү Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ)-нд материаллаг арга хэмжээ, үйл ажиллагаа, тодорхой баримт бичиг ба төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжих хугацааг тодорхойлов.
- [Зээлдэгчийн нэр] нь мөн БОНБББ-д тусгасан шаардлага, БОНАТ-д дурдсан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (БОНМТ), Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (НШТ), Нутгийн уугуул иргэдийн төлөвлөгөө (НУИТ) зэрэг БОН-ийн бусад баримт бичгүүдийн заалт, БОН-ийн баримт бичгүүдэд тусгасан огноог дагаж мөрдөнө.
- [Зээлдэгчийн нэр] нь дээр буюу энэ баримт бичгийн нэгдүгээр заалтад дурдсан яамд, агентлагуудын аливаа арга хэмжээ, үйл ажиллагаанаас үл хамааран БОНАТ-ний бүх шаардлагыг даган биелүүлэх үүрэгтэй.
- БОНАТ-д заасны дагуу, мөн хууль ёсны гэрээний нөхцөлийн дагуу БОНАТ-д тусгасан материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар [Зээлдэгчийн нэр]-аар/ээр дамжуулан [Банк/Ассоциаци]-д тайлагнах бөгөөд Төслийн хэрэгжилтийн явцад материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд [Банк/Ассоциаци] хяналт тавьж, үнэлгээ хийнэ.
- Төслийн аливаа өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал, эсвэл БОНАТ-ний хүрээнд хэрэгжүүлсэн Төслийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд энэхүү БОНАТ-ийг [Банк/Ассоциаци] болон [Зээлдэгчийн нэр] хооронд харилцан тохиролцсоны дагуу Төслийн хэрэгжилтийн явцад цаг тухайд нь шинэчилж болно. Ийм нөхцөлд тухайн өөрчлөлтийг [Зээлдэгчийн нэр/эсвэл төлөөлөл(үүд)] [Банк/Ассоциаци] харилцан хүлээн зөвшөөрч, тухайн өөрчлөлтийг БОНАТ-д нэмж оруулна. БОНАТ-д өөрчлөлт оруулах гэрээг [Банк/Ассоциаци], [Зээлдэгчийн нэр/эсвэл төлөөлөл(үүд)]-ын/ийн харилцан гарын үсгээр баталгаажуулсан албан бичгээр баримтжуулна. [Зээлдэгчийн нэр/эсвэл төлөөлөл(үүд)] БОНАТ-д орсон өөрчлөлтийг тухай бүрд нь олон нийтэд мэдээлнэ.

7. Төслийн явцад Төсөл өөрчлөгдсөн, урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн, эсвэл Төслийн гүйцэтгэл нь болзошгүй эрсдэл, нөлөөлөлд өөрчлөлт оруулсан тохиолдолд [Зээлдэгчийн нэр] нь тухайн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх үйл ажиллагаа, арга хэмжээг [байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын нөлөөлөл, хөдөлмөрийн үрсгал, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг Төсөлтэй холбоотой тодорхой эрсдэл, нөлөөллүүд үүнд багтана] хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилт гаргана.

МАТЕРИАЛЛАГ АРГА ХЭМЖЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА		ЦАГ ХУГАЦАА	ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА
<b>ХЯНАЛТ, ТАЙЛАН</b>			
А	<p><b>ТОГТМОЛ ТАЙЛАГНАХ</b></p> <p>[Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал (БОНЭМАБ)-ын гүйцэтгэлд хяналт тавьж, Дэлхийн Банканд тайлагнах шаардлагатай. Үүнийгээ БОНАТ-д тусгана. Доорх жишээнээс харна уу]</p> <p>Төслийн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал [БОНЭМАБ]-ын гүйцэтгэлийн тайланг боловсруулж, [Банк/Ассоциац]-д тогтмол хүргүүлнэ. Үүнд БОНАТ-ний хэрэгжилт, БОНАТ-ний хүрээнд шаардагдах БОН-ийн бэлтгэл ажил, хэрэгжилтийн баримт бичгүүд, оролцогч талуудын оролцоог дэмжих үйл ажиллагаанууд, санал, гомдол хүлээн авах механизмийн үйл ажиллагаа багтах ч тэдгээрээр хязгаарлагдахгүй.</p>	<p>[Төслийн хэрэгжилтийн явцад тайлагнах давтамж. Улирал, зургаан сар тутам, жил бүр гэх мэт]</p>	
В	<p><b>ОСОЛ, АВААР</b></p> <p>[Осол, аваар гарсан тохиолдолд тухай бүрд нь мэдэгдэх нь БОНС1-ийн нэг чухал шаардлага. Доорх жишээнээс харна уу.]</p> <p>[үйл ажиллагааны төрлөөс хамаарсан осол, аваарын жишээ] [зэрэг] Төсөлтэй холбоотойгоор байгаль орчин, суурин газар, олон</p>	<p>[Мэдээлэх хугацааг тодорхойлох. Тухайлбал осол гарсан гэдгийг мэдсэнээс хойш 48 цагийн дотор] мэдээлж, ослын дараах тайлан боловсруулах хугацааг Банк тодорхойлно. Тухайлбал Банк/Ассоциацийн хүсэлтийн дагуу ослын талаар тайланг Банк/Ассоциациад хүлээн зөвшөөрөгдөх хугацаанд хүргүүлнэ.</p>	



	<p>нийт, ажилчдад сөргөөр нөлөөлсөн, нөлөөлөх магадлалтай осол, аваар гарсан тохиолдолд [Банк/Ассоциац]-д нэн даруй мэдэгдэнэ. Ингэхдээ тухайн ослын талаар хангалттай нарийн мэдээлэл өгч, авч хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа яаралтай арга хэмжээний талаар мэдээлж, туслан гүйцэтгэгч, хяналтын нэгжүүдээс ирүүлсэн холбогдох мэдээллийг хавсаргана. Мөн [Банк/Ассоциац]-д ирүүлсэн хүсэлтийн дагуу ослын талаар тайлан боловсруулж, ижил төрлийн нөхцөл байдал дахин үүсгэхгүй байх урьдчилан сэргийлэх арга хэмжээ санал болгоно.</p>		
С	<p><b>ГҮЙЦЭТГЭГЧИЙН САР ТУТМЫН ТАЙЛАН</b></p> <p>[Банкны худалдан авах ажиллагааны стандартын баримт бичгүүдийг ашиглан гүйцэтгэх гэрээт ажлуудын хүрээнд гүйцэтгэгчид сар тутмын хяналтын тайланг Төслийн хэрэгжилтийн нэгжид хүргүүлэх шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд тухайн сар тутмын тайланг Зээлдэгчийн хүсэлтээр Банканд хүргүүлэх ажлыг ажлын хэсгүүд нэмэх боломжтой]</p>		
<p><b>БОНС 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ, НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ</b></p>			
1.1	<p><b>БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ</b></p> <p>[Дор харуулсан жишээний дагуу Төсөл дээр ажиллах нэмэлт ажилтан томилох/хөлслөх шаардлагатай эсэхийг тодорхойлно уу].</p>	<p><i>[байгууллагын бүтэц/ажилтнуудыг хэзээнээс ажиллуулах шаардлагатайг тодорхойлно, жишээ нь Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор хоёр (2) нэмэлт мэргэжилтэн томилно. Мэргэжилтнүүдийг оруулаад байгууллагын бүтцийг Төсөл хэрэгжиж дуустал хариуцаж ажиллана.]</i></p>	

	<p>[биологийн олон янз байдлын мэргэжилтэн, эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтэн гэх мэт байгууллагын бүтцийн нэг хэсэг болох БОНЭМАБ-ийн менежментийн тодорхой албан тушаалуудыг зохих газартай нь тодорхойлно уу] [зэрэг] БОН-ийн эрсдэлийн удирдлагыг дэмжиж ажиллах чадварлаг ажиллах хүчин, хүний нөөц бүхий байгууллагын бүтэц бий болгож, хариуцаж ажиллана.</p>		
1.2	<p><b>БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ</b></p> <p>[Зээлдэгчид байгаль орчин, нийгмийн үнэлгээ (БОНУ) хийх шаардлагатай бөгөөд БОНС1 Хавсралт 1-ийн 5 дугаар цогцолборт заасны дагуу үүнд олон төрлийн арга барил, баримт бичиг хамруулж болно. Хэрэв БОНУ-ийг шинэчлэх шаардлагатай, төслийн шатандаа яваа бол тухайн өөрчлөлтийг оруулах талаар БОНАТ-д тусгаж өгнө. Төслийн дүн шинжилгээний дагуу нэмэлт үнэлгээ хийх шаардлагагүй бол БОНАТ-д нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй. Доорх жишээнээс харна уу].</p> <p>Төсөлд зориулж боловсруулсан Байгаль орчин, нийгмийн үнэлгээг [Банк/Ассоциац]-д зөвшөөрөгдөх байдлаар шинэчилж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p><i>[БОНУ хийх товыг тусгана. Хэрэв бэлэн болсон бол БОНУ-д тусгасан саармагжуулах арга хэмжээг Төслийн хэрэгжилтийн явцад хэрэгжүүлэх шаардлагатай талаар тусгаж өгнө].</i></p>	

1.3	<p><b>МЕНЕЖМЕНТИЙН БАРИМТ БИЧИГ</b></p> <p>[БОНС1-ийн хүрээнд БОНУБББ, БОНМТ-ууд гэх мэт өөр бусад БОН-ийн баримт бичиг, төлөвлөгөө боловсруулах эсвэл боловсруулахаар төлөвлөж байгаа эсэх талаар оруулах. Доорх жишээнээс харна уу.</p> <p>Төсөлд зориулж боловсруулсан Байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлогын баримт бичиг (БОНУБББ)-ийн дагуу санал болгосон дэд төслүүдэд шинжилгээ хийж, дараагаар нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНМТ)-ний төслийг Банк/Ассоциацад хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p>[Баримт бичгүүдийг боловсруулах хугацааг тусгана. Боловсруулж дууссан бол тухайн баримт бичгийг төслийн хэрэгжилтийн явцад баримтална гэдгийг тусгаж өгнө. БОН-ийн баримт бичиг, төлөвлөгөөг Банк урьдчилан дүгнэж, батлах шаардлагатай эсэхийг тусгаж өгнө. Тухайлбал тухайн дэд төслийн тендерийн үйл явцыг эхлүүлэхээс өмнө БОНМТ-уудыг Банк/Ассоциацаар батлуулах эсэх].</p>	
1.4	<p><b>ГҮЙЦЭТГЭГЧИЙН МЕНЕЖМЕНТ</b></p> <p>[Төслийн зарим үйл ажиллагаануудад гүйцэтгэгч/туслан гүйцэтгэгч оролцох боломжтой. Энэ тохиолдолд БОНАТ-ний холбогдох хүчин зүйлсийг тусгах үүднээс БОНАТ-д тендерийн баримт бичиг шаардагдана. Доорх жишээнээс харна уу].</p> <p>БОН-ийн холбогдох баримт бичиг, төлөвлөгөө, Хөдөлмөрийн менежментийн журам зэрэг БОНАТ-ний холбогдох хэсгүүдийг гүйцэтгэгчийн худалдан авах ажиллагааны баримт бичгүүд дэх БОНЭМАБ-ийн тодорхойлолтуудтай нэгтгэнэ.</p>	<p>[Хугацаа тодорхойлох:</p> <p>[Жишээ нь. Худалдан авах ажиллагааны баримт бичгийг боловсруулахаас өмнө. Төслийн хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчдэд хяналт, шалгалт явуулах].</p>	
<b>БОНС 2: ХӨДӨЛМӨР, АЖИЛЛАХ ЗОРЧИН</b>			
2.1	<p><b>ХӨДӨЛМӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖУРАМ</b></p>	<p>[Хугацаа заах: Жишээ нь Төсөл хэрэгжиж дуусах хүртэл].</p>	

	<p>[ХМЖ-ийг Зээлдэгч нь тодорхой цаг хугацаанд боловсруулах шаардлагатай эсвэл шаардлага үүсэж магадгүй. Үүнийг БОНАТ-д тусгаж өгөх хэрэгтэй. Доорх жишээнээс харна уу]</p> <p>Төсөлд зориулж хөгжүүлсэн Хөдөлмөрийн менежментийн журмыг (ХМЖ) шинэчилж, баталж, хэрэгжүүлнэ.</p>		
2.2	<p><b>ТӨСЛИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ</b></p> <p>[БОНС2-ын хүрээнд шаардагдах санал гомдол шийдвэрлэх механизмыг ХМЖ-д тодорхойлох хэрэгтэй. Доорх жишээнээс харна уу.].</p> <p>ХМЖ болон БОНС2-д заасанчлан Төслийн ажилчдад зориулсан санал, гомдол шийдвэрлэх механизм байгуулж, удирдан явуулж, хэвийн үйл ажиллагааг нь хангаж ажиллана.</p>	<p><i>[Хугацаа заах – жишээ нь Төсөлд ажилчид авахаас өмнө санал, гомдол шийдвэрлэх механизмыг бэлэн болгож, төсөл хэрэгжиж дуустал удирдаж авч явна].</i></p>	
2.3	<p><b>ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН (ХАБЭА) АРГА ХЭМЖЭЭ</b></p> <p>[БОНС1-д дурдсаны дагуу онцгой байдлын урьдчилсан бэлтгэл, хариу арга хэмжээ зэрэг ХАБЭА-ийн арга хэмжээнүүдийг БОН-ийн тусдаа баримт бичигт (жишээ нь БОНМТ) тодорхойлж болно. Энэ тохиолдолд үүрэг, амлалтыг тухайн баримт бичигт тусгаж болно. Доорх жишээнээс харна уу].</p> <p>БОНМТ-д заасан Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХАБЭА) арга хэмжээг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх.</p>	<p><i>[Хугацаа заах. ж.н. БОНМТ-ний хэрэгжилтийн цаг хугацаатай ижил байна].</i></p>	

**БОНС 3: НӨӨЦИЙН ҮР АШИГТАЙ БАЙДАЛ, БОХИРДЛЫН МЕНЕЖМЕНТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ** [БОНУ-ний явц дундын БОНС3-ийг тодорхойлно. БОНС3-т эрчим хүч, ус, түүхий эдийн хэрэглээ, агаарын бохирдол, аюултай, аюулгүй хог хаягдал, химийн болон аюултай материал, пестицидийн менежментийг хангах тодорхой арга хэмжээг батлах шаардлага гарах магадлалтай. Төслөөс хамаарч эдгээр арга хэмжээнүүдийг дээр буюу БОНС1-д заасны дагуу БОН-ийн баримт бичигт (жишээ нь БОНМТ), аль эсвэл бие даасан баримт бичигт тусгах, эсвэл тусдаа үйл ажиллагаагаар хэрэгжүүлж болно. БОНС3-тай холбоотой арга хэмжээнүүдийг бэлэн байгаа баримт бичгүүдэд оруулсан, эсвэл тусдаа арга хэмжээгээр шийдвэрлэх эсэхийг тусгана. Доорх жишээнүүдээс харна уу].

3.1	<b>ХОГ ХАЯГДЛЫН ЦАХИМ ТӨЛӨВЛӨГӨӨ:</b> Хог хаягдлын цахим төлөвлөгөө боловсруулж, баталж, хэрэгжүүлэх.	<i>[Хугацаа заах. ж.н. Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын хугацаанд боловсруулж, төсөл хэрэгжиж дуустал хэрэгжүүлнэ].</i>	
3.2	<b>НӨӨЦИЙН ҮР АШИГТАЙ БАЙДАЛ, БОХИРДЛЫН МЕНЕЖМЕНТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ:</b> БОНМТ болон дээр дурдсан ХХ заалтын хүрээнд нөөцийн үр ашигтай байдал, бохирдлын менежмент, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг боловсруулна.	<i>[Хугацаа заах. ж.н. БОНМТ-уудтай ижил хугацаанд боловсруулж, хэрэгжүүлнэ]</i>	

**БОНС 4: ОРШИН СУУГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ** [БОНС4-ийн холбогдох баримт бичгүүдийг БОНУ-ний явц дунд боловсруулна. Дээр буюу БОНС1, эсвэл бие даасан баримт бичиг, тусдаа арга хэмжээнд дурдсанчлан БОНС3, БОНС4-ийн хүрээнд БОН-ийн баримт бичигт (БОНМТ г.м) тодорхой арга хэмжээнүүдийг батлах шаардлагатай болж магадгүй. БОНС4-тэй холбоотой арга хэмжээнүүд одоогийн баримт бичгүүд, бие даасан үйл ажиллагаанд багтсан эсэхийг тодорхой болгох. Доорх жишээнээс харна уу].

4.1	<b>ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ:</b> Дээр буюу ХХ-д заасны дагуу хөгжүүлэх БОНМТ-уудын хүрээнд Замын хөдөлгөөн, замын аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж, зохицуулах арга хэмжээнүүдийг баталж, хэрэгжүүлэх.	<i>[Хугацаа заах. ж.н. БОНМТ-уудтай ижил хугацаанд боловсруулж, хэрэгжүүлнэ]</i>	
-----	--	--	--

4.2	<p><b>ОРШИН СУУГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ:</b> Төслийн үйл ажиллагааны үлмээс оршин суугчдад бий болох тодорхой эрсдэл, нөлөөллүүдийг үнэлж, зохицуулах арга хэмжээ, үйл ажиллагааг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх. [Үүнд, тэр дундаа,] [анхаарал хандуулах шаардлагатай тодорхой эрсдэл байгаа эсэх, жишээ нь Төслийн ажилчдын зан төлөв, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн, онц байдлын үеийн хариу арга хэмжээ] багтах бөгөөд эдгээр арга хэмжээг БОНМБББ-д заасны дагуу Банкны шаардлагад нийцсэн байдлаар боловсруулах БОНМТ-уудад багтаах.</p>	<p><i>[Хугацаа заах ж.н. БОНМТ-уудтай ижил хугацаанд боловсруулж, хэрэгжүүлнэ]</i></p>	
4.3	<p><b>ЖСХ, БДХ-ИЙН ЭРСДЭЛҮҮД:</b> [БДХ-ийн дундаж, бодит, эсвэл өндөр тархалтын эрсдэл]</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), бэлгийн дарамт, хүчирхийллийн (БДХ) эрсдэлүүдийг үнэлж, шийдвэрлэх зорилгоор Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг үйл ажиллагааны бие даасан төлөвлөгөө (ЖСХ-ийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө) боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p><i>[Хугацаа заах ж.н. худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг боловсруулахаас өмнө ЖСХ-ийн эсрэг үйл ажиллагаан төлөвлөгөөг Банкаар батлуулна. Батлагдсаны дараа ЖСХ-ийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн хэрэгжилт дуустал хэрэгжүүлнэ].</i></p>	
4.4	<p><b>ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕИЙН ЖСХ, БДХ-ИЙН ЭРСДЭЛҮҮД:</b> [Шаардлагатай гэж үзвэл Төслийн хэрэгжилтийн явцад гарах магадлалтай ЖСХ, БДХ-ийн эрсдэл, нөлөөллүүдийг шийдвэрлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнд ашиглаж болох нэмэлт санхүүжилтийг тодорхойлно.]</p>		
4.4	<p><b>ХАМГААЛАЛТЫН АЖИЛТНУУД:</b> БОНС4-ийн шалгуурын хүрээнд Хамгаалалтын ажилтнуудын зохицуулалтын бие даасан төлөвлөгөөг Банканд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p><i>[Хугацаа заах ж.н. Хамгаалалтын ажилтнуудтай холбогдохоос өмнө, түүнээс хойш төслийн хэрэгжилт дуусах хүртэл].</i></p>	

**БОНС 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ, АЛБАДАН НҮҮЛГЭЛТ** [БОНС5-ийн хэрэгцээг БОНУ-ийг явц дунд тодорхойлно. Төслийн боловсруулалтын шатанд нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой баримт бичиг хэрэгтэй эсэхийг тодорхойлно. Үүнийг БОНАТ-д тусгаж өгнө. Доорх жишээнээс харна уу.]

5.1	<p><b>НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:</b> БОНС5-ийн хүрээнд болон төсөлд зориулж баталсан НШБББ-ийн шалгуурын дагуу нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнүүдийг (НШТ) боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ. Холбогдох үйл ажиллагаануудын хүрээнд хийгдэх ажлуудыг хэрэгжүүлэхээс өмнө НШТ-үүдийг [Банк/Ассоциац]-д хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>	<p><i>[Хугацаа заах ж.н. НШТ-үүдийг Банкаар батлуулж, дараагаар нь Төслийн үйл ажиллагаа, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг эхлүүлэхээс өмнө хэрэгжүүлнэ].</i></p>	
5.2	<p><b>ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ</b></p> <p>[Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой гомдлыг шийдвэрлэхэд зориулсан гомдол шийдвэрлэх механизм (ГШМ)-ыг НШБББ, НШТ-үүд, ТОДТ-д тодорхойлох хэрэгтэй. БОНС5-тай холбоотой гомдлыг шийдвэрлэхэд шаардлагатай онцлог зүйлс гарвал БОНАТ-д тодорхойлж болно].</p>	<p><i>[Хугацаа заах ж.н. Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа эхлэхээс өмнө]</i></p>	

**БОНС 6: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН АМЬД НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ** [БОНС6-ийн хэрэгцээг БОНУ-ний явц дунд тодорхойлно. Бусад БОНС-уудын адилаар, дээр буюу БОНС1 эсвэл бие даасан баримт бичиг, тусдаа үйл ажиллагааны хүрээнд БОНС6-ын хүрээнд тодорхой арга хэмжээг БОН-ийн баримт бичгүүдэд (ж.н. БОНМТ) батлах шаардлагатай болох магадлалтай. БОНС6-тай холбоотой арга хэмжээнүүд одоогийн баримт бичгүүд болон бие даасан үйл ажиллагаанд багтсан эсэхийг тодорхойлно. Доорх жишээнээс харна уу].

6.1	<p><b>БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ЭРСДЭЛҮҮД, НӨЛӨӨЛЛҮҮД:</b> [Биологийн олон янз байдалтай холбоотой эрсдэлүүд, нөлөөллүүд БОНМТ-ний хүрээнд нэгдсэн байдлаар тусгаж болохгүй үед]</p> <p>Биологийн олон янз байдлын удирдлагын бие даасан төлөвлөгөөг Төсөлд зориулж боловсруулсан БОННУ-ний хүрээнд, Банканд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p><i>[[хугацаа]][Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын хугацаанд]][биологийн олон янз байдалд нөлөөлж мэдэх [байгууламж]-ийн бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө Банкаар батлуулахаар өргөн барина].</i></p>	
-----	--	--	--

		<i>[Батлуулсны дараа төслийн хэрэгжилт дуустал хэрэгжүүлнэ.]</i>	
<b>БОНС 7: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭД/ӨВӨР САХАРЫН АФРИКЫН ХАМГААЛАГДААГҮЙ, ТҮҮХЭН, УЛАМЖЛАЛТ СОЁЛ ИРГЭНШИЛ</b> [БОНС 7 хамааралтай гэж үзвэл боломжит арга хэмжээний талаарх жишээг харна уу].			
7.1	<b>НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:</b> Нутгийн уугуул иргэдийн төлөвлөгөө (НУИТ)-нүүдийг төсөлд зориулж, БОНС7-ийн дагуу бэлтгэсэн Нутгийн уугуул иргэдийн төлөвлөгөөний бодлогын баримт бичиг (НУИТБББ)-ийн хүрээнд Банканд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.	<i>[Хугацаа заах ж.н. НУИТ боловсруулах шаардлагатай аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө тухайн НУИТ-г Банканд хүргүүлж, батлуулна. Баталсны дараа НУИТ-г төсөл хэрэгжиж дуустал хэрэгжүүлнэ.]</i>	
7.2	<b>ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ:</b> НУИТБББ-ийн шаардлагын дагуу нутгийн уугуул иргэдэд зориулсан гомдол шийдвэрлэх механизмын зохион байгуулалтыг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх бөгөөд (хэрэв гомдол шийдвэрлэх механизм нь БОНС10-аас ялгаатай бол) тэдгээрийг НУИТ тус бүрд тодорхойлно.	<i>[Хугацаа заах]</i>	
<b>БОНС 8: СОЁЛЫН ӨВ</b> [БОНС8-ийн хэрэгцээг БОНУ-ний явц дунд тодорхойлно. Бусад БОНС-уудын адилаар, дээр буюу БОНС1 эсвэл бие даасан баримт бичиг, тусдаа үйл ажиллагааны хүрээнд БОНС8-ын тодорхой арга хэмжээг БОН-ийн баримт бичгүүдэд (ж.н. БОНМТ) батлах шаардлагатай болох магадлалтай. БОНС8-тай холбоотой арга хэмжээнүүд одоогийн баримт бичгүүд, бие даасан үйл ажиллагаанд багтсан эсхийг тодорхойлно. Доорх <u>жишээнээс</u> харна уу].			
8.1	<b>ГЭНЭТИЙН ОЛДВОР:</b> Төсөлд зориулж боловсруулсан БОНМТ-д тусгасны дагуу гэнэтийн олдворын журам боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.	<i>[Хугацаа заах ж.н. Төсөл хэрэгжиж дуустал].</i>	
<b>БОНС 9: САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ</b> [Энэхүү стандарт нь зөвхөн Санхүүгийн зуучлал (СЗ) орсон Төслүүдэд хамааралтай. СЗ орсон тохиолдолд авах үйл ажиллагааны хэд хэдэн жишээг доор харуулав.]			



9.1	<p><b>БОНМС:</b> Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС) боловсруулж, баталж, удирдан явуулна.</p>	<p>[Хугацаа заана ж.н. СЗ-ын дэд төслүүдэд шинжилгээ хийхээс өмнө. Бэлэн болсны дараа Төсөл хэрэгжиж дуустал ажиллуулж, хэвийн үйл ажиллагааг нь хангана.]</p>	
9.2	<p><b>СЗ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮЧИН ЧАДАЛ:</b> БОНМС-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагын хүчин чадал, хүн хүч бүрдүүлж, үйл ажиллагааг нь хангана. Үүнд үүрэг хариуцлагуудыг нь тодорхой зааж төгсөн байх шаардлагатай [байгууллагын бүтцийн салшгүй нэг хэсэг, БОН-ийн менежментийн тодорхой албан тушаал/нөөцийг холбогдох газар нь тодорхойлох].</p>	<p>[Хугацаа заана. ж.н. байгууллагын хүчин чадлыг [албан тушаал/нөөц] тодорхойлсон байх [огноо] тогтооно].</p>	
9.3	<p><b>МЕНЕЖМЕНТИЙН АХЛАХ ТӨЛӨӨЛӨЛ:</b> СЗ-ын дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн ерөнхий үүрэг хариуцлагыг хариуцсан менежментийн ахлах төлөөлөл томилох.</p>	<p>[Менежментийн ахлах төлөөллийг хэдий хугацаанд томилохыг тодорхойлно].</p>	
<p><b>БОНС 10: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АЖИЛ</b></p>			
10.1	<p><b>ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БОЛОВСРУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ</b></p> <p>[Үнэлгээ хийхээс өмнө ТОДТ-ний төслийг боловсруулж, олон нийтэд ил болгоно. Төлөвлөгөөг боловсруулсан, эсвэл шинэчлэх шаардлагатай, хэрэгжүүлэх хэрэгтэй эсэхийг БОНАТ-д тусгах хэрэгтэй. Доорх жишээнээс харна уу].</p> <p>Талуудын оролцоог дэмжих төлөвлөгөөг (ТОДТ) шинэчилж, баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p>[Хугацаа заах. ж.н. [огноо эсвэл үйл явдал оруулах]-аас/ээс өмнө]</p>	

10.2	<b>ТӨСЛИЙН ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ:</b> ТОДТ-д тусгасан гомдол шийдвэрлэх механизмыг боловсруулж, баталж, хэрэгжүүлж, үргэлжлүүлнэ.	<i>[Хугацаа заах: ж.н. [огноо оруулах]-аас/ээс өмнө].</i>	
<b>ЧАДАВХЖУУЛАХ (СУРГАЛТ)</b>			
ЧД1	<p>[Зорилтот бүлэгт үзүүлэх сургалтуудыг тодорхойлох</p> <p>Жишээ нь, Дараах зүйлсэд сургалт шаардагдах магадлалтай [ж.н. ТУН-ийн ажилтан, оролцогч талууд, иргэдийн бүлэг, Төслийн ажилчид]:</p> <ul style="list-style-type: none"> <li>● оролцогч талуудын зураглал, оролцооц</li> <li>● байгаль орчин, нийгмийн үнэлгээний тодорхой хэсгүүд</li> <li>● онц байдалд бэлтгэлтэй байдал, хариу арга хэмжээ</li> <li>● олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал.]</li> </ul>		
ЧД2	<p>[Төслийн ажилтнуудад онц байдалд урьдчилж бэлдэх, бэлэн байх, онц байдлын үеийн зохицуулалт зэрэг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар орох сургалтыг тусгах.]</p>		

## **ХАВСРАЛТ 2: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ШАЛГАХ ЖАГСААЛТ**

Энэхүү Жагсаалт нь Дэлхийн Банкны 2016 оны Байгаль орчин, нийгмийн хүрээний бодлогын баримт бичгийн хэсэг болох Байгаль орчин, нийгмийн стандартуудыг хангасан эсэхийг Зээлдэгч тал шалгахад зориулсан зөвлөмж болно. Жагсаалт нь БОНС-уудын шалгууруудыг хангахад нь тус болж, БОНС-уудын зарим шалгууруудыг хэрэгжүүлэх жишиг алхмуудыг санал болгоно; эдгээр нь Банкны бодлого биш бөгөөд заавал биелүүлэх шаардлагагүй болно. Төслийн хүрээнд шийдвэр гаргах явцад зөв зохистой шийдвэр үнэлгээ, дүгнэлт хийх шаардлагыг энэхүү жагсаалт орлохгүй. Жагсаалт, БОНС-ууд хооронд аливаа үл нийцэл, зөрчил үүссэн тохиолдолд БОНС-ийн заалтууд хүчин төгөлдөр үйлчлэх болно.

Төслийн Гомдол шийдвэрлэх механизмын (ГШМ) нарийн, төвөгтэй байдлын зохих түвшин нь тухайн төсөл болон төслийн хүрээнд хийгдэх ажлуудын эрсдэл, сөрөг нөлөөллөөс хамаарна. Дараах жагсаалт нь олон улсын сайн туршлагыг баримталсан ГШМ-ын зохистой үйл ажиллагааг харуулах бөгөөд энэхүү туршлагыг бүх төсөлд заавал ашиглах шаардлагагүй болно. Түүнчлэн энэхүү жагсаалтыг ашиглан аливаа гомдол шийдвэрлэх механизм олон улсын сайн туршлагыг мөрдөж буй эсэхийг шалгаж болно.

### **A. Тогтолцооны асуудлууд**

1. Төслийн талаарх санал/гомдол нээлттэй хүлээн авч байгаа юу?
2. Тухайн байгууллагад санал, гомдол шийдвэрлэх бодлого бий юу?
  - a. Бодлого нь бүх ажилтан, үр ашиг хүртэгч болон боломжит хэрэглэгчдэд нээлттэй байдаг уу?
  - b. Бодлого нь тухайн оршин суугчдын эх хэл(үүд) дээр бичигдсэн үү?
3. Гомдол шийдвэрлэх механизм нь дараах онцлогийг агуулсан уу?
  - a. Хүмүүс саналаа илэрхийлж, гомдол мэдүүлэхэд тодорхой, ойлгогдохоор журамлагдсан.
  - b. Санал/гомдлуудыг хэн хариуцаж шийдвэрлэх нь тодорхой мэдэгдэж байгаа.
  - c. Тухайн гомдлын хэр ноцтой, далайцтай байгаагаас нь хамаарч гомдлыг шийдвэрлэх, эсвэл зуучлах, шалгах журмуудтай.
  - d. Гомдол гаргагчдад шийдвэрлэлтийн явц, нөхцөл байдлын талаар мэдээлэх системтэй.
  - e. Санал/гомдол, үр дүнг бүртгэх системтэй.
  - f. Гомдол гаргагчдын нууцыг хамгаалах журмуудтай.

### **B. Ажилтнуудад зориулсан арга хэмжэ**

1. Ажилтнуудад зориулсан санал, гомдол шийдвэрлэх гарын авлага бий юу?
2. Гомдол шийдвэрлэх бодлого, журамд дараах зүйл багтаж байгаа юу:
  - a. Гомдол/санал гэж юу вэ?
  - b. Гомдол гаргагчдаас ямар мэдээлэл цуглуулах вэ?

- c. Гомдлыг шийдвэрлэх ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай, эсвэл болох вэ?
- 3. Гомдол шийдвэрлэх бодлого, журмын талаарх ойлголтыг бүх ажилчдад өгдөг үү?
- 4. Гомдол шийдвэрлэх механизмыг үр дүнтэй явуулахад хангалттай нөөц бололцоо хуваарилдаг үү?
- 5. Байгууллагаас ажилтнууддаа санал, гомдол шийдвэрлэх сургалт явуулдаг үү?

**C. Гомдол шийдвэрлэх механизмыг хэрэглэгчдэд хүргэх**

- 1. Гомдол/саналыг хэрхэн хүргүүлэх талаар хэрэглэгчдэд хэлж өгдөг үү?
  - a. Гомдол шийдвэрлэх механизмын талаарх мэдээллийн брошур хэрэглэгчдэд хүртээмжтэй юу?
  - b. Санал/гомдлын маягт хэрэглэгчдэд хүртээмжтэй юу?
  - c. Гомдлын маягт болон хаяг гаргацтай, тод харагдахуйц, хүртээмжтэй байгаа юу?
  - d. Санал/гомдол хүлээн авч буй ажилтантай холбогдох мэдээлэл нийтийн талбайд хэвлэмэл, харагдахуйц байдлаар бий юу?
  - e. Гомдолтой холбоотой зохицуулалтын талаар мэдээлэл оршин суугчдын эх хэл дээр байгаа юу?
- 2. Хэрэглэгчид дараах байдлаар гомдол/санал мэдүүлэх боломжтой юу:
  - a. Бичгээр
  - b. Цахим шуудангаар
  - c. Факсаар
  - d. Утсаар
  - e. Биеэр
- 3. Хэрэглэгчдэд санал/гомдол мэдүүлэх шаардлагатай үед нь туслалцаа үзүүлдэг үү?
- 4. Гомдол шийдвэрлэх механизмыг үнэгүй ашиглах боломжтой юу?
- 5. Хэрэглэгчдийн нууцыг баттай хадгалдаг үү?
- 6. Шүүхэд гомдол мэдүүлэх процессын талаар хэрэглэгчдэд мэдээлэл өгдөг үү?

**D. Санал/гомдлын бүртгэл**

- 1. Бүх санал/гомдлыг бүртгэдэг үү?
  - a. Гомдол/саналуудыг тэмдэглэж, баримт бичиг болгож хадгалдаг үү?

- b. Тодруулга/зөвлөмж, зөвлөгөөнүүдийг бүртгэлжүүлдэг үү?
- c. Бүх гомдол/саналын үр дүн, хариу арга хэмжээнүүдийг бүртгэлжүүлдэг үү?

**E. Бизнесийн стандарт**

- 1. Гомдол/саналыг шийдвэрлэх үйл явц, цаг хугацааны тал дээр бизнесийн стандарт бий юу?
  - a. Мэдүүлгийг тогтсон цаг хугацааны дотор хүлээн авдаг үү?
  - b. Гомдлуудыг тогтсон хугацаанд нь шийдвэрлэх ёстой юу?
- 2. Дараах зүйлсийг агуулсан чанарын хяналтын систем бий юу:
  - a. Бүх гомдлыг шийдвэрлэсэн, эсвэл арга хэмжээ авсан эсэхийг шалгах.
  - b. Гомдлыг бүхэлд нь шийдвэрлэсэн эсэхийг шалгах.
  - c. Шаардлагатай бүх алхмуудыг хэрэгжүүлсэн эсэхийг шалгах.

**F. Дүн шинжилгээ, санал**

- 1. Гомдол/саналын дотоод тайланг удирдах албан тушаалтнуудад тогтмол хүргүүлдэг үү?
- 2. Гомдол/саналын тайланд дараах өгөгдлийг багтаадаг эсэх:
  - Хүлээн авсан гомдол/саналын тоо.
  - Бизнесийн стандартыг мөрдөж буй эсэх.
  - Гомдол/саналтай холбоотой үүссэн асуудлууд.
  - Тодорхой хугацаанд ирүүлсэн гомдол/саналын хандлага.
  - Гомдол/саналын шалтгаан.
  - Хариу арга хэмжээ хангалттай байсан эсэх
  - Гомдол барагдуулах ямар арга хэмжээ авсан талаар
  - Ижил төрлийн асуудал үүсэхээс сэргийлэх, хязгаарлах зөвлөмжүүд/стратегийн үйлдвэр.
- 3. Гомдол/саналын талаарх тайланг олон нийтэд тогтмол мэдээлдэг үү?

## **ХАВСРАЛТ 3: ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР**

---

Энэхүү загвар нь Дэлхийн Банкны 2016 оны Байгаль орчин, нийгмийн бодлогын баримт бичигийн нэг хэсэг болох Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-уудыг хэрэгжүүлэхэд түс болох зүйлсийг Зээлдэгчид зөвлөх үүрэгтэй болно. Загварууд нь БОНС-уудын шалгууруудыг дүрслэн харуулахад тусалж, тэдгээрийг биелүүлэх жишиг алхамуудыг санал болгов. Эдгээр нь Банкны бодлого биш бөгөөд сайн дураар хэрэглэх зориулалттай баримт бичиг болно. Энэхүү загвар болон БОНС-ууд хооронд үл нийцэл, зөрчил үүссэн тохиолдолд БОНС-ийн заалтууд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Төлөвлөгөөний цар хүрээ, нарийвчлалын түвшин нь байгаль орчин, цар хүрээ, эрсдэлийн магадлал, төслийн нөлөө, төслийн улмаас сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай, эсвэл сонирхсон оролцогч талуудын оролцоо зэргийг тооцож, үялдуулах хэрэгтэй. Төслийн эрсдэл, нөлөөллийн цар хүрээний үндсэн шинжээс хамаарч ТОДТ-ний элементүүдийг Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ)-ний нэг хэсэг болгож, бие даасан ТОДТ боловсруулахгүй байх боломжтой.

*ТОДТ нь товч, тодорхой байдлаар төслийг тайлбарлаж, оролцогч талуудыг тодорхойлоход анхаарах хэрэгтэй. Олон нийтэд ямар мэдээллийг ямар хэлээр, хаана байрлуулах вэ гэдгийг тодорхойлох нь чухал. Үүнд олон нийтийн хэлэлцүүлэг явуулах боломжуудыг тайлбарлаж, санал хүсэлт авах эцсийн хугацааг нь зааж, санал хүсэлт хүргүүлж болох талаар шинэ мэдээлэл, боломж гарвал хэрхэн хүргэх талаар ойлголт өгнө. Ингэхдээ санал хүсэлтийг хэрхэн дүгнэж, анхааралдаа авах вэ гэдгийг тайлбарлана. Үүнд мөн төслийн санал, гомдол шийдвэрлэх механизмыг тодорхойлж, үүнд хэрхэн хандах талаар ойлголт өгнө. ТОДТ-д мөн хэлэлцүүлэг явуулах боломжууд, гомдлыг хэрхэн зохицуулах гэх мэт төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэл түгээх үүрэг, амлалтыг тусгах хэрэгтэй.*

ТОДТ-ний ерөнхий стандартыг дор харуулав:

### **1. Танилцуулга/Төслийн тодорхойлолт**

Төсөл, төслийн үе шат, зорилго, одоо хэлэлцэгдэж буй, олон нийтийн оролцоо хэрэгтэй байгаа шийдвэрүүдийг товч тайлбарлана.

Байршлыг тодорхойлж өгөх бөгөөд боломжтой бол төслийн талбай(нууд) болон ойролцоох талбайн зураглалыг хавсаргаж, оршин суугчид болон ажилчдын байр, барилгын талбайн хашаа, эсвэл түр хугацааны үйл ажиллагаа зэрэг оролцогч талуудад нөлөөлж мэдэхүйц нөлөөллийн талбайг харуулна. Холбоос хаяг, эсвэл төслийн нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн магадлалын техникийн бус тоймыг хавсаргана уу.

### **2. Талуудын оролцоог дэмжих өмнөх үйл ажиллагаануудын тойм**

Зөвшилцөх, олон нийтэд мэдээлэх ажлууд хийгдсэн бол олон нийтэд мэдээлсэн талаар болон албан бус эсвэл албан үүлзалт/эсвэл зөвшилцлийн талаарх мэдээллийг хавсаргаж, тэдгээр үйл ажиллагаануудын хураангуй тойм (хагас нүүрнээс хэтрэхгүй), нийтэд мэдээлсэн мэдээлэл, өмнөх үйл ажиллагаануудын талаар

нарийн мэдээллийг хаанаас авч болох талаар оруулж өгнө(жишээ нь цахим холбоос, эсвэл байршил, хүсэлт гаргах боломж).

### **3. Оролцогч талыг тогтоох, дүн шинжилгээ хийх ажил**

Төслийн талаар мэдээлэл авч, зөвшилцөх гол оролцогч талуудыг тодорхойлно. Үүнд дараах шалтгаантай хувь хүн, бүлэг, оршин суугч хамрагдана:

- a. Төслийн нөлөөлөлд өртсөн, өртөх магадлалтай (төслийн нөлөөлөлд өртсөн талууд);
- b. Төсөлд оролцох сонирхолтой байж болох (бусад сонирхсон талууд).

Төслийн үндсэн шинж, цар хүрээ, эрсдэл, нөлөөллийн магадлалаас хамаарч засгийн газрын эрх бүхий байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, ТББ-ууд, хувийн хэвшлийн компаниуд, ойролцоох оршин суугчдыг төсөлд оролцох боломжтой талуудад гэж үзэж болно. Улс төрчид, хөдөлмөрийн холбоод, судалгаа, шинжилгээний салбарынхан, шашны бүлгүүд, нийгэм, байгаль орчны төлөөх төрийн агентлагууд, хэвлэл мэдээллийнхэн оролцогч тал болох боломжтой.

#### **3.1. Нөлөөлөлд өртөх талууд**

Төслийн эерэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх магадлалтай хувь хүмүүс, оршин суугчид болон бусад оролцогч талуудыг тодорхойлно. Төслийн үйл ажиллагаанд шууд болон сөрөг нөлөөлөлд өртөх талуудыг ТОДТ-д анхаарах хэрэгтэй. Нөлөөлөлд өртөх оршин суугчдыг газарзүйн бүсэд байршуулах замаар нөлөөллийн бүсийг гаргах нь төслийн нөлөөллийн бүсийг тодорхойлж, сайжруулахад тус болно. Нөлөөлөлд өртөх магадлалтай, төслийн нөлөөллийн хязгаарыг ойлгохын тулд нэмэлт мэдээлэл шаардлагатай талуудыг ТОДТ-д тодорхойлох хэрэгтэй.

#### **3.2. Сонирхсон бусад талууд**

Төслийн байршил, байгалийн болон бусад нөөц баялагтай ойр байдал, салбар, төсөлд оролцож буй талуудтай холбоотойгоор төслийг сонирхсон оролцогч талуудыг өргөн хүрээнд тогтоох хэрэгтэй. Орон нутгийн захиргааны албан хаагчид, оршин суугчдын удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа нөлөөллийн бүсэд ажилладаг, оршин суудаг хүмүүс үүнд багтаж болно. Эдгээр бүлгүүд төсөлд шууд өртөхгүй байж болох ч төслийн бэлтгэл ажилд чухал үүрэгтэй байж болно (тухайлбал засгийн газраас зөвшөөрөл авахад), аль эсвэл төслийн нөлөөлөлд өртөх нийгмийн бүлэгт багтаж буй түл өрхийн нөхцөл байдалд ерөнхийд нь санаа зовнисон байж болно.

Цаашлаад иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд төслийн талбайн байгаль орчин, нийгмийн нөхцөл байдал, ойролцоох хүн амын талаар илүү нарийн мэдлэгтэй байж болох бөгөөд Зээлдэгчид эрсдэлийн магадлал, болзошгүй сөрөг нөлөөлөл, боломж бололцоог тодорхойлж, үнэлгээний явцад шийдэл олоход нь туслах боломжтой. Тухайн салбараас (жишээ нь уул уурхай, эрүүл ахуй) хамаарч зарим бүлэг хүмүүс төсөлд оролцох сонирхолтой байж болно. Мөн зарим нь төслийн дэмжлэг болгож төсвийн санхүүжилт санал болгож байгаа гэх шалтгаанаар мэдээлэл авах хүсэлтэй байж болно. Төслийн талаарх мэдээлэл олон нийтийн мэдээллийн сүлжээнд нээлттэй байгаа нөхцөлд ямар хүмүүс эсвэл нийгмийн бүлэг төслийн талаар мэдээлэл хүлээн авч буй шалтгааныг тогтоох шаардлагагүй, сонирхсон бүх хүнд нээлттэй байх хэрэгтэй.

#### **3.3. Хөгжлийн бэрхшээлтэй / эмзэг бүлгийнхэн**

Төслийн нөлөөллийг ойлгож, ихэнх тохиолдолд өөрсдийн дуу хоолойг хүргэж, төслийн нөлөөллийг төдийлөн ойлгож чаддаггүй хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл эмзэг бүлгийнхэнд тэгш бус нөлөөлөх эсэхийг тодорхойлох нь тур дундаа маш чухал. Хүн амын энэхүү бүлгийн үзэл бодлыг ойлгоход дараах алхмууд тусална:

- a. Нийгмийн эмзэг бүлгийн, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй бүлэг, тэдгээрийн төсөлд оролцох эсвэл төслийн мэдээллийг ойлгож, хэлэлцэх явцад оролцоход тулгарч буй асуудлуудыг тодорхойлох.
- b. Төлөвлөсөн үйл ажиллагаанд оролцоход нь эдгээр хувь хүн, бүлэгт ямар асуудал тулгарч болох вэ? (Жишээ нь хэлний зөрүүтэй байдал, арга хэмжээнд очих тээврийн бололцоо дутмаг, арга хэмжээ болж буй газрын хүртээмжтэй байдал хязгаарлагдмал, хөгжлийн бэрхшээлийн улмаас, хэлэлцүүлгийн явцын талаар ойлголт дутмаг зэргээс)
- c. Оршин суугчид, төслүүд, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэнхдээ хаанаас авдаг вэ?
- d. Олон нийтийн хэлэлцүүлгийг тодорхой цаг, байршилд явуулахад саад бэрхшээл учирдаг уу?
- e. Хэлэлцүүлгийн явцад эдгээр хүмүүсийн оролцоог хангахад ямар нэмэлт дэмжлэг эсвэл нөөц хэрэгтэй вэ? (Жишээ нь цөөнхийн хэл рүү орчуулах, дохио, зангааны хэл рүү хөрвүүлэх, томоор хэвлэсэн эсвэл барейль мэдээлэл өгөх; илүү олон хүн хамрагдаж болох газар сонгож, арга хэмжээг зохион байгуулах; алслагдмал байршилд оршин суугчдад хамгийн ойр зохион байгуулагдаж буй уулзалт руу нь хүргэж өгөх шийдэл санал болгох; нийгмийн эмзэг бүлгийнхэн илүү нээлттэй асуулт асууж, асуудал хөндөх бололцоотой цомхон, тодорхой бүлэгт анхаарсан уулзалтууд зохион байгуулах.)
- f. Төслийн талбайд хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт нийгмийн эмзэг бүлгийнхэнтэй тулж ажилладаг тодорхой байгууллага байхгүй бол хүн амын цөөнхийн талаарх тодорхой ойлголттой, тэдэндээ илүү сайн ажиллаж чадах эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоно.
- g. Төслийн хүрээнд нийгмийн эмзэг бүлгийнхэн болон тэднийг төлөөлөх талуудын оролцоог дэмжих чиглэлд ямар ажил хамгийн сүүлд хийгдсэн бэ?

### 3.4. Төслийн оролцогч талуудын хэрэгцээ шаардлагын хураангуй

Жишээ

Нийгмийн бүлэг	Оролцогч талууд	Гол шинж чанарууд	Хэлний хэрэгцээ	Мэдээлэл авах хэрэгсэл (имэйл, утас, радио, албан бичиг)	Тодорхой хэрэгцээ (хүртээмж, томоор хэвлэх, хүүхдийн халамж, өдрийн цагаар уулзах г.м)
А тосгон	Бага насны хүүхэдтэй эцэг эх	Нөөлөлд өртсөн дунджаар 180 өрх; 300 хүүхэд	Тухайн улсын албан ёсны хэл	Бичмэл хэлбэрээр, радио	Уулзалтуудын явцад хүүхэд асрах, үдээс хойш зохион байгуулах



А тосгон	Дүрвэгсэд	38 гэр бүл ба тэдний төрөл садан, ядуурлын түвшин	Өөр хэлээр	Орчуулагчийн хамт биеэр очиж, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөр дамжуулан	Үзүүлж, харуулах, үйл явцын талаар заах
----------	-----------	---	------------	--	---

#### 4. Талуудын оролцоог дэмжих хөтөлбөр

##### 4.1. Талуудын оролцоог дэмжих хөтөлбөрийн зорилго, цаг хугацаа

Талуудын оролцогч дэмжих хөтөлбөрийн гол зорилгууд болон энэ чиглэлд хийх төрөл бүрийн үйл ажиллагаануудын урьдчилсан хуваарийг тоймлоно: Төслийн ямар шатанд, хэдий хугацаанд хэрэгжих, ямар хүмүүсийн санал, хүсэлт, асуудлыг шийдвэрлэхээр хэлэлцэж байгааг дурдах. Олон нийтийн дүнд явуулах уулзалтууд, тэдгээрийн байршил, тов гараагүй бол олон нийтэд мэдээллийг дүгнэж, байр сууриа илэрхийлэх боломж хэзээ олгогдох талаар тодорхой мэдээлэл өгөх. Тухайн мэдээлэлд БОНАТ-ийг хавсаргах. Зарим төсөлд ТОДТ-ийг тусад нь салгах шаардлагагүй, хамаатай хэсгүүдийг нь БОНАТ-д нэгтгэж болно.

##### 4.2. Олон нийтэд мэдээлэл түгээхээр санал болгож буй стратеги

Ямар мэдээллийг ямар форматтай олон нийтэд мэдээлж, оролцогч тал тус бүрд тухайн мэдээллийг түгээх арга барилын төрлийг товч тодорхойлно. Зорилтот бүлгээс хамаарч ашиглах арга барил нь өөр байх боломжтой. Хэвлэлийн байгууллага тус бүрийн нэрийг жишээ нь тодорхой болгоно (тухайлбал, Өдрийн сонин, The Independent, радио 100.6, 44 дүгээр суваг). Олон нийтэд мэдээлэх ажлыг сонгон шалгаруулах ажиллагаа нь тухайн төсөл хэрэгжих байршилд оршин суугчдын мэдээлэл хүлээн авахдаа хамгийн түгээмэл хэрэглэдэг хэрэгслээс хамаарах бөгөөд үндэсний эрх ашигт нийцсэн, мэдээллийн төвлөрсөн эх үүсвэр үүнд багтаж болно. Илүү олон талуудтай холбогдож ажиллахын тулд өөр олон арга хэрэгсэл ашиглах хэрэгтэй. Төсөлд хамгийн тохирох хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгож, тухайн сонголтыг хийх болсон шалтгаанаа тодорхой заах хэрэгтэй. Талуудын оролцоог дэмжихээр санал болгож буй төлөвлөгөөний талаар санал хүсэлтийг нээлттэй авах тухай мэдэгдэл, сайжруулах зөвлөмжүүдийг төлөвлөгөөнд тусгаж өгөх хэрэгтэй. Алслагдсан байршилд оршин сууж буй хүмүүст зориулсан сонин хэвлэл, эсвэл тусдаа уулзалт, олон нийтийн хэрэгсэлд нэмэлт баримт бичгүүд байрлуулах шаардлага гарч магадгүй. Олон нийтийн хэрэгсэл гэдэгт дараах зүйлс багтана:

- a. Сонин, зурагт хуудас, радио, телевиз;
- b. Мэдээллийн төвүүд, үзэсгэлэн, эсвэл үзэгдэх байдлаар мэдээлэл түгээх бусад хэрэгслүүд;
- c. Брошур, хэвлэмэл материалууд, зурагт хуудас, техникийн бус баримт бичгийн тойм, тайлангууд;
- d. Олон нийттэй харилцах ажилтан, албан ёсны уулзалтууд;
- e. Веб хуудас, нийгмийн сүлжээ.

Төсөлд томоохон өөрчлөлт орсны улмаас нэмэлт эрсдэл, нөлөөллүүд бий болсон тохиолдолд төслийн нөлөөлөлд өртөх талуудтай хэлэлцэх арга замыг стратегид оруулах хэрэгтэй. Хэлэлцүүлгээс улбаалж БОНАТ-ийг шинэчилж, олон нийтэд түгээнэ.

Жишээ

Төслийн үе шат	Олон нийтэд түгээх мэдээллийн жагсаалт	Санал болгосон арга барил	Цагийн хуваарь: Байршил/огноо	Зорилтот бүлгийн оролцогч талууд	Гүйцэтгэлийн хувь	Хариуцагч
Бүтээн байгуулалт	Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө	100.6 Радио болон тосгоны төвд хэвлэмэл байдлаар зарлал түгээнэ  Олон нийтийн мэдээллийн мэдээллийн самбар дээр зурагт хуудас байршуулна	Долоо хоногийн хугацаанд радиогоор өдөрт хоёр удаагийн давтамжтай мэдээлнэ	Тосгоны иргэд. Үүнд явган хүн, жолоочид хамрагдана	100.6 Радиогоор дамжуулан тосгоны 60%-д мэдээлэл түгээсэн  Мэдээллийн самбар дээр зурагт хуудас байршуулсан, хүн амын тодорхой хувьд мэдээлэл түгээсэн	Олон нийттэй харилцах ажилтан

#### 4.3. Хэлэлцүүлэгт зориулж санал болгосон стратеги

Оролцогч талууд тус бүртэй хийх хэлэлцүүлэгт ашиглах арга барилыг товч тайлбарлана. Зорилтот бүлгээс хамаарч арга барилууд хоорондоо адилгүй байж болно:

- Оролцогч талууд болон холбогдох байгууллагуудтай ярилцлага хийх
- Судалгаа, санал асуулга авах
- Олон нийтийн уулзалт, сургалт зохион байгуулж, нийгмийн тодорхой бүлгийг цуглуулах
- Оролцооны арга
- Хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явцын уламжлалт бусад механизмууд

Жишээ

Төслийн үе шат	Хэлэлцүүлгийн сэдэв	Ашигласан арга барил	Цагийн хуваарь: Байршил/огноо	Зорилтот бүлгийн оролцогч талууд	Хариуцагч
----------------	---------------------	----------------------	-------------------------------	----------------------------------	-----------

Бүтээн байгуулалт	Замын аюулгүй байдал	Тосгоны сургуулиудт ай хийсэн хэлэлцүүлэг  Олон нийтийн уулзалтууд	АБВ бага сургуульд 9-р сарын 4-ны өдөр, 15:00 цагт.  А тосгоны төв байранд 9-р сарын 8-ны, 18:30 цагт..	Тосгоны эцэг эх, хүүхдүүд  Оршин суугчид	Олон нийттэй харилцах ажилтан (ОНХА)  Тээврийн инженер, Менежер, ОНХА
-------------------	----------------------	--	---	--	---

#### 4.4. Нийгмийн эмзэг бүлгийнхний байр суурийг нэгтгэх стратегийн санал

Төслийн олон нийттэй хэлэлцүүлэг өрнүүлэх ажилд нийгмийн эмзэг эсвэл хөгжлийн бэрхшээлтэй бүлгүүдийн үзэл бодол, байр суурийг хэрхэн сонсох талаар тайлбарлах. Төсөлд оролцоход учирч буй саад бэрхшээлийг арилгахаар ямар арга хэмжээ хэрэгжүүлэх вэ? Тэдэнтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, гомдлыг нь барагдуулахад тусгайлан зориулсан тусдаа механизм, төслийн өгөөжийг хүртээмжтэй байлгах арга зам бий болгох гэх мэт алхмууд байж болно.

#### 4.5. Цаг хугацааны дараалал

Төслийн үе шатууд, гол шийдвэрүүдтэй холбоотой цаг хугацааны товын талаар мэдээлэл өгөх. Санал хүсэлт хүлээн авах эцсийн хугацааг тодорхойлох.

#### 4.6 Санал хүсэлтүүдийн тойм

Санал хүсэлтийг хэрхэн хүлээн авч (санал хүсэлтийг бичгээр, амаар хүлээн авна), дүгнэж, эцсийн шийдвэрийн талаар оролцогч талуудад тайлагнах үүрэг амлалт өгч, санал хүсэлтийг хэрхэн анхааралдаа авах талаар тайлбарлах.

#### 4.7 Төслийн дараагийн үе шатууд

Төслийн хөгжүүлэлтийн явцад төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл, талуудын оролцоог дэмжих төлөвлөгөө, санал, гомдол шийдвэрлэх механизмын хэрэгжилтийн тайлан зэргийг боловсруулж, хүмүүст тогтмол мэдээлэл хүргэнэ гэдгийг ойлгуулна. Оролцогч талуудад жилд багадаа нэг удаа төслийн талаар тайлагнах хэрэгтэй ч төслийн нөлөөлөл илүү мэдрэгдэх үе шатанд болон төсөлд өөрчлөлт орох зэрэг хэрэгжилтийн явц эрчимжих үеэр тайланг илүү олон давтамжтай танилцуулах хэрэгтэй (жишээ нь бүтээн байгуулалтын үед улиралдаа нэг, хэрэгжүүлэлтийн үед жилдээ нэг удаа).

### 5. Талуудын оролцоог дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөц бололцоо, үүрэг хариуцлага

#### 5.1. Нөөц бололцоо

Талуудын оролцоог дэмжих төлөвлөгөөний зохицуулалт, хэрэгжүүлэлтийг хангахад ямар нөөц бололцоо хэрэгтэй байгааг харуулах. Тэр дундаа:

- a. ТОДТ-ийг ямар хүмүүс хариуцаж байгааг мэдээлэх

- b. Оролцогч талуудын оролцоог дэмжихэд хангалттай төсөв хуваарилсан болохыг баталгаажуулах
- c. Төсөл болон хэлэлцүүлгийн явцын талаар санал хүсэлт гаргах, асуулт асуух хүсэлтэй хүмүүст зориулж холбоо барих мэдээллээр хангах; утасны дугаар, хаяг, и-мэйл хаяг, хариуцсан хүний албан тушаал (хариуцсан хүмүүсийн нэр өөрчлөгдөх магадлалтай) гэх мэт.

## 5.2. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага

Талуудын оролцоог дэмжих үйл ажиллагааг төслийн менежментийн системтэй хэрхэн үялдуулахыг тайлбарлаж, Талуудын оролцоог дэмжих төлөвлөгөөг ямар албан тушаалтан хариуцаж, хэрэгжүүлэхийг тусгаж өгөх:

- a. Талуудын оролцоог дэмжих үйл ажиллагааг хэн хариуцаж явуулах, тэдгээр албан тушаалтнуудад тавигдах шаардлагууд нь юу байх вэ?
- b. Талуудын оролцоог дэмжихэд удирдлагууд ямар үүрэгтэй оролцох вэ?
- c. Төслийн үйл явцыг хэрхэн баримтжуулж, хянаж, зохицуулах вэ (жишээ нь оролцогч талуудын мэдээллийн сан, үүрэг амлалтуудыг бүртгэх, гэх мэт)?

## 6. Гомдол шийдвэрлэх механизм

Төслийн нөлөөлөлд өртөх хүмүүсийн гомдол мэдүүлэх, цаашлаад төслийг хариуцсан удирдлагуудад хүргүүлэх процесс, мөн тэдгээрийг хэрхэн анхааралдаа авч, шийдвэрлэх талаар тайлбарлах:

- a. Гомдол шийдвэрлэх албан болон албан бус механизм байгаа эсэх. Хэрэв тийм бол тэр нь БОНС10-ын шалгуурыг хангаж байгаа юу? Үүнийг ашиглах боломжтой юу? эсвэл шинэ механизм шаардлагатай юу?
- b. Гомдол шийдвэрлэх механизм нь тухайн соёлд нийцсэн эсэх. Олон нийтийн асуудлыг шийдвэрлэхэд соёлын хувьд зохистой байж чадах үү? Жишээлбэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хамтад нь бусад тусад нь уулзалт зохион байгуулдаг соёлтой улсад төслийн санал, гомдол шийдвэрлэх үйл явцад эмэгтэй хүн эмэгтэйчүүдийн асуудлыг хөндөж чадах үү?
- c. Гомдол, асуудлыг баримтжуулахад ямар арга зам ашиглаж байгаа вэ? Олон нийтээс ирүүлсэн гомдлыг хэн хүлээж авах вэ? Тэдгээрийг хэрхэн бүртгэж, хянах вэ?
- d. Асуудлуудыг хүлээн авч, шийдвэрлэхэд хэдий хугацаа шаардах вэ? Шийдвэрлэх явцад гомдол гаргагчтай холбогдож ажиллах үү?
- e. Гомдол шийдвэрлэх механизмын талаар оролцогч талуудад хэрхэн мэдээлэх вэ? Нийгмийн эмзэг бүлгийн оролцогч талуудад зориулсан тусдаа процессууд шаардлагатай юу?
- f. Тухайн гомдлыг шалгах нь зохимжгүй гэж үзвэл гомдол гаргагч талд тухайн шалгалтыг яагаад зохимжгүй гэж үзэж байгаа талаар тайлбар өгөх үү?
- g. Гомдлыг шийдвэрлэхээр санал болгосон шийдэл нь гомдол гаргагч талд хангалтгүй санагдвал шүүхэд хандах шат дамжлага бий юу? Шүүхэд өргөдөл гаргах шат дамжлага нь төсөл бүрд шаардагдахгүй ч багц төслүүдэд нэг байх нь зохимжтой. Ямар ч нөхцөлд гомдол гаргагч нь тухайн улсын шүүхийн байгууллагад хандах хууль ёсны эрхтэй болохыг нь сануулж, хэлж өгөх хэрэгтэй.
- h. Гомдол шийдвэрлэх механизмын хэрэгжилтийн тоймыг олон нийтэд тогтмол мэдээлэх хэрэгтэй. Ингэхдээ гомдол гаргагчийн хувийн мэдээллийг хамгаалах үүднээс түүнтэй холбогдох мэдээллийг хасах нь зүйтэй. Гомдолтой холбоотой үйл явц хэрэгжиж байгаа талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр ямар давтамжаар тайлагнах вэ?

## **7. Хяналт, тайлан**

### **7.1. Хяналтын үйл ажиллагаанд талуудыг хамруулах тухай**

Зарим төсөл болон төсөлтэй холбоотой сөрөг нөлөөллийн хяналтын шатанд гуравдагч этгээдийн үүргийг тусгаж өгнө. Төслийн нөлөөлөл, тэдгээрийг арилгах хөтөлбөрийн хяналтад төсөлд оролцогч талууд эсвэл хяналт явуулах гуравдагч этгээдийг оролцуулах төлөвлөгөө байгаа эсэхийг тодорхойлно. Гуравдагч этгээдийг сонгох шалгуур нь тодорхой байх хэрэгтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг Дэлхийн Банкны Хяналт хариуцсан гуравдагч этгээдийн сайн туршлагын талаарх тэмдэглэлээс харна уу.

### **7.2. Талуудад эргэж тайлагнах тухай**

Талуудын оролцоог дэмжих үйл ажиллагааны үр дүнг талууд болон өргөн хүрээн оролцогчдод хэзээ, хаана, хэрхэн тайлагнах талаар тайлбарлана. Эдгээр тайлангуудыг танилцуулахдаа талуудыг тодорхойлоход ашигласан харилцаа холбооны эх үүсвэрээ ашиглах нь зүйтэй. Гомдол шийдвэрлэх механизмын талаар оролцогч талуудад тогтмол сануулж байх хэрэгтэй.

## **ХАВСРАЛТ 4: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ БА БОННУ, БОНМТ-НИЙ ЖИШИГ ЗАГВАР**

---

Зээлдэгч нь төсөл хэрэгжих хугацааны турш уг төслийн байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл болон нөлөөг үнэлэхэд чиглэсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийж гүйцэтгэнэ. 'Байгаль орчин, нийгмийн үнэлгээ' гэдэг нь Зээлдэгч төслийн зүгээс байгаль орчин, нийгэмд учруулах нөлөө ба эрсдлүүдийг олж тогтоох, тэдгээрээс сэргийлэх, мөн багасгах, бууруулах, сулруулах зэрэг зорилгоор авч хэрэгжүүлэх дүн шинжилгээ, төлөвлөлтийн үйл ажиллагаануудыг тодорхойлсон ерөнхий нэршил юм.

Төслүүдийг байгаль орчин, нийгмийн хувьд найдвартай, тогтвортой байлгах гол арга зам бол байгаль орчин, нийгмийн үнэлгээ бөгөөд уг үнэлгээг шийдвэр гаргалтын түвшинд бүрэн мэдээлэл өгөх зорилгоор ашигладаг. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь тухайн төслийн нарийн шинж чанар болон Зээлдэгчийн нөхцөл байдал зэргээс хамааран өөр өөр төрлийн хэрэгсэл, арга барил ашиглан гүйцэтгэж болох уян хатан шинжтэй үйл ажиллагаа юм.

Байгаль орчин, нийгмийн үнэлгээг БОНС1-ийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх шууд, шууд бус, хуримтлагдсан зэрэг бүхий л эрсдэл, нөлөөллүүдийг цогц байдлаар авч үзнэ. Тэдгээрт БОНС1-ээс БОНС10-т тус бүр нэрлэгдсэн зүйлс мөн багтана. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд гүйцэтгэсэн дүн шинжилгээний хамрах хүрээ, хэр хэмжээ, төрөл нь тухайн төслийн шинж чанар, цар хүрээ, мөн түүнчлэн үр дүнд нь гарч болохуйц байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөлөл зэргээс хамаарна. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийж гүйцэтгэхдээ гарч болох боломжит эрсдэл, нөлөөллүүдийн хэмжээ, шинж чанартай уялдаа холбоотой байлгана.

Байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийж гүйцэтгэх арга зам, мөн шийдвэрлэх шаардлагатай асуудлууд нь төсөл тус бүрд өөр өөр байна. Зээлдэгч нь энэ хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлохдоо Банктай зөвшилцөх бөгөөд ингэхдээ судалгаа тооцоо, оролцогч талуудын оролцоо, гарч болохуйц байгаль орчин, нийгмийн асуудлууд, Банк болон Зээлдэгчийн хооронд үүссэн тодорхой асуудлууд зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь байгаль орчин, нийгэмд учруулж болохуйц бүхий л томоохон эрсдлүүд болон нөлөөллүүдийг олж тогтоон, шийдвэрлэхийн тулд, ялангуяа эхний шатандаа, нөлөөнд өртсөн хүмүүс болон бусад сонирхогч талуудын уялдаа холбоо, тэдний зөвшилцөл зэргийг оролцуулсан буюу тооцож үзсэн байна.

Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийж гүйцэтгэхдээ, түүнчлэн энэ төрлийн үнэлгээний үр дүнг баримтжуулахдаа ашиглах өөр өөр төрлийн арга хэрэгслүүд болон сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд зэрэг нь төслийн үндсэн шинж чанар, цар хүрээтэй харилцан хамааралтай байна. БОНС1-д дурдсанаар, үүнд дурдсан зүйлсийн нийлбэрүүд эсвэл бүрэлдэхүүн хэсгүүд багтана:

### **a. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)**

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) гэдэг нь тухайн санал болгосон төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болохуйц нөлөөллийг тодорхойлж үнэлэх, боломжит хувилбаруудыг дүгнэх мөн сөрөг нөлөөллийг бууруулах, менежментийн, хяналт шалгалтын зэрэг тохирох арга хэмжээнүүдийг боловсруулах зорилго бүхий хэрэгсэл юм.

### **b. Байгаль орчин, нийгмийн аудит**

Байгаль орчин, нийгмийн аудит гэдэг нь тухайн төслийн болон үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн салбарыг хамарсан бүхий л асуудлуудын шинж чанар, хамрах хүрээг тодорхойлох хэрэгсэл юм. Тус аудит нь холбогдох асуудлуудыг багасгахад чиглэсэн үндэслэл бүхий арга хэмжээ, үйл ажиллагаануудыг тодорхойлж, тухайн арга хэмжээ, үйл ажиллагаануудад шаардагдах зардлыг тооцон, тэдгээрийг хэрэгжүүлэхэд тохирсон төлөвлөгөөг санал болгоно. Зарим тодорхой төслүүдэд, байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь зөвхөн байгаль орчин эсвэл нийгмийн аудитаас бүрддэг бол бусад тохиолдолд аудит нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг байдаг.

#### **с. Аюул, эрсдлийн үнэлгээ**

Аюул, эрсдлийн үнэлгээ нь төслийн талбай дээр аюултай бараа материал эсвэл аюултай нөхцөл бий болсон тохиолдолд түүнтэй холбогдох аюул эрсдлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийх, хяналт тавихад чиглэсэн хэрэгсэл юм. Шатах, дэлбэрэх, урвалд орох материал болон хортой бодис зэргийг ашиглах шаардлагатай төслүүдийн хувьд тухайн материалууд нь тогтоож өгсөн доод хэмжээнээс их хэмжээгээр байгаа үед Банкны зүгээс аюул, эрсдлийн үнэлгээг шаардана. Зарим тодорхой төслүүдэд, байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь зөвхөн аюул, эрсдлийн үнэлгээнээс бүрддэг бол бусад төслүүдийн хувьд аюул, эрсдлийн үнэлгээ нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг байдаг.

#### **д. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ**

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь тухайн төслийн хуримтлагдах нөлөөллийг өнгөрсөн, одоо, мөн ирээдүйд тохиолдож болохуйц үндэслэл бүхий холбогдох үйл явцуудаас урган гарах нөлөөлөл, түүнчлэн төлөвлөгөөгүй хэдий ч урьдчилан таамаглах боломжтой, цаашид эсвэл өөр байршилд ч тохиолдож болзошгүй төслийн хүрээний үйл ажиллагаануудыг хамтад нь тооцож үздэг хэрэгсэл юм.

#### **е. Нийгмийн ба зөрчлийн дүн шинжилгээ**

Нийгмийн ба зөрчлийн дүн шинжилгээ гэдэг нь (а) уг төсөл нийгмийн дотор оршин байгаа сөргөлдөөн, тэгш бус байдлыг дэвэргэж болзошгүй байдал (төслийн нөлөөнд өртсөн нийгмийн бүлгийн дотор болон тэдгээр бүлгүүд ба бусад бүлгүүдийн хоорондын); (б) төслийн зүгээс тогтвортой байдал болон хүний аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл; (с) мөн оршин буй сөргөлдөөн, зөрчил, тогтворгүй байдал, тэр дундаа дайн дажин, бослого, үймээн самуун зэрэг нөхцөл байдал нь төсөлд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл зэргийн түвшнийг тус тус үнэлэх хэрэгсэл юм.

#### **ф. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)**

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) нь (а) байгаль орчин, нийгэмд учруулах сөрөг нөлөөллийг арилгах, тэдгээрээс зайлсхийх эсвэл зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багасгах зорилгоор төслийн хэрэгжилтийн болон төслийн үйл ажиллагааны турш авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, түүнчлэн (б) тэдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлуудыг дэлгэрэнгүй тусгасан байна.

#### **г. Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын баримт бичиг (БОНМБББ)**

Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын баримт бичиг (БОНМБББ) гэдэг нь аливаа төслийн хүрээнд хөтөлбөр болон/буюу дэд төслүүд хэрэгжих тохиолдолд эсвэл тухайн төслийн болон дэд төслийн талаарх нарийвчилсан мэдээлэл тодорхой болох хүртэл эрсдэл, нөлөөллийг тодорхойлох боломжгүй байгаа тохиолдолд холбогдох эрсдэл болон нөлөөллийг хянан судалдаг хэрэгсэл юм.

БОНМБББ нь байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл, нөлөөллийг үнэлэхэд чиглэсэн зарчим, дүрэм журам, зааварчилгаа, процедурыг агуулсан байна. Мөн сөрөг эрсдэл, нөлөөллийг арилгах, бууруулах ба/эсвэл тэдгээрээс зайлсхийх зорилго бүхий арга хэмжээ, төлөвлөгөөнүүд, тухайн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, төсөвтэй холбогдсон заалтууд, төслийн эрсдэл, нөлөөллийн асуудлуудыг шийдвэрлэх үүрэг бүхий агентлаг буюу агентлагуудын тухай мөн тэдний байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл, нөлөөллийг удирдан зохион байгуулах чадавхийн талаарх мэдээлэл зэрэг багтсан байна. Түүнчлэн ямар дэд төслүүдийг аль аль газарт байршуулахаар төлөвлөж буй талаар, тухайн газрынх нь болзошгүй байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын тухай, түүнчлэн учирч болзошгүй нөлөөллүүд, тэдгээрийг багасгахын тулд авч хэрэгжүүлэхээр тооцоолж буй арга хэмжээнүүдийн талаар зохих мэдээллүүдийг багтаана.

Төслийн зарим онцлогоос шалтгаалан Зээлдэгч нь үнэлгээг хийж гүйцэтгэхдээ зарим тусгайлсан арга барил, хэрэгслийг ашиглах шаардалагатай болж болзошгүй. Жишээ нь, Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, Амжиргааг сэргээх төлөвлөгөө, Уугуул иргэдийн төлөвлөгөө, Биологийн төрөл зүйлийн ажлын төлөвлөгөө, Соёлын өвийн менежементийн төлөвлөгөө болон Банктай тохиролцсоны дагуу бусад төлөвлөгөөнүүд энд хамаарна.

Зээлдэгч нь төслийн боловсруулалтын шатандаа аль болох эрт байгаль орчин, нийгмийн үнэлгээг эхлүүлэх нь зүйтэй. Зээлдэгч нь мөн аль болох эртнээс Банктай зөвлөлдөж эхлэх нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг анхнаас нь БОНС-ын хүрээнд тавигдах шаардлагуудыг хангасан байхаар боловсруулахад тустай.

#### **БОННУ-ний жишиг загвар**

Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулж байгаа үед түүнд дараах зүйлсийг агуулсан байна:

- a. Ерөнхий Хураангуй
  - Онцлох үр дүн, санал болгож буй үйл ажиллагаануудыг товч тодорхой хураангуйлсан байна.
- b. Хууль эрх зүйн болон Институцын орчин
  - Байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийгдэж буй төсөлтэй холбогдох хууль эрх зүй, институцын орчинд дүн шинжилгээ хийнэ. Үүнд БОНС1-д тусгагдсан асуудлууд мөн хамаарна.
  - Зээлдэгчийн одоогийн байгаль орчин, нийгмийн бодлогын баримт бичгүүдийг БОНС-уудтай харьцуулж, хоорондын зааг ялгаануудыг олж тогтооно.
  - Хамтран санхүүжүүлэгчдийн зүгээс тавих байгаль орчин, нийгмийн чиглэлийн холбогдох шаардлагуудыг олж тогтоон, үнэлнэ.
- c. Төслийн танилцуулга
  - Санал болгосон төсөл болон түүний газарзүй, байгаль орчин, нийгмийн чиглэлийн болон төслийн талбайгаас гадна хийгдэх хөрөнгө оруулалт (жишээ нь, зориулалтын дамжуулах хоолой, нэвтрэх зам, эрчим хүчний болон усан хангамж, орон байр, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах байгууламж) гэх мэт тодорхой цаг хугацааг хамарсан асуудлууд, түүнчлэн төслийн гол ханган нийлүүлэгчдийн талаар товч тодорхой танилцуулсан байна.
  - Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн тусламжтайгаар БОНС1-ээс 10 хүртэл дурдагдсан шаардлагуудыг хангахад чиглэсэн ямар нэгэн төлөвлөгөө хэрэгтэй эсэхийг энд мөн харуулна.



- Төслийн талбай болон төслийн шууд, шууд бус, хуримтлагдсан нөлөөлөлд өртөх хэсгүүдийг нарийвчлан харуулсан зураглалтай байна.
- d. Суурь өгөгдөл
- Төслийн байршил, загвар, үйл ажиллагаа, мөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаарх шийдвэрүүдтэй холбогдох суурь мэдээллийг дэлгэрэнгүй агуулсан байна. Үүнд тухайн өгөгдлийн болон мөн төслийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх цаг хугацаатай холбогдсон мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал, эх сурвалжийг нягтлан судалсан байна.
  - Бэлэн байгаа өгөгдөл, голлох өгөгдлийн зөрүү, таамаглалаас үүдэн гарах тодорхой бус байдал зэргийн хамрах хүрээ, шинж чанарыг тодорхойлж, шинжилнэ.
  - Одоо байгаа мэдээлэл дээрээ үндэслэн, судлагдах газруудын хамрах хүрээг үнэлж, холбогдох материаллаг, биологийн болон нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, түүний дотор төсөл эхлэхээс өмнө тохиолдож болзошгүй аливаа өөрчлөлт зэргийг тайлбарласан байна.
  - Төсөлтэй шууд холбоогүй ч төслийн төслийн хүрээнд хамрагдах одоо үргэлжилж буй болон санал болгосон бүтээн байгуулалтын үйл ажиллагаануудыг энд харгалзан үзнэ.
- e. Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөлөл
- Төслийн байгаль орчин, нийгэмд учруулах бүхий л эрсдэл, нөлөөллүүдийг энд хамруулна. Үүнд ялангуяа БОНС2-8-д тусгайлан дурдсан байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллүүд, мөн БОНС1-д тодорхойлсон эрсдэл, нөлөөллүүд гэх мэт тухайн төслийн онцлог шинж чанар, нөхцөл байдлаас урган гарах байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөллүүд багтана.
- f. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд
- Нөлөөлийг багасгахад чиглэсэн арга хэмжээнүүд болон сөрөг нөлөөллийг нь бууруулж чадаагүй үлдэх томоохон нөлөөлөл зэргийг энд олж тодорхойлно. Мөн тэдгээр арга хэмжээний үр дүнд үлдсэн сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрөх нөхцөл боломжийг тодорхой хэмжээнд тооцож гаргана.
  - Үзүүлэх сөрөг нөлөөг таатай нөхцөл боломжоор хангагдаагүй эсвэл эмзэг бүлгийн хүмүүст хэт их хэмжээнд байлгахгүйн тулд авч хэрэгжүүлэх ялгавартай арга хэмжээнүүдийг тодорхойлно.
  - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах боломж, санал болгосон сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн болон урсгал зардал, тухайн орон нутгийн нөхцөл байдалд хэр тохирох эсэх, мөн санал болгосон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд тавигдах институцын, сургалтын болон хяналт шалгалтын чиглэлийн шаардлагуудыг үнэлнэ.
  - Нөхцөл байдлыг харгалзан нэмэлт анхаарал тавих шаардлагагүй тодорхой асуудлууд.
- g. Боломжит хувилбаруудын дүн шинжилгээ
- Санал болгосон төслийн талбай, технологи, загвар, үйл ажиллагаа, үүн дотор “төслөөс гадуур” гэсэн нөхцөл байдлыг тэдгээрийг орлох боломжит хувилбаруудтай нь хооронд нь тодорхой аргачлалын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийг нь харгалзан үзэж харьцуулна.
  - Тухайн боломжит хувилбаруудын байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах боломж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн боломжит өөр хувилбаруудад шаардагдах хөрөнгийн болон урсгал зардал, тэдгээрийн тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохиромжтой эсэх, мөн сөрөг

нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн боломжит өөр хувилбаруудад тавигдах институцын, сургалтын болон хяналт шалгалтын чиглэлийн шаардлагуудыг тус тус үнэлсэн байна.

- Боломжит хувилбар тус бүрийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тоон хэмжээгээр илэрхийлж, боломжтой бол, эдийн засгийн өртгийг нь хавсаргана.
  
- h. Загвартай холбоотой арга хэмжээнүүд
  - Тухайн төсөлд санал болгосон тодорхой загварыг сонгох үндэслэл нь юу болохыг танилцуулж, тохирох БОЭМАБЗ-ийг зааж өгнө. Хэрвээ тохирох БОЭМАБЗ байхгүй гэж үзвэл GIIP буюу Олон Улсын Аж Үйлдвэрийн Сайн Туршлагатай нийцсэн бохирдлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга зам, ялгарлын зохистой түвшин зэргийг тайлбарласан байна.
  
- i. Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөөний (БОНАТ) голлох арга хэмжээ, үйл ажиллагаа
  - Төсөл нь БОНС-уудын хүрээнд тавигдах шаардлагуудыг хангасан байхын тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээ, үйл ажиллагаанууд, цаг хугацааны төлөвлөгөөг хураангуйлсан байна. Үүнийг Байгаль Орчин, Нийгмийн Амлалтын Төлөвлөгөөг (БОНАТ) боловсруулахад ашиглана.
  
- j. Хавсралтууд
  - Байгаль орчин, нийгмийн үнэлгээг боловсруулсан болон хувь нэмэр оруулсан хүмүүс, байгууллагуудын жагсаалт.
  - Ашигласан материал—Хэвлэгдэж гарсан болон хэвлэгдэж гараагүй байгаа материалуудыг жагсаана.
  - Нөлөөнд өрсөн хүмүүс болон бусад сонирхогч талууд гэх мэт оролцогч талуудын оролцсон уулзалт, зөвлөлдөөн, судалгааны тэмдэглэлүүд. Уг баримт нь нөлөөнд өртсөн болон сонирхогч талуудын санаа бодлыг мэдэж авахын тулд ашигласан оролцогч талуудын оролцоог хангах арга хэрэгслүүдийг харуулна.
  - Гол материалд дурдагдсан эсвэл хураангуйлагдсан мэдээлэл, тоо баримтуудыг харуулсан хүснэгтүүд.
  - Холбогдох тайлан, төлөвлөгөөний жагсаалт.

### **БОНМТ-ний жишиг загвар**

БОНМТ нь төслийн хэрэгжилт болон үйл ажиллагааны шатанд авч хэрэгжүүлэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдлийг арилгах, тэдгээрээс зайлсхийх, эсвэл зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багасгахад чиглэсэн нөлөөллийг бууруулах, хяналт шалгалтын болон институцын цогц арга хэмжээнүүдээс бүрдэнэ. Мөн БОНМТ-нд нь тэдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээ, үйл ажиллагаанууд багтсан байна. Зээлдэгч нь (а) тохиолдож болзошгүй сөрөг нөлөөллийн эсрэг авах цогц хариу арга хэмжээнүүдийг тодорхойлон; (б) тэдгээр хариу арга хэмжээнүүдийг үр дүнтэй, цагаа олсон байхад тавигдах шаардлагуудыг тогтоон; мөн (с) тэдгээр шаардлагуудыг хэрхэн хангах арга замуудыг олж тогтооно.

Тухайн төслөөс шалтгаалан БОНМТ-ийг бие даасан баримт бичиг хэлбэрээр эсвэл БОНАТ-ний нэг бүрэлдэхүүн хэсэг хэлбэрээр боловсруулна. БОНМТ нь дараах агуулгатай байна:

- a. Нөлөөллийг бууруулах

- БОНМТ нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх боломжит сөрөг нөлөөллийг зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулах нөлөөллийг бууруулах шатлалын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаануудыг тодорхойлно. Тохиромжтой бол, уг төлөвлөгөөнд нөхөн олговрын арга хэмжээнүүд багтана. Тухайлбал, БОНМТ нь: (i) байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй бүхий л сөрөг нөлөөллийг тодорхойлж, хураангуйлсан (уугуул иргэдтэй хамааралтай болон хүчээр нүүлгэн шилжүүлэх тохиолдлууд мөн орно); (ii) нөлөөллийг бууруулах арга хэмжээ тус бүрийг түүнд хамаарах нөлөөллийн хэлбэр болон тус нөлөөлөлд тавигдах нөхцлийнх нь хамт (жишээ нь, байнгын эсвэл урьдчилан хараагүй нөхцөл байдлын үед), мөн оновчтой бол, загварууд, төхөөрөмжийн үзүүлэлт тайлбар, үйл ажиллагааны журам зэргийг техникийн нарийвчлалтай тайлбарласан; (iii) тэдгээр арга хэмжээнүүдийн байгаль орчин, нийгмийн боломжит нөлөөллийг тооцсон; (iv) төсөлд шаардлагатай нөлөөллийг бууруулахад чиглэсэн бусад төлөвлөгөөг (жишээ нь, албадан нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд, соёлын өв) тооцож үзсэн буюу тэдгээртэй уялдаа холбоотой байна.
- b. Хяналт шалгалт
  - БОНМТ нь хяналт шалгалтын хүрээнд тавигдах зорилтуудыг үүнд тодорхойлохын хажуугаар хяналт шалгалтын төрлийг тэдгээрийн байгаль орчин, нийгмийн үнэлгээнд дүгнэгдсэн нөлөөллүүд, мөн БОНМТ-нд дурдагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд зэрэгтэй холбогдох уялдаа холбооных нь хамт тодорхой зааж өгнө. Тухайлбал, БОНМТ-ний хяналт шалгалтын хэсэгт дэлгэрэнгүй танилцуулга, мөн хэмжилт хийгдэх үзүүлэлт, хэрэглэгдэх арга барил, түүвэрлэлт хийх байршил, хэмжилтийн давтамж, илрүүлэх хязгаар (тохиромжтой бол) зэрэг хяналт шалгалтын арга хэмжээнүүд, мөн засч сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байгаа эсэхийг тодорхойлох хүчин зүйлсийн талаар тус тус тусгасан байна. Үүнээс гадна тус хэсэгт (i) нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл байдлыг эрт олж илрүүлэх болон (ii) нөлөөллийг бууруулах ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллээр хангах зорилго бүхий b) хяналт шалгалтын болон тайлагнах журмууд байна.
- c. Чадавхжуулалт ба сургалт
  - Байгаль орчин, нийгмийн төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг зөв цаг хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БОНМТ нь ажил үүрэг хариуцан ажиллаж буй талууд эсвэл агентлаг болон яамны түвшний холбогдох талуудын байгаль орчин, нийгмийн үнэлгээ, тэдний гүйцэтгэх үүрэг болон чадварыг нөөц болгон ашигладаг.
  - Тухайлбал, БОНМТ-нд аль тал нь нөлөөлөл бууруулах болон хяналт шалгалтын арга хэмжээнүүдийг (жишээ нь, үйл ажиллагаа, хяналт, дүрэм журмын хэрэгжилт, хэрэгжилтийг хянан шалгах, засан сайжруулах арга хэмжээ, санхүү, тайлан, ажилтнуудыг сургах гэх мэт) гүйцэтгэх үүрэгтэй болохыг тодорхойлсон институцын нарийн зохицуулалтууд тусгагдсан байна.
  - Хэрэгжүүлэх үүрэг бүхий агентлагуудын байгаль орчин, нийгмийн менежментийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор БОНМТ нь үүрэг хүлээн ажиллах талуудыг бүрдүүлэх болон өргөтгөх, ажилтнуудыг сургах зэрэг асуудлаар мөн нөлөөллийн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн шаардлагатай нэмэлт арга хэмжээнүүдийн талаар зөвлөмж өгөхөөс гадна байгаль орчин, нийгмийн үнэлгээтэй холбогдох бусад төрлийн зөвлөмжөөр хангана.
- d. Хэрэгжүүлэх хуваарь ба зардлын тооцоо

- Бүх гурван хэсгийн хувьд (нөлөөллийг бууруулах, хяналт шалгалт, чадавхи бэхжүүлэх) БОНМТ-нд (а) төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хийж гүйцэтгэх хуваарь багтсан байх бөгөөд энэ нь төслийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнүүдтэй зохицож уялдсан байна. Түүнчлэн (b) БОНМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн болон урсгал зардлын тооцоо, тэдгээрийн эх үүсвэрийг харуулсан байна. Төслийн нийт зардлын хүснэгтэд эдгээр тоог мөн нэгтгэсэн байна.
- e. БОНМТ-г Төсөлтэй нэгтгэх
  - Зээлдэгчийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шийдэр, үүнийг нь Банкны зүгээс дэмжиж буй шийдвэр нь БОНМТ нь (бие даасан эсвэл БОНАТ-ний нэг хэсэг байдлаар) үр дүнтэй хэрэгжиж чадна гэсэн хүлээлт дээр тус тус үндэслэнэ. Ингэснээр нөлөөллийг бууруулах болон хяналт шалгалтын арга хэмжээ, үйл ажиллагаанууд, өөр хоорондоо холбоотой институцын үүрэг хариуцлага зэрэг арга хэмжээ, ажил тус бүр тодорхой тусгагдсан байх бөгөөд хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлуудыг төслийн ерөнхий төлөвлөлт, загвар, төсөв, хэрэгжилт зэрэгтэй нэг дор авч үзнэ.

## **ХАВСРАЛТ 5: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР**

---

БОНС5-д төсөлтэй холбоотой хийгдэх газар чөлөөлөлт болон газар ашиглалтын хязгаарлалт нь оршин суугчид, хүн амд сөрөг нөлөө үзүүлж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Төсөлтэй холбоотой газар чөлөөлөлт, эсвэл газар ашиглалтын хязгаарлалтын улмаас биет шилжилт хөдөлгөөн хийх (нүүлгэн шилжүүлэлт, оршин суугаа газар, байр сууцаа алдах), эдийн засгийн шилжилт хийх (газар, хөрөнгө, эсвэл хөрөнгө хүртэх боломжоо алдах, үүнээс шалтгаалсан орлогын эх үүсвэр болон амьжиргааг тэтгэх бусад боломжоо алдах), эсвэл хоёуланд нь өртөх тохиолдол гарч болзошгүй. Эдгээр нөлөөлөл нь “албадан нүүлгэх” гэдэг нэр томъёонд хамаарна. Нөлөөлөлд өртөж буй хүн, оршин суугчид газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалтыг эсэргүүцэх эрхгүйн улмаас шилжин нүүх шаардлагатай бол түүнийг албадан нүүлгэн шилжүүлэлт гэж үзнэ.

### **1. Зорилтууд**

Дараах зорилтуудтай байна:

- a. Албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд, төслийн загварын боломжит бусад хувилбаруудыг судалж үзэх замаар албадан нүүлгэн шилжүүлэлтийг бууруулах.
- b. Хүч хэрэглэн нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх.
- c. Газар чөлөөлөлт эсвэл газар ашиглалтын хязгаарлалтын улмаас байгаль орчин, нийгэмд зайлшгүй учруулах сөрөг нөлөөлийг дараах хоёр аргаар бууруулах. Үүнд (a) алдагдсан хөрөнгийг нь орлуулалтын өртөгийн дагуу цаг алдалгүй нөхөн олгох (b) нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийг өөрсдийн амжиргаа болон амьдралын чанараа сайжруулах эсвэл нүүн шилжихээс өмнөх түвшин хүртэл эсвэл төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх түвшний аль илүү сайн түвшинд нь хүртэл бодитоор сэргээн босгоход нь туслалцаа үзүүлэх.
- d. Тохирох орон сууц, үйлчилгээ, хэрэгсэл, эзэмшлийн баталгаа зэргээр хангах замаар нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн ядуу болон эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралын нөхцлийг сайжруулах
- e. Төслийн үндсэн нөхцөлтэй тохирч байгаа тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс тус төслөөс шууд байдлаар ашиг түс хүртэх бололцоогоор хангахуйц хэмжээний хөрөнгө оруулалтын нөөц бүхий тогтвортой хөгжлийн хөтөлбөр зэрэг албадан нүүлгэхтэй холбогдсон ажлуудыг боловсруулж, хэрэгжүүлэх.
- f. Албадан нүүлгэхтэй холбоотой ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ зохистой мэдээллээр хангаж, ач холбогдол бүхий зөвлөлдөөнийг зохион байгуулж, мөн нөлөөнд өртсөн талуудын оролцоог хангах хэрэгтэй.

### **2. Хэрэглэх Хүрээ**

БОНС1-т дүрслэгдсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээнийн хүрээнд БОНС5-ын хэрэглээний хүрээг тогтооно. Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн эсвэл ногдуулсан дараах төрлийн газар чөлөөлөлт эсвэл газар ашиглалтын хязгаарлалтын үр дүнд бий болсон байнгын болон түр хугацааны нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн шилжилтийн үед энэхүү БОНС-ыг хэрэглэнэ:

- a. Газрын эрх эсвэл газар ашиглалтын эрхийг үндэсний хуулийн дагуу албадан хураах болон бусад албадлагын шинжтэй аргаар олж авсан эсвэл хязгаарласан;

- b. Газрын эрх, газар ашиглалтын эрхийг олж авах болон хязгаарлахдаа өмчийн эсвэл тухайн газрын хууль ёсны эрхийг эзэмшигчтэй яриа хэлэлцээ хийж, тохиролцоонд хүрсэн, тохиролцоонд хүрэх аргагүйн улмаас албадан хураах болон бусад албадлагын шинжтэй аргыг хэрэглэх шаардлагатай болсон тохиолдолд;
- c. Аливаа нийгмийн бүлэг доторх оршин суугчид болон бүлэг нь тухайн нөөцийг уламжлал, хэвшмэл хэлбэрээр эзэмшиж ирсэн нөөцөө ашиглах эрх, эсвэл хүлээн зөвшөөрөхүйц ашиглалтын эрхээ алдахад хүргэж буй газар ашиглалт болон байгалийн нөөцийн ашиглалтад тогтоосон хязгаарлалтууд. Үүнд төсөлтэй холбогдуулан хуулийн дагуу тогтоож өгсөн хамгаалалтын бүс, ой, биологийн төрөл зүйл бүхий газар эсвэл буфер бүсүүдийг байгуулсан тохиолдлууд мөн хамаарч болно;
- d. Албан ёсны, уламжлалт, хүлээн зөвшөөрөхүйц эрхгүй ч төслийн ажил эхлэх шаардлагатай сүүлийн өдрөөс өмнөх хугацаанд тухайн газрыг эзэмшиж, ашиглаж байгаа хүмүүсийг сэлгэн суурьшуулах;
- e. Төслийн нөлөөллийн улмаас газар нь ашиглах, хүрэх боломжгүй болсон хүмүүсийг шилжүүлэх тохиолдолд;
- f. Газар эсвэл бусад төрлийн нөөц, жишээлбэл, нийтийн өмч мөн далайн ба усны нөөц, мод ба бусад төрлийн ойн бүтээгдэхүүн, цэвэр ус, эмийн ургамал, ан гөрөө хийх ба хураах газар, бэлчээрийн ба тариалангийн газар гэх мэт байгалийн нөөцийг ашиглах боломжид тавигдсан хязгаарлалт;
- g. Нөхөн олговроо бүтэн авалгүйгээр хувь хүмүүс, оршин суугчдын татгалзсан газрын эрх эсвэл газар эзэмших нэхэмжлэл, эсвэл нөөц;
- h. Төслөөс өмнөх хугацаанд хамаарах ч тухайн төсөлд зориулж, эсвэл түүний бэлтгэл болгон хийгдсэн эсвэл эхлүүлсэн газар чөлөөлөлтийн ба газар ашиглалтын хязгаарлалтууд.

Орлого, амжиргаа зэрэгт үзүүлсэн аливаа нөлөөллүүд нь төслийн хүрээнд тавигдсан газар чөлөөлөлтийн ба газар ашиглалтын хязгаарлалтын шууд үр дүн биш бол энэхүү БОНС-д хамаарахгүй. Энэ төрлийн нөлөөллүүдийн талаар БОНС1-д бичсэн.

### **3. Тавигдах шаардлагууд**

#### **3.1 Ерөнхий**

##### **Хамрагдах ангилал**

Нөлөөнд өртсөн хүмүүсийг дараах байдлаар ангилж болно: (a) Газар болон хөрөнгийг эзэмших албан ёсны, хууль ёсны эрхтэй хүмүүс; (b) Газар болон хөрөнгийг эзэмших албан ёсны, хууль ёсны эрхгүй ч улсын хуулийн дагуу тухайн газар, хөрөнгийг эзэмшихийг нь зөвшөөрч болохуйц баталгаа бүхий хүмүүс; эсвэл (c) Ашиглаж буй эсвэл эзэмшиж буй газар болон хөрөнгөө эзэмших хүлээн зөвшөөрөхүйц хууль ёсны эрх, баталгаагүй хүмүүс.

##### **Төслийн загвар**

Албадлагын шинжтэй газар чөлөөлөлтийн ба газар ашиглалтын хязгаарлалтууд нь зөвхөн өгөгдсөн тодорхой цаг хугацаа, зорилгын хүрээнд тавигдсан төслийн шаардлага байх болно гэдгийг Зээлдэгчийн зүгээс нотлон харуулна. Зээлдэгч нь газар чөлөөлөх болон газар ашиглалтад тавигдах хязгаарлалтууд, ялангуяа албадан нүүлгэх, эдийн засгийн шилжилт хийх шаардлагатай болсон тохиолдолд, тэдгээрээс

зайлсхийх эсвэл багасгахад чиглэсэн төслийн боломжит загваруудыг судалж үзнэ. Ингэхдээ байгаль орчин, нийгэм, санхүүгийн өртөг, өгөөжийн тэнцвэрийг ханган, жендэрийн нөлөөлөл, ядуу, эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нөлөөлөл зэрэгт давхар анхаарах шаардлагатай.

### **Нөлөөнд өртсөн хүмүүст олгох нөхөн төлбөр, тэдний хүртэх өгөөж**

Газар чөлөөлөх болон газар ашиглалтад тавигдах хязгаарлалт зэргийг (байнгын болон түр) зайлшгүй хийх шаардлагатай тохиолдолд, Зээлдэгч нь нөлөөнд өртсөн хүмүүст орлуулалтын өртөгийн дагуу нөхөн олговор болон өөрсдийн амжиргаа болон амьдралын чанараа сайжруулах эсвэл сэргээн босгоход нь дэмжлэг үзүүлэх бусад төрлийн туслалцаа үзүүлэхийг санал болгоно.

Газар болон үндсэн хөрөнгөд олгох нөхөн олговрын төрөлтэй холбоотой стандартыг ил тод болгож, тогтмол хэрэгжүүлнэ. Нөхөн олговрын үнэлгээг тогтоохдоо харилцан тохиролцох стратеги бүхий дээш чиглэсэн тохируулгын аргыг хэрэглэнэ. Бүх тохиолдолд, нөхөн олговрыг тооцсон тодорхой үндэслэлийг баримтжуулж авах бөгөөд нөхөн олговрыг хуваарилахдаа ил тод байдлыг хангана.

Нөлөөнд өртсөн хүмүүсийн амжиргаа нь газарт суурилсан тохиолдолд, эсвэл газрыг хамтран эзэмшдэг бол Зээлдэгч нь 35(а) хэсгийн дагуу тухайн нөлөөнд өртсөн хүмүүст орлуулж болох газрын сонголтыг санал болгоно. Ингэхдээ Банкны зүгээс тавьсан шаардлагын дагуу орлуулан санал болгох ижил төрлийн газар нь бэлэн байгаа эсэхийг харгалзана. Төслийн шинж чанар, зорилтуудтай нийцэж байвал Зээлдэгч нь мөн нүүлгэн шилжүүлсэн оршин суугчид болон хүмүүст тус төслийн тусламжтайгаар цаашид өсөн дэвжих боломжоор хангана.

БОНС-д заасан нөхөн олговрыг шийдвэрлэсэн, мөн боломжтой бол, нүүлгэн шилжүүлсэн хүмүүс нь өөр газар суурьшиж, нүүлгэлтийн тэтгэмжийг, нөхөн олговрын хамт нөлөөнд өртсөн хүмүүст олгосны дараагаар л Зээлдэгч чөлөөлсөн газар болон холбогдох хөрөнгийг эзэмшилдээ авна. Үүнээс гадна нөлөөнд өртсөн хүмүүс нь амжиргаагаа сайжруулах шаардлагатай бол цаашид гарч ирэх боломжуудыг бүрэн дүүрэн ашиглаж чаддаг болоход нь тэднийг сургах зорилго бүхий амжиргааг сэргээн сайжруулах хөтөлбөрийг шуурхай эхлүүлнэ.

Зарим тохиолдолд нөлөөнд өртсөн тодорхой хүмүүст төлөх нөхөн олговортой холбогдсон ихээхэн хүндрэл гарч болзошгүй. Жишээ нь, өөрийн биеэр оршин суудаггүй эзэмшигчидтэй холбоо тогтоох гэж удаа дараа оролдсон ч бүтэлгүйтэх, төслийн нөлөөнд өртсөн хүмүүс батлагдсан төлөвлөгөөний дагуу санал болгосон нөхөн олговрыг авахаас татгалзах, газар болон хөрөнгийг өмчлөх эрхийг олж авах зам нь урт сунжирсан хууль шүүхийн процесст хүргэх гэх мэт.

Банктай урьдчилан тохиролцсоны дагуу, онцгой тохиолдлуудад болон Зээлдэгчийн зүгээс энэ төрлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргасан гэсэн үндэслэл байгаа тохиолдолд, Зээлдэгч нь төлөвлөгөөнд шаардсаны дагуу нөхөн олговрын мөнгөн санг (нэмээд гэнэтийн үйл явдалд шаардагдах хангалттай хэмжээний мөнгө) хүүгийн төлбөр хүримтлагддаг эскроу эсвэл бусад хадгаламжийн дансанд байршуулж, төслийн бусад холбогдох ажлуудыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ. Тухайн асуудал шийдэгдмэгц эскроу дансанд байрлуулсан нөхөн олговрыг эрх бүхий хүмүүст нь шуурхай олгоно.

### **Олон нийтийн оролцоог хангах**

Зээлдэгч нь БОНС10-т тайларласан оролцогч талуудын оролцоог дэмжих үйл явцыг ашиглан орон нутгийн оршин суугчид зэрэг нөлөөнд өртсөн олон нийттэй холбоотой ажиллана. Нүүлгэн шилжүүлэх болон

амжиргааг нөхөн сэргээхтэй холбогдсон шийдвэр гаргалтын үйл ажиллагаанд нөлөөнд өртсөн хүмүүсийн сонгох боломжтой сонголт, хувилбарууд нь багтана. Төслийн загваруудын боломжит хувилбаруудыг судалж үзэхдээ болон түүний дараах шатууд болох төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шалгалт, нөхөн олговрын үнэлгээний явц, амжиргааг сэргээх үйл ажиллагаа болон сэлгэн суурьшуулах үйл явцын үед холбогдох мэдээллийг ил тод болгон, нөлөөнд өртсөн олон нийтийн оролцоог үр дүнтэйгээр хангана. БОНС7-ийн дагуу, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн Уугуул иргэдтэй хийх зөвлөгөөнтэй холбоотой асуудалд нэмэлт нөхцлүүд үйлчилнэ.

Зөвлөгөөний үйл явцад эмэгтэйчүүдийн санал бодлыг хүлээн авч, тэдний ашиг сонирхлыг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, хэрэгжилтийн бүх үе шатанд тусгана. Амжиргааны нөлөөллийг шийдвэрлэхийн тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амжиргаанд өөр өөр нөлөө үзүүлсэн тохиолдлууд дээр өрхийн дотоод дүн шинжилгээ хийх шаардлага тулгарч болзошгүй. Бэлэн мөнгөнөөс илүү нөхөн орлуулах газар эсвэл байгалийн нөөц ашиглах боломжийг илүүд үзэх гэх мэт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нөхөн олговрын өөр өөр сонголтыг судалж үзэх хэрэгтэй.

### **Санал, гомдол шийдвэрлэх механизм**

Зээлдэгч нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн (болон бусад) тавьсан нөхөн олговор, сэлгэн суурьшуулах эсвэл амжиргааг сэргээх арга хэмжээтэй холбогдсон асуудлуудыг шуурхай шийдвэрлэх үүднээс БОНС10-ын дагуу тухайн төсөлд санал, гомдол шийдвэрлэх механизмыг аль болох эрт хугацаанд эхлүүлэн хэрэгжүүлнэ. Боломжтой бол хэрэглэгдэх санал, гомдол шийдвэрлэх механизм нь төслийн зорилгод нийцсэн, хэрэглэх боломжтой албан ёсны болон албан бус санал, гомдол шийдвэрлэх механизм байна. Ингэхдээ аливаа маргааныг шударгаар шийдвэрлэх зорилгоор тухайн төслийн онцлогт таарсан зохицуулалтыг нэмж болно.

### **Төлөвлөлт ба хэрэгжилт**

Газар чөлөөлөлт болон газар ашиглалтад тавигдах хязгаарлалтыг зайлшгүй тавих шаардлагатай тохиолдолд, Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний хэсэг болгон тооллого зохион байгуулж, төслийн нөлөөнд өртөх хүмүүсийг олж тогтоон, нөлөөлөлд өртөх газрын, хөрөнгийн бүртгэл хийн, нөхөн олговор, тусламж авах эрх бүхий хүмүүсийг тогтоохын хажуугаар ашиг хонжоо хайн нүүн ирэгсэд гэх мэт эрх нь бүрдээгүй хүмүүсийн тэтгэмж нэхэмжлэх боломжийг нь таслан зогсооно. Улирлын шинжтэй нөөц ашигладаг хүмүүс гэх мэт тооллого явуулах хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар төслийн газар дээр өөрийн биеэр байх боломжгүй хүмүүсийн шаардлага, хүсэлтэй холбоотой асуудлыг нийгмийн үнэлгээнд мөн тусгасан байна. Тооллоготой холбогдуулан, шаардлага хангасан эсэхийг тогтоох сүүлийн өдрийг /cut-off date/ Зээлдэгч товлон. Энэ өдөртэй холбоотой мэдээллийг сайтар баримтжуулан төслийн газарт бичгэн (тохиромжтой бол) болон бичгэн бус хэлбэрээр, мөн тухайн орон угтийн хэлээр байнга түгээнэ. Үүнд, товлогдсон сүүлийн өдрөөс хойш төслийн газарт ирж суурьшсан хүмүүсийг тухайн газраас нүүлгэх шаардлагатай болох тухай анхааруулга зар мөн багтана. Байгаль орчин, нийгмийн үнэлгээнд дурдагдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд, Зээлдэгч нь төсөлтэй холбоотой эрсдэл, нөлөөллийг тэнцвэржүүлэх төлөвлөгөө боловсруулна:

- a. Бага хэмжээний газар чөлөөлөлт, эсвэл газар ашиглалтын хязгаарлалт бүхий, үр дүнд нь орлого, амжиргаанд ихээхэн хэмжээний нөлөөлөл учруулахгүй нөхцөлтэй төслүүдийн хувьд, уг төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүст тавигдах шалгуур, нөхөн олговрын журам, стандартыг тодорхойлж,



зөвлөгөөн, хяналт шалгалт, санал, гомдол шийдвэрлэх механизмтай холбоотой зохицуулалтуудыг агуулна;

- b. Биет шилжин хөдөлгөөн хийх шаардлагатай төслүүдийн хүрээнд нөлөөлөлд өртсөн хүмүүсийг сэлгэн суурьшуулахтай холбоотой нэмэлт арга хэмжээнүүдийг уг төлөвлөгөөнд танилцуулсан байна;
- c. Амжиргаа, орлогод ихээхэн хэмжээгээр нөлөөлөх, эдийн засгийн шилжилт хийх шаардлагатай төслүүдийн хүрээнд амжиргааг сайжруулах эсвэл сэргээхтэй холбоотой нэмэлт арга хэмжээнүүдийг уг төлөвлөгөөнд танилцуулсан байна;
- d. Хууль журмын дагуу тусгайлан тогтоож өгсөн талбай, хамгаалалттай газар дахь нөөц, мөн тухайн нутгийн иргэд нь ашиглан амжиргаагаа тэтгэн амьдардаг бусад төрлийн нийтийн өмчийн нөөц зэргийг хэрэглэх боломжийг хязгаарлахуйц хэмжээний газар ашиглалтын өөрчлөлтүүд хийх шаардлагатай төслүүдийн хувьд уг төлөвлөгөөнд олон нийтийг оролцуулж хамгийн тохиромжтой хязгаарлалтуудыг олж тогтоох үйл ажиллагааг тусгаж, энэ төрлийн хязгаарлалтаас амжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг агуулсан байна.

Зээлдэгчийн төлөвлөгөө нь санхүүжүүлэлт, хэрэгжилттэй холбоотой үүрэг хариуцлагыг тогтоож, урьдчилан таамаглаагүй зардлыг төлөх гэнэтийн санхүүжилттэй холбогдох зохицуулалтууд, төлөвлөсөн үр дүндээ хүрэх явцыг удаашруулж буй урьдаас төлөвлөөгүй нөхцөл байдалд тохирсон шуурхай хариу арга хэмжээний зохицуулалт зэргийг агуулсан байна. Төслийн зорилтуудад хүрэхэд авч хэрэгжүүлэх шаардлагатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаануудын бүх зардлыг төслийн нийт зардалд оруулж тооцно. Төслийн бусад үйл ажиллагаануудын зардлын адил, нүүлгэн шилжүүлэх зардлыг төслийн эдийн засгийн үр өгөөжөөс төлөгдөх зардал гэж үзэх бөгөөд шилжин суурьсан хүмүүсийн хүртсэн цэвэр өгөөжийг (“төсөл байхгүй үед” гэсэн нөхцөлтэй харьцуулахад) төслийн үр өгөөжийн үрсгалд нэмж тооцно.

Зээлдэгч нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан шалгах, үнэлж дүгнэх журмыг тогтоох бөгөөд БОНС-д тодорхойлсон зорилтуудад хүрэхийн тулд төсөл хэрэгжиж байх хугацаанд засч залруулах шаардлагатай ажлуудыг мөн хийнэ. Хяналт шалгалтын үйл ажиллагаануудын хамрах хүрээ нь төслийн эрсдэл, нөлөөллүүдтэй харилцан ижил байна. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн үлмаас ихээхэн хэмжээний нөлөөлөл үзүүлэх бүхий л төслүүдийн хүрээнд Зээлдэгч нь төслийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан шалгах, шаардлагатай бол засч залруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг боловсруулж, энэхүү БОНС-ийн дагуу зөвлөгөө өгөх, хяналт шалгалтын тайланг тогтмол хугацаанд гаргах үүрэг бүхий чадварлаг мэргэжилтнүүдийг авч ажиллуулна. Хяналт шалгалтын тайланг боловсруулаад, хяналт шалгалтын үр дүнгийн талаарх мэдээллийг нөлөөлөлд өртсөн хүмүүст шуурхай өгнө.

Нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөллийг холбогдох төлөвлөгөө болон БОНС-ийн зорилтуудын дагуу шийдвэрлэсэн тохиолдолд Зээлдэгчийн төлөвлөгөөг хэрэгжиж дууссан гэж тооцно. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн үлмаас ихээхэн хэмжээний нөлөөлөл үзүүлэх бүхий л төслүүдийн хувьд, нөлөөллийг бууруулах бүх арга хэмжээ бодитойгоор хэрэгжиж дуусахад Зээлдэгч уг төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийлгэхээр захиалга өгнө. Тус аудитыг нүүлгэн шилжүүлэлтийн чадварлаг мэргэжилтнүүд хийж гүйцэтгэх бөгөөд амжиргаа, амьдралын чанар сайжирсан эсвэл сэргэсэн, мөн шаардлагатай тохиолдолд биелүүлж чадаагүй зорилтуудад хүрэхийн тулд засч залруулах арга хэмжээ авах хэрэгтэй эсэхийг үнэлнэ.

Төсөлтэй холбоотой газар чөлөөлөлт болон газар ашиглалтад тавигдах хязгаарлалтын боломжит шинж чанар, хэмжээ нь нүүлгэн шилжүүлэлт болон/эсвэл эдийн засгийн шилжилт хийх шалтгаан болох эсэхийг

төслийн бэлтгэлийн хугацаанд үед олж мэдэх боломжгүй бол Зээлдэгч нь БОНС-тай нийцсэн ерөнхий зарчим, журмыг тогтоосон баримт бичгийг боловсруулна. Төслийн бие даасан бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтоож, шаардлагатай мэдээлэл бэлэн болсны дараа тухайн баримт бичгийг өргөтгөж боломжит эрсдэл, нөлөөлөл зэрэгтэй уялдаа холбоо бүхий нэг эсвэл хэд хэдэн тодорхой төлөвлөгөө болгоно. Уг БОНС-д шаардлагатай гэж үзсэн төлөвлөгөөнүүдийг эцэслэж, Банк батлах хүртэл ямар нэгэн нүүлгэн шилжүүлэлт болон/эсвэл эдийн засгийн шилжилт явагдах ёсгүй.

### **3.2 Шилжилт хөдөлгөөн**

#### **Биет шилжилт хөдөлгөөн**

Биет шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд, Зээлдэгч нь нөлөөнд өртсөн хүмүүсийн тоог харгалзахгүйгээр энэхүү БОНС-ын тохирох шаардлагуудыг наад зах нь хамарсан төлөвлөгөө боловсруулна. Уг төлөвлөгөө нь шилжилт хөдөлгөөнөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах мөн боломжтой бол хөгжлийн боломжуудыг тодорхойлоход чиглэсэн байна. Төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэлтийн төсвийг багтааж, хэрэгжүүлэх хугацааг зааж өгсөн байх ёстой бөгөөд нөлөөнд өртсөн бүх ангиллын хүмүүсийн (тухайн орон нутгийн оршин суугчид энд багтана) эдлэх эрхийг тогтоож өгнө. Жендэрийн хүрээний асуудлууд болон ядуу, эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагуудад тусгай анхаарал хандуулна. Зээлдэгч нь газрын эрхийг өмчилж авах, нөхөн олговор олгох болон сэлгэн суурьшуулахтай холбогдсон бусад ажлуудын бүх гүйлгээг баримтжуулж авна.

Төслийн газарт оршин сууж буй хүмүүс өөр байршил руу нүүх шаардлага гарах үед, Зээлдэгч нь:

- a. Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүст шаардлага хангасан орон сууц эсвэл бэлэн мөнгөний нөхөн төлбөр гэх мэт нүүлгэн шилжүүлэлтийн боломжит хувилбаруудыг оронд нь санал болгох;
- b. Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн бүлэг хүмүүсийн тус тусын онцлогт тохирсон сэлгэн суурьшуулахтай холбоотой туслалцаа үзүүлэх.

Нүүлгэн шилжүүлэх шинэ газрын амьдрах нөхцөл байдал нь өмнө амьдарч байсан газрын амьдрах нөхцөлтэй хамгийн багадаа ижил хэмжээнд эсвэл тухайн үед хэрэгжиж буй боломжит хууль тогтоомж, стандартуудын хамгийн өндөр тогтоосон хувилбарыг нь баримтална. Нүүлгэн шилжүүлэх шинэ газрыг бэлтгэхийн өмнө тухайн орон нутгийн оршин суугчидтай төлөвлөлтийн өөр өөр хувилбаруудын талаар зөвлөлдөх бөгөөд нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн оршин суугчид нь амьдрах таатай нөхцөл байдал, үйлчилгээгээр тасралтгүй хангагдсаар байна. Өмнө нь оршин сууж байсан нийгмийн бүлэг, оршин суугчдын дотор сэлгэн суурьших тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн сонголыг хүндэтгэн авч үзнэ. Мөн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс болон орон нутгийн бүхий л оршин суугчдын нийгэм, соёлын байдлыг хүндэтгэнэ.

10 (a) болон (b) хэсэг дэх ангилалд багтсан биет нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн тохиолдолд Зээлдэгчийн зүгээс тэдэнд оронд нь ижил эсвэл илүү өндөр үнэ бүхий өмч хөрөнгийг адил төрлийн эсвэл илүү дээр нөхцөлтэй өмчлөх эрхийн баталгааны хамт эсвэл орлуулалтын өртгийн дагуу бэлэн мөнгөнөөс сонгохыг санал болгоно. Мөнгөн бус хэлбэрээр олгосон нөхөн олговрыг бэлэн мөнгөний оронд тооцно.

10 (c) хэсэг дэх ангилалд багтсан биет нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн хувьд Зээлдэгч нь тэднийг өмчлөх эрхийн баталгаа бүхий тохиромжтой байр сууцтай болоход нь туслах шаардлагатай зохицуулалтыг хийж өгнө. Тэдгээр нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс нь байгууламж (structures) эзэмшдэг тохиолдолд Зээлдэгч нь байр сууцны болон газарт нь бусад сайжруулалтыг хийх гэх мэт газраас бусад төрлийн хөрөнгийнх нь алдагдлыг нь тооцож орлуулалтын өртгийн дагуу нөхөн олговор олгоно. Нүүлгэн

шилжүүлэлтэд өртсөн тэдгээр хүмүүстэй зөвшилцсөний дагуу Зээлдэгч нь тэдэнд газрынх нь нөхөн олговрын оронд тохиромжтой өөр байрлалд амьдралын чанараа сэргээн сайжруулахад нь хангалттай хэмжээний сэлгэн суурьшилтын туслалцаа үзүүлнэ.

Зээлдэгч нь шаардлага хангасан эсэхийг тогтоох сүүлийн өдрөөс хойш төслийн газар дээр зөрчиж орж ирсэн хүмүүст нөхөн олговор төлөх, туслалцаа үзүүлэх шаардлагагүй бөгөөд ингэхдээ тухайн сүүлийн өдрийг тодорхой товлож, олон нийтэд зарлаж түгээсэн байна.

Зээлдэгч нь нөлөөнд өртсөн хүмүүсийг хүч хэрэглэн албадан нүүлгэхгүй. “Хүч хэрэглэн албадан нүүлгэх” гэдэг нь хувь хүмүүс, гэр бүл болон/эсвэл нийгмийн бүлгүүдийг тэдний ямар нэгэн хууль ёсны болон бусад төрлийн баталгаагүйгээр оршин суудаг байр сууц болон/эсвэл газраас нь тэдний хүсэл зоригийнх нь эсрэг түр хугацаанд болон бүр мөсөн холдуулахыг хэлнэ. Хууль ёсны баталгаа гэдэг ойлголтод БОНС-д дурдагдсан тохирох бүх журам, зарчмууд мөн хамаарна. Зээлдэгчийн албадан дайчлан авах, албадан чөлөөлөх зэрэг эрх мэдлийг улсын хууль болон БОНС-ийн зүйл заалтуудын хүрээнд тавигдах шаардлагуудтай нийцсэн байдлаар мөн зохих ёсны процедурын (due process) суурь зарчмуудыг баримтлан гүйцэтгэсэн тохиолдолд тэдгээрийг хүч хэрэглэн албадан нүүлгэлт гэж тооцохгүй (жишээлбэл, зохих байдлаар урьдчилан мэдэгдсэн, гомдол мэдүүлэх, санал хүсэлт гаргах хангалттай боломжоор хангасан, шаардлагагүй, зохисгүй, хэт их хүч хэрэглэхээс зайлсхийсэн гэх мэт).

Шилжилт хөдөлгөөний оронд хэрэгжүүлэх нэгэн хувилбар нь Зээлдэгчийн зүгээс тухайн газар дээр хийх бүтээн байгуулалттай холбоотой зохицуулалтын нөлөөнд өртөх хүмүүстэй хэлэлцээ хийж болох юм. Энэ нь тэдгээр нөлөөнд өртөх хүмүүс газрынхаа хэсэгчилсэн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсвэл тухайн орон нутагтаа сэлгэн суурьшиж, хариуд нь тухайн газарт хийгдсэн бүтээн байгуулалт нь хөрөнгийнх нь үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэхүйц сайжруулалтад авчирна гэсэн хувилбараас сонголт хийлгэх юм. Харин энэхүү сонголтод оролцох хүсэлгүй хүмүүст оронд нь БОНС-д тавигдсан шаардлагын хүрээнд бүтэн нөхөн төлбөр эсвэл бусад төрлийн туслалцаа авах эрх нь нээлттэй байна.

### **Эдийн засгийн шилжилт**

Төслүүдийн зүгээс амжиргаа болон орлогын эх үүсвэрт нөлөө үзүүлж байгаа тохиолдолд, Зээлдэгчийн төлөвлөгөөнд нөлөөнд өртсөн тухайн хүмүүст амжиргаа болон орлогоо сайжруулах, эсвэл ядахдаа сэргээх боломж олгосон арга хэмжээнүүд багтсан байна. Тус төлөвлөгөө нь нөлөөнд өртсөн хүмүүс болон/эсвэл олон нийтийн эдлэх эрхийг тогтоож өгөх бөгөөд ингэхдээ жендэрийн асуудал болон олон нийтийн дундах эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг тооцож үзсэн байна. Мөн тэдгээр эрхийг хэрэгжүүлэх арга нь ил тод, түүштай, шударга хэлбэртэй байхад анхаарна. Түүнчлэн төлөвлөгөөнд хэрэгжилтийн болон хэрэгжилт дууссаны дараах дүгнэлтийн хугацаанд хэрэгжүүлэх амжиргаатай холбогдсон арга хэмжээнүүдийн үр дүнтэй байдлыг хянан шалгах зохицуулалтууд багтана. Аудитын шалгалтаар нөлөөнд өртсөн бүх хүмүүс болон олон нийт өөрсдөд нь зөвшөөрөгдсөн туслалцаагаа бүгдийг нь хүлээн авч, амжиргаагаа сэргээх хангалттай боломжоор хангагдсан гэсэн дүгнэлт гарсны дараа сая эдийн засгийн шилжилтийн нөлөөллийг бүүруулах үйл ажиллагааг хэрэгжиж дууссан гэж тооно.

Хөрөнгийн алдагдал эсвэл хөрөнгө ашиглах боломжоо алдсан эдийн засгийн хувьд шилжилт хийсэн хүмүүсийн дараах төрлийн хохирлыг орлуулалтын өртгийн дагуу барагдуулна:

- a. Газар чөлөөлөлт болон газрын ашиглалтад тавьсан хязгаарлалтууд нь худалдааны бизнесийн компаниудад нөлөөлж байгаа тохиолдолд, тухайн нөлөөнд өртсөн бизнес эрхлэгчдийн тохирох өөр байршлыг эрж тогтооход гарах зардал; шилжилт хийгдэх хугацаанд алдах нийт цэвэр орлого;

үйлдвэр, машин механизм болон бусад тоног төхөөрөмжийг зөөвөрлөх, дахин суурилуулах, мөн худалдааны үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхэд гарах зардал зэрэг хохирлыг барагдуулна. Нөлөөнд өртсөн ажилтнуудын цалин хөлсөө түр алдсан хохирлыг нь барагдуулахад чиглэсэн туслалцаа олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд, өөр ажлын байр хайж олоход нь туслалцаа үзүүлнэ;

- b. Үндэсний хууль эрх зүйн (10 (a) ба (b) хэсгийг харах) хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл хүлээн зөвшөөрч болохуйц хууль ёсны газрын эрх буюу нэхэмжлэлтэй хүмүүс нөлөөнд өртсөн тохиолдолд, ижил эсвэл илүү өндөр өртөг бүхий нөхөн орлуулахуйц өмчийг (жишээ нь хөдөө аж ахуйн эсвэл худалдааны газар гэх мэт) эсвэл тохиромжтой бол, орлуулалтын өртгийн дагуу бэлэн мөнгөөр нөхөн олговор болгон олгоно.
- c. Эдийн засгийн шилжилт хийсэн хүмүүс нь хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөхүйц газрын нэхэмжлэлгүй (10 (c) хэсгийг харах) бол тэдний газраас бусад алдагдсан хөрөнгийн (газар тариалан, үсжуулалтын дэд бүтэц болон тухайн газарт хийсэн бусад сайжруулалтууд) хохирлыг нь орлуулалтын өртгийн дагуу нөхөн олгоно. Үүнээс гадна Зээлдэгч нь тухайн хүмүүст газрын нөхөн олговрын оронд өөр газар амжиргаагаа сэргээн эхлүүлэхэд нь хангалттай бололцоо олгохуйц тусламж үзүүлнэ. Зээлдэгч нь шаардлага хангасан эсэхийг тогтоох сүүлийн өдрөөс хойш төслийн газар дээр зөрчиж орж ирсэн хүмүүст нөхөн олговор төлөх, туслалцаа үзүүлэх шаардлагагүй.

Эдийн засгийн шилжилт хийсэн хүмүүсийг өөрсдийн орлого олох чадвар, хөдөлмөрийн бүтээмжийн түвшин болон амьдралын чанараа сайжруулах эсвэл дор хаяж сэргээх бололцоогоор хангана:

- a. Амжиргаа нь газарт суурилсан хүмүүс байгаа тохиолдолд, боломжтой бол тухайн алдагдаж буй газрынх нь үйлдвэрлэлийн бүтээмж, байршлын давуу тал болон бусад хүчин зүйлтэй нь ижил тэнцүү нөхцөлтэй нөхөн олговрын газрыг санал болгоно;
- b. Амжиргаа нь байгалийн нөөцөд суурилсан хүмүүс байгаа тохиолдолд, мөн нөөц ашиглах боломж нь төсөлтэй холбоотойгоор хязгаарлагдаж байгаа үед, тухайн нөлөөнд өртсөн нөөцийг үргэлжлүүлэн ашиглах бололцоогоор хангасан, эсвэл амжиргааг дэмжих ижил хэмжээний боломж, хүртээмж бүхий нөөцийн өөр хувилбарыг хэрэглэх боломжоор хангасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Нийтийн өмчийн нөөц нөлөөнд өртсөн тохиолдолд байгалийн нөөцийг ашиглах хязгаарлалттай холбоотой олгох тэтгэмж, нөхөн олговор нь нийтийн шинжтэй байна;
- c. Хэрвээ нөхөн орлуулах газар болон нөөц боломжгүй болох нь батлагдсан бол, Зээлдэгч нь эдийн засгийн шилжилт хийсэн хүмүүст орлого олох өөр боломжит хувилбаруудыг санал болгоно. Үүнд зээлийн боломжууд, чадвар сайжруулах сургалт, шинээр бизнес эхлүүлэхэд нь туслах дэмжлэг, ажлын байр, хөрөнгийн нөхөн олговроос гадна мөнгөн тусламж үзүүлэх зэрэг орно. Нөлөөнд өртсөн хүмүүст зөвхөн бэлэн мөнгөний тусламж үзүүлэх нь тэдэнд амжиргаагаа сэргээхэд нь хэрэг болохуйц бүтээмж сайжруулах арга барил, чадварыг тэр бүр олгож чаддаггүй.

Эдийн засгийн хувьд шилжилт хийсэн бүх хүмүүст хэрэгцээтэй үед нь шилжилтийн дэмжлэг үзүүлнэ. Ингэхдээ тэдний орлого олох чадавхи, хөдөлмөрийн бүтээмжийн түвшин болон амьдралын чанараа сэргээхэд зарцуулах хугацааг нь бодитоор тооцсон тооцоонд үндэслэнэ.

## **ХАВСРАЛТ 6: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ ЗАГВАР**

---

Тус хавсралтад БОНС5 дахь биет ба/эсвэл эдийн засгийн шилжилт хөдөлгөөнийг тодорхойлж байна. Энэхүү хавсралтын хүрээнд эдгээр төлөвлөгөөнүүдийг нийтэд нь “нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө” хэмээн нэрлэнэ. Эдгээр нь аливаа төслийн үр дүнд гарах өөрчлөлтөөс хамааран үүсэх биет ба/эсвэл эдийн засгийн шилжилт хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө юм. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хамарч буй хүрээнээс хамаараад, тухайлбал тус төсөл зөвхөн эдийн засгийн шилжилт хөдөлгөөний хүрээнд яригдаж байгаа бол “амьжиргааны төлөвлөгөө” гэх, эсвэл аливаа цогцолбор газар, тусгай хамгаалалттай газарт нэвтрэхийг хориглох асуудал яригдаж байгаа бол “үйл явцын төлөвлөгөө” гэх мэт өөр нэр өгч болно.

Нүүлгэн шилжүүлэх ажлын далайц, нарийн төвөгтэй байдлын түвшнээс шалтгаалан төлөвлөгөөний тавигдах шаардлагуудын хамрах хүрээ, нарийвчилсан мэдээлэл янз бүр байна. Төлөвлөгөөг боловсруулахдаа (а) санал болгож буй төсөл, шилжилтэд өртөж буй, асар их хэмжээний нөлөөлөлд автаж буй хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөө, (б) хохирлыг арилгах зохистой бөгөөд боломжит арга хэмжээ, (в) тухайн төлөвлөгөөний хүрээнд авах арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүй, институцийн зохицуулалтуудын талаар үнэн, бодитой, сүүлийн үеийн мэдээлэлд үндэслэнэ.

### **Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний үндсэн элементүүд:**

**Төслийн танилцуулга.** Төслийн үйл ажиллагаа, хамрах хүрээний талаар ерөнхий тодорхойлолт.

**Үзүүлж болох нөлөө.** Дараах асуудлуудыг тодорхойлсон байна. Үүнд:

- a. шилжилт хөдөлгөөн хийх шаардлагыг үүсгэж байгаа төслийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох, ингэхдээ төслийг хэрэгжүүлэх хугацаанд тухайн газрыг ашиглах ямар хэрэгцээ байгааг тайлбарлах;
- b. тус бүрэлдэхүүн хэсэг болон төслийн үйл ажиллагааны нөлөөний хүрээг тодорхойлох;
- c. газар эзэмшлийн хамрах хүрээ, барилга, байгууламж, үл хөдөлөх хөрөнгөд учруулах нөлөө;
- d. газар, байгалийн баялгийн ашиглалт, хүртээмжид төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан хязгаарлалтууд;
- e. шилжилт хөдөлгөөнийг аль болох бага байлгах, эсвэл зайлсхийх зорилгоор боловсруулсан сонголтот арга хэмжээ, мөн яагаад тухайн сонголтыг хэрэгсэхгүй болсон тухай тайлбар;
- f. төсөл хэрэгжих хугацааны туршид шилжилт хөдөлгөөнийг аль болох бага байлгах зорилготой ажилладаг механизм.

**Зорилт.** Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрийн гол зорилтууд

**Тооллого судалгаа, нийгэм, эдийн засгийн суурь судалгаа.** Шилжилт хөдөлгөөн өртөх хүн амын тоо, төслийн хүрээнд яригдаж буй газар, барилга, байгууламж үл хөдлөх хөрөнгийн талаарх өрхийн түвшний тооллого судалгааны үр дүн. Тус тооллого судалгаа нь мөн дараах үүргийн гүйцэтгэнэ:

- a. Шилжилт хөдөлгөөнд өртөж буй айл өрхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ам бүл, зохион байгуулалт гэх мэт хэв шинжийг нь тодорхойлох; амьжиргааны суурь мэдээлэл (үүнд албан ба албан бус эдийн засгийн үйл ажиллагаагаар олж авч буй орлого гэх мэт багтана), амьдралын түвшин (эрүүл мэндийн байдал гэх мэт);
- b. Тусгай хангамж олгох шаардлага гарч болзошгүй эмзэг бүлгийнхэн;

- c. Шилжилт хөдөлгөөнд өртөж болзошгүй нийтийн эзэмшлийн дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээний газруудыг олж тогтоох;
- d. Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрийн зураг төсөл, төсөв боловсруулах суурь мэдээлэл болох;
- e. дахин суурьшуулалтын тэтгэмж авах шаардлагыг хангахгүй хүмүүсийг олж тогтоох, хяналт шалгалт, үнэлгээ хийхэд харьцуулах суурь нөхцлүүдийг тодорхойлох;
- f. Дэлхийн Банк шаардлагатай гэж үзвэл дараах асуудлуудаар тооллого судалгааг зохион байгуулна:
- g. газар ашиглах, өмчлөх тогтолцоо, амьжиргаагаа залгуулдаг нийтийн эзэмшлийн байгалийн баялгийн тогтолцоо (загасчлалын цэг, бэлчээр, ой мод гэх мэт) -г орон нутгийн удирдлага хэрхэн зохицуулдаг талаар болон төслийн байршилд газар хуваарилах механизмд ялгаатай зүйл байгаа эсэх;
- h. шилжилт хөдөлгөөний нөлөөнд өртөж буй суурин газрын нийгмийн харилцааны арга хэрэгсэл, нийгмийн сүлжээ, нийгмийн дэмжлэгийн тогтолцоо зэрэг нь юу болох, төслийн нөлөөнд хэр өртөх тухай судалгаа;
- i. шилжилт хөдөлгөөнд орж байгаа хүмүүсийн нийгэм, соёлын шинж чанар, тухайлбал албан ба албан бус институт (үүнд олон нийтийн байгууллага, зан үйлийн бүлгэмүүд, ТББ-үүд багтана)-ууд нь төслийн нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох эсэхийг шийдвэрлэх.

**Хууль, эрх зүйн орчин.** Хууль эрх зүйн орчны судалгаанд дараах асуудлууд орсон байна:

- a. газрыг албадан хураах, газар эзэмшихийг хориглох, үүнтэй холбогдуулан олгох нөхөн төлбөрийн хэлбэр, түүний аргачлал ба төлбөр олгох хугацаа;
- b. хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ, тухайлбал шүүхийн шийдвэрээр шилжилт хөдөлгөөнд орсон хүн амд олгох нөхөн олговрын хэмжээ ба цаг хугацаа, төсөлд ашиглаж болох хохирол барагдуулах механизм;
- c. нүүлгэн шилжүүлэх чиг үүргийг хамаардаг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, журам;
- d. Газар албан хураах, газар эзэмших эрхийг нь хязгаарлах талаарх тус улсын хууль, тогтоомж болон БОНС5 стандартын хооронд зөрүү байгаа эсэх, байгаа бол тус зөрүүг арилгах механизм.

**Институцын орчин.** Интституцын орчны судалгаанд дараах асуудлууд орсон байна:

- a. ТББ, нийтийн үйлчилгээний газар, төрийн байгууллага гэх мэт шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн байгууллагуудыг тодорхойлж, шилжилт хөдөлгөөнд өртөж буй хүмүүст дэмжлэг үзүүлэх зэргээр төслийн хэрэгжилтэд оролцох боломжтой эсэх;
- b. ТББ, нийтийн үйлчилгээний газар, төрийн агентлаг гэх мэт байгууллагуудын институцын чадамж;
- c. Төрийн байгууллага, ТББ, нийтийн үйлчилгээний газрууд гэх гэм байгууллагын институцын чадамжийг ахиулах алхмууд.

**Нийцэмж.** Шилжилт хөдөлгөөнд өртөж буй хүний тодорхойлолт, дахин суурьшуулалтын тусламж, нөхөн төлбөр авахад тавигдах шаардлага, нөхөн төлбөр авч дуусах хугацаа

**Хохирлыг үнэлэх, нөхөн төлөх.** Хохирлыг үнэлэх, түүнийг нөхөн төлөхөд зарцуулагдах зардлыг тодорхойлох аргачлал; газар, байгалийн баялаг болон бусад эд хөрөнгийг нөхөн барагдуулах хэлбэр ба түвшин, тус улсын хууль, тогтоомжийн заасны дагуу, тэдгээр нөхөн олговрыг олгохын тулд заавал авах арга хэмжээ.

**Олон нийтийн оролцоо.** Шилжилтэд орж байгаа хүмүүсийг оролцуулах (тухайн төсөл явуулж байгаа газрын оршин суугчид):

- a. нүүлгэн шилжүүлэх ажлыг боловсруулж, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийттэй зөвлөлдөх, тэднийг оролцуулах төлөвлөгөөний тодорхойлолт;
- b. иргэд, олон нийтийн үзэл бодлын хураангуй, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад эдгээр үзэл бодлыг шингээсэн байдал;
- c. нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хувилбаруудыг иргэд, олон нийтэд мэдээлсэн байх, иргэд мэдээлэл авсны дагуу сонголтоо хийсэн байх;
- d. Төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн бүхий л хугацаанд шилжилтэд орж байгаа иргэд, олон нийт төслийн удирдлагуудад санал бодлоо хүргэх институцын зохицуулалттай байх, мөн уугуул иргэд, үндэстний цөөнх, эмэгтэйчүүд гэх мэт эмзэг бүлгийнхний оролцоог хангах арга хэмжээг авсан байх.

**Хэрэгжүүлэх хуваарь.** Шилжилт хөдөлгөөн эхлэх огноо, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг эхлэх, дуусгах төлөвлөгөөт хугацааг харуулсан хуваарь. Нүүлгэн шилжүүлэх ажлууд нь төслийн хэрэгжилттэй хэрхэн уялдаж байгааг тус хуваарьт харуулах ёстой.

**Зардал ба төсөв.** Нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд гарах бүх зардлыг ангилан, харуулсан хүснэгт, тухайлбал инфляц, хүн амын өсөлт, бусад зардал гэх мэт; зардлын цаг хугацааны хуваарь; санхүүгийн эх үүсвэр; санхүүг цаг тухайд нь гаргах, нүүлгэн шилжүүлэхэд зориулах санхүүжилт, хэрэгжүүлэгч агентлагуудын хууль, тогтоомжоом гадуурх асуудал байгаа бол түүнд зарцуулах санхүүжилт.

**Хохирол барагдуулах механизм.** Нүүлгэн шилжүүлэлтийн шилжилт хөдөлгөөнөөс болж гарах маргааныг гуравдагч талаар шийдвэрлүүлэх, санхүүгийн хувьд боломжийн бөгөөд хүртээмжтэй горимыг тусгасан байна. Ингэхдээ шүүн таслах, олон нийтийн болоод уламжлалт маргаан шийдвэрлэх арга замуудыг тооцож үзэх хэрэгтэй.

**Хяналт, шинжилгээ, үнэлгээ.** Иж бүрэн, үнэн бодит мэдээллээр хангах үүднээс шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэх ажлыг хянах ажлыг хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс зохион байгуулах, Дэлхийн Банкны зүгээс зөвшөөрсөн тохиолдолд гуравдагч этгээдээр хяналт авах; нүүлгэн шилжүүлэх ажлын зарцуулалт, үр өгөөж, үр дүнг гүйцэтгэлийн хувьд хянах хэмжүүрүүд; хяналт тавих үйл явцад шилжилтэд орж байгаа хүмүүсийг оролцуулах; нүүлгэн шилжүүлэх бүх үйл ажиллагаа дууссаны дараа боломжийн хугацаанд үр дүнг хянаж үнэлэх; дараа дараагийн ажлын хэрэгжилтэд ХШҮ-ний үр дүнг ашиглаж, тусгах.

**Дасан зохицох менежментийн зохицуулалтууд.** Төслийн нөхцөл байдалд урьдчилан тооцоолоогүй өөрчлөлт гарах, эсвэл нүүлгэн шилжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад гэнэтийн саад бэрхшээл гарч ирсэн тохиолдолд түүнд дасан зохицож ажиллах тухай заалтуудыг тус төлөвлөгөөнд тусгасан байна.

## **ХАВСРАЛТ 7: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДТЭЙ ХОЛБООТОЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖИШИГ ЗАГВАР**

Нийгэм, соёлын өвөрмөц онцлогтой бүлгийн асуудлаар БОНС7-г баримтлан ажиллана. Орон оронд эдгээр бүлгүүд өөр өөр нэршилтэй байх бөгөөд үндэсний хэмжээнд авч үздэг асуудал байдаг. БОНС7-д “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” гэдэг нэршлийг хэрэглэдэг боловч бусад улс орнуудад тэдгээр өвөрмөц бүлгүүдийг өөрөөр нэрлэж байгааг үгүйсгэхгүй юм. “Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил”, “Нутгийн уугуул, цөөнх угсаатан”, “аборигенчууд”, “уулын омгийнхон”, “эмзэг бүлэг”, “үндэстний цөөнх”, “хуваарьт омгууд”, “анхдагч үндэстэн”, “омгууд” гэх мэт нэршлүүд бий. БОНС7 нь шаардлагад нийцэж байгаа дээрх бүх нэршлүүдэд хамаарах бүлгүүдэд үйлчилнэ. Энэхүү БОНС-ын хүрээнд “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” хэмээх нэр томъёонд дээр дурдсан ба бусад бүх нэршлүүдэд хамаарах бүлгүүдийг хамруулан ойлгоно.

### **1. Зорилтууд**

Дараах зорилтуудад нийцүүлэн ажиллана:

- a. Бүтээн байгуулалтын үйл явцад нутгийн уугуул иргэдийн хүний эрх, нэр төр, хүсэл тэмүүлэл, өвөрмөц онцлог, соёл, байгалийн баялагт суурилсан амьжиргааны хэлбэрийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзэх үзлийг дэлгэрүүлэх.
- b. Төслийг хэрэгжүүлэхдээ нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншилд хор хохирол учруулахгүй байх, учруулахаас өөр аргагүй болсон бол хор хохирлыг аль болох багасгах, эсвэл учруулсан хохирлоо нөхөн төлөх
- c. Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншилд тогтвортой хөгжлийн үр өгөөж, боломжуудыг хүртээмжтэй бөгөөд соёлыг нь хүндэтгэсэн, оролцоог дэмжсэн аргаар нэвтрүүлэх.
- d. Аливаа төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өртөж буй Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншлийн гишүүдтэй төслийг хэрэгжиж дуусах хүртэлх бүхий л хугацаанд зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, түншлэл бий болгон, түүнийг хадгалах.
- e. БОНС-д тусгасан 3 тохиолдолд нутгийн уугуул иргэдээс чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрлийг нь авсан байх.
- f. Нутгийн уугуул иргэдийн соёл, мэдлэг, туршлагыг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзэж, тэдгээр иргэдэд тохиромжтой хэв маяг, цаг хугацаанд нь тааруулж, өөрчлөгдөн буй нөхцөл байдалд дасан зохицох боломж олгох.

### **2. Үйлчлэх хүрээ**

Энэхүү БОНС нь нийгэм, соёлын өвөрмөц онцлогтой бүлэг хүмүүст үйлчилнэ. Зарим улсад ийм бүлэг хүмүүсийг “нутгийн уугуул иргэд” гэдэг. “Өвөр Сахарын Африкын хамгаалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил”, “Нутгийн уугуул, цөөнх угсаатан”, “аборигенчууд”, “уулын омгийнхон”, “эмзэг бүлэг”, “үндэстний цөөнх”, “хуваарьт омгууд”, “анхдагч үндэстэн”, “омгууд” гэх мэт нэршлүүд бий. “Нутгийн уугуул иргэд” гэдэг нэр томъёонд хамаарах иргэд нь орон оронд өөр байх тул Зээлдэгч тал Дэлхийн Банкнд улс орны онцлогт тохирсон нэршил ашиглах хүсэлт гаргаж болно. Нэршил ямар байхаас үл хамааран энэ БОНС-д тусгасан шаардлагууд нь дээрх нэршлүүдэд багтах бүх хүмүүст хамаарна. Нутгийн уугуул иргэдийг



тодорхойлох бүх төрлийн нэршлийг энэхүү БОНС-д “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хадгалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” гэсэн нэр томъёогоор орлуулна.

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний үед нутгийн уугуул иргэдийн амьдралтай холбогдох агуулга илэрвэл энэхүү БОНС-ыг баримтлан ажиллана. Төслийн хэрэгжилтийн үр дүнд уугуул иргэдэд сайн эсвэл муу, их эсвэл бага үр нөлөө үзүүлэх эсэхээс үл хамааран энэхүү БОНС-ыг мөрдөнө. Мөн эдийн засаг, улс төр, нийгмийн эмзэг байдал илэрхий байгаа эсэхээс үл хамааран үйлчилнэ. Гэхдээ төслийн үр шимийг тэгш хүртээмжтэй эдлэх боломжийг олгох, эсвэл төслийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг боловсруулахдаа эмзэг байдлын түвшинг харгалзан үзнэ.

Энэхүү БОНС-д Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хадгалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил” (эсвэл улс орны онцлогт тохируулан өөр нэршлээр орлуулсан) хэмээх нэршлийг дараах шинж чанарыг агуулсан, нийгэм, соёлын өвөрмөц онцлог бүхий бүлэг хүмүүсийг тодорхойлоход ашиглана.:

- a. Өөрийгөө болон өрөөл бусдын тодорхойлж байгаагаар нийгэм, соёлын өвөрмөц онцлог бүхий бүлэгт хамаардаг байх;
- b. газарзүйн хувьд өвөрмөц онцлогтой газарт олноор суурьшсан, эсвэл нутаг сэлгэн амьдардаг бөгөөд тухайн газар орны байгалийн баялгийг ашиглан амь зуудаг;
- c. Нийгэм, соёлын түгээмэл байдлаас ангид, уламжлалт соёл, эдийн засаг, нийгэм, улс төрийн өвөрмөц институцтай байх;
- d. оршин суудаг улс орныхоо албан ёсны хэлээс өөр хэл, аялгаар ярьдаг байх.

Төслийг хэрэгжүүлж буй газар нь “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хадгалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил”-ийн гишүүний уугуул газар нутаг байсан бөгөөд хүчээр булаан авсан, зөрчил маргаан, төрийн нүүлгэн шилжүүлэх хөтөлбөр, байгалийн гамшиг, газар эзэмшлийн эрхгүйгээс үүдсэн% эсвэл тухайн газар нутгийг хот суурин газрын нэг хэсэг болгон авсан зэрэг шалтгаанаар алдагдсан бол энэхүү БОНС-ыг мөрдөнө. Ойн иргэд, анчин-түүвэрлэгч, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч болон дээрх шаардлагуудыг хангаж буй бусад нүүдэлчин бүлгүүдэд бас хамаарна.

Төсөл хэрэгжиж буй газарт нутгийн уугуул иргэдийн эрх ашиг хөндөгдөж байгааг Дэлхийн Банк олж тогтоосон даруйд зээлдэгч тал нь БОНС-ын зөвлөлгөөн, төлөвлөлт, шаардлагуудад нийцэж ажиллахын тулд зохих мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах шаардлагатай тулгарч болно. Тус улсын үндэсний зохицуулалтын бодлого нь энэ БОНС-ын 8 шаардлагатай нийцэж байгаа бол Дэлхийн Банк нутгийн уугуул иргэдийн асуудлыг үнэлж, тогтоохдоо үндэсний бодлого, зохицуулалтыг ашиглаж болно.

### **Хураангуй**

Энэхүү БОНС-ын гол зорилго нь нутгийн уугуул иргэдийг хэрэгжиж буй төслийн талаар бүрэн мэдээлэлтэй болсон байх, төслийн боловсруулалт, хэрэгжилт, зохион байгуулалтад идэвхтэй оролцох боломжоор нь хангахад оршино. Нутгийн уугуул иргэдтэй зөвлөлдөх зөвлөлгөөний хамрах хүрээ, түүний араас хийх төлөвлөлт, зохион байгуулалтын түвшин нь тухайн төсөл нутгийн уугуул иргэдийн амьдралд хэр их нөлөө үзүүлж байгаагаас хамаарна.

Төслийн байршилд оршин сууж байгаа, эсвэл тус газар нутагт хамаарал бүхий нутгийн уугуул иргэдийн эдийн засаг, соёл (соёлын өв гэх мэт), байгаль орчны байдалд нөлөөлөх шүүд ба шүүд бус нөлөөллийг зээлдэгч тал үнэлж, тогтоосон байна. Мөн нутгийн уугуул иргэдтэй зөвлөлдөх стратеги, төсөл боловсруулах,

хэрэгжүүлэх үйл явцад оролцуулах аргачлалыг боловсруулсан байна. Улмаар төслийн зураг төсөл, баримт бичгүүд дараах байдлаар, зохих журмын дагуу бэлтгэгдэн гарна.

Зээлдэгч тал арга хэмжээ, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг нутгийн уугуул иргэдтэй зөвлөлдсөний дагуу, “Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хадгалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншил”-ийн Төлөвлөгөө зэргийн цаг хугацаатай төлөвлөгөө хэлбэрээр гаргана. Төслийн эрсдэл, сөрөг нөлөө хэр их байна, тус төлөвлөгөөний хамрах хүрээ нь төдий чинээ өргөн байна. Тус төлөвлөгөөний формат, гарчиг нь тухайн улс орны болон төслийн онцлогт тохирсон байх ба нутгийн уугуул иргэд гэдэг ойлголтыг ч улс орны онцлогт тохируулан өөр нэршлээр орлуулсан байж болно.

### **Сөрөг нөлөө их гарахаас сэргийлэх**

Нутгийн уугуул иргэдийн амьдралд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхээс ямагт сэргийлж байх нь зүйтэй. Ихээхэн сөрөг нөлөө бий болохоос өөр аргагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд зээлдэгч тал нутгийн уугуул иргэдийн соёлын онцлогт тохирсон, тэдгээр иргэдэд учруулсан хор хохирлын хэмжээ, цар хүрээ, мөн тэдгээр иргэдийн амьдралын түвшин, эмзэг байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хохирлыг нөхөн барагдуулна.

Гадаад ертөнцтэй холбоо тогтоодоггүй, “сайн дураараа тусгаарлагдаж буй ард түмэн”, “алслагдсан ард түмэн”-д нөлөөлөхөөр нөхцөл байдал шсссэн бол зээлдэгч тал тэр хүмүүсийн газар нутаг, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, соёлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн, хамгаалах арга хэмжээг авах ба болж өгвөл контакт үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллана. Тухайн уугуул “алслагдсан” ард түмний зүгээс ямар нэг харилцаа үүсгэхийг хүсэхгүй байгаа тохиолдолд төслийн тийм хэсгийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болно.

### **Эрсдлийг бууруулах ба бүтээн байгуулалтын үр өгөөж**

Зээлдэгч тал нутгийн уугуул иргэдтэй хамтран эрсдэл бууруулах арга хэмжээг БОНС1-т заасан эрэмбэ дарааллын дагуу боловсруулна. Мөн соёлыг нь хүндэтгэсэн, тогтвортой байдлаар төслийн бүтээн байгуулалтын үр шимийг хүртээх боломжийг судалж, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. Соёлын ба материаллаг нөлөөллийн аль алиных нь эрсдлийг бууруулж, үнэлнэ. Харилцан тохиролцсон арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулж хэрэгжүүлэх үүргийг зээлдэгч тал хүлээнэ.

Төслийн нөлөөнд өртсөн нутгийн уугуул иргэдийн хохирлын нөхөн төлбөрийг тодорхойлж, олгох, үр өгөөжийг хуваалцахдаа тэдгээр хүмүүсийн институцын зохион байгуулалт, дүрэм журам, зан заншил, мөн түгээмэл соёл иргэншилтэй харилцааны түвшинг нь харгалзан үзнэ. Нөхөн төлбөр авах нийцэмж нь хүн нэг бүрээр, юмуу нийтэд нь хамааруулсан, эсвэл аль алийг нь харгалзан үзсэн байж болно. Нийт дунд олгосон нөхөн төлбөрийг нутгийн уугуул иргэдийн төлөөлөл бүрт тэгш хуваарилах, эсвэл олон нийтэд чиглэж, тухайн бүлгийн хүн бүр үр өгөөжөөс нь тэгш хүртэх боломжтой үйл ажиллагаанд зарцуулах механизмыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

Төслийн мөн чанар, агуулга, өртөж буй уугуул иргэдийн эмзэг байдаг зэргээс хамааран төслийн үр өгөөжөөс хэрхэн хүртэх нь тодорхойлогдоно. Нутгийн уугуул иргэдийн амьдралын чанарыг соёлыг нь хүндэтгэсэн хэлбэрээр сайжруулах, амьдралаа залгуулдаг байгалийн баялгийнх нь тогтвортой байдлыг сайжруулах гэх мэт нутгийн уугуул иргэдийн таатай байдлыг хангахад тэдгээр боломжууд нь чиглэсэн байна.

### **Нутгийн уугуул иргэд/Өвөр Сахарын Африкын хадгалагдаагүй, түүхэн, уламжлалт соёл иргэншлүүдэд зориулан бэлтгэсэн зөвлөлгөөн**

Төслийн зураг төслийг үр дүнтэй боловсруулах, орон нутгийнхнаар төслөө дэмжүүлэх, төсөлтэй холбоотой маргаан, хугацаа хойш татах асуудал гаргахгүй байх үүднээс зээлдэгч тал нутгийн уугуул иргэдтэй харилцаа тогтоож, зөвлөлдөх ёстой хэмээн БОНС10-т заасан. Харилцаа тогтоох үйл явцад харилцааны үйл ажиллагааг төлөвлөх, мэдээлэл өгөх, зөвлөлдөх, эдгээрийг зохион байгуулахдаа соёлыг нь хүндэтгэсэн, жендэр ба насны зохистой харьцааг эрхэмлэж, оролцоог хангасан байх зэрэг багтана. Нутгийн уугуул иргэдийн хувьд зөвлөлгөөн нь:

- a. Нутгийн уугуул иргэдийн төлөөллийн байгууллага (түхэйлбал ахмадуудын зөвлөл, тосгоны зөвлөл, ахлагч нарын хурал гэх мэт), бусад ард иргэдийн төлөөллийг хамруулсан байна.
- b. нутгийн уугуул иргэдэд шийдвэр гаргах үйл явцад оролцох хангалттай цаг хугацааг олгосон байна.
- c. Төслийн үйл ажиллагааг боловсруулах, эрсдлийг бууруулах, ямар нэг байдлаар өөрсдөд нь нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад нутгийн уугуул иргэд идэвхтэй оролцох боломжоор хангана.

### **3. Чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл (FPIC) авах шаардлагатай нөхцөл байдал**

Газар орныг нь ашиглах, байгалийн ба соёлын эх үүсвэрээс нь салгахад нутгийн уугуул иргэд ихээхэн хохирох магадлалтай. Энэхүү эмзэг байдлыг нь харгалзан үзээд, БОНС (А хэсэг), БОНС 1 ба 10-т заасны дагуу, дараах тохиолдолд зээлдэгч тал нутгийн уугуул иргэдээс чөлөөт байдлаар, урьдчилан, мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрлийг нь авах шаардлагатай:

- a. уламжлал, зан үйлийн зорилгоор ашиглаж, эзэмшдэг газар нутаг, байгалийн баялагт ихээхэн нөлөө үзүүлэх бол;
- b. уламжлал, зан үйлийн зорилгоор ашиглаж, эзэмшдэг газар нутаг, байгалийн баялгийг нь нутгийн уугуул иргэдээс салгах, хурааж авах, тэдгээр иргэдийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай бол; эсвэл
- c. нутгийн уугуул иргэдийн өвөрмөц онцлог, оюун санаа, шашин шүтлэгийн соёлын өвд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх бол.

Дээрх нөхцөл байдалд, төслийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлохын тулд зээлдэгч тал хөндлөнгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Дээрх зөвшөөрлийг тодорхойлсон нийтлэг тодорхойлолт гэж байхгүй. Энэхүү БОНС-ын хүрээнд чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрлийг дараах байдлаар тодорхойлж байна:

- a. тус зөвшөөрөл нь төслийн боловсруулалт, хэрэгжилтийн зохион байгуулалт, нутгийн уугуул иргэдэд нөлөөлөх нөлөөлөл зэрэг өргөн хүрээг хамарна;
- b. БОНС10-т заасанчлан тус зөвшөөрөл нь зөвлөлгөөний үр дүнд гарах ба цаашид зөвлөлдөх үйл явцыг өргөжүүлж өгнө. Тус зөвшөөрлийг зээлдэгч тал ба нутгийн уугуул иргэдийн хооронд бий болсон итгэлцлийн үндсэн дээр гаргуулж авна;
- c. Зээлдэгч тал: (i) зээлдэгч тал ба нутгийн уугуул иргэдийн хооронд итгэлцлийн хэлэлцээр байгуулсан, хоёр талаас харилцан хүлээн зөвшөөрсөн үйл явц; (ii) түхэйл итгэлцлийн хэлэлцээрийн үр дүнг баримтжуулж авах ба ингэхдээ санал нэгдсэн болон зөрчилдсэн зүйлсийг ч нэгд нэгэнгүй оруулна;
- d. Зөвшөөрөл заавал нэг санал дээр бүгд нэгдэх шаардлагагүй. Нутгийн уугуул иргэдийн зарим нь илтэд санал нэгдэхгүй байгаагаа илэрхийлсэн ч олонхын саналаар зөвшөөрнө.

Энэхүү БОНС-ыг дагаж мөрдөх хүрээнд, өөрсдөд нь нөлөөлж байгаа төслийн үйл ажиллагаатай нутгийн уугуул иргэдийн дийлэнх нь санал нэгдэж, соёлыг нь хүндэтгэсэн хэлбэрээр зөвшилцөлд хүрснийг

зөвшөөрөл авсанд тооцно. Хэсэг бүлэг хүмүүс эсвэл зарим нэг хүн эсэргүүцлээ илэрхийлсэн ч зөвшилцөлд хүрч болно.

Нөлөөнд өртөж буй нутгийн уугуул иргэдийн урьдчилсан зөвшөөрлийг Дэлхийн Банк магадлахгүй гэж үзвэл төслийн тус хэсгийг цааш үргэлжлүүлэх боломжгүй юм. Зөвшөөрлийг нь магадлаагүй хэсгийг орхиод төслийн бусад хэсгийг хэрэгжүүлэхээр шийдсэн бол нутгийн уугуул иргэдэд нөлөөлж болох үйл ажиллагааг цаашид зохион байгуулахгүй бөгөөд нутгийн уугуул иргэдийн амьдралд ямар нэг нөлөө үзүүлэхээс бүрэн сэргийлэх ёстой.

Зээлдэгч ба нутгийн уугуул иргэдийн ххорондох хэлэлцээрийг тодорхойлж, шаардлагатай ажлуудыг БОНАТ-нд тусгаж өгнө. Нутгийн уугуул иргэдээр төслийн хэрэгжилтийг дэмжүүлж байхын тулд зээлдэгч тал шаардлагатай ажлуудыг гүйцэтгэж, хэлэлцэж тохирсон үр өгөөж, сайжруулалт, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

### **Уламжлал, зан үйлийн зорилгоор ашиглагддаг газар ба байгалийн баялагт үзүүлэх нөлөө**

Нутгийн уугуул иргэдийн амьдрал нь ихэвчлэн амьдарч байгаа газар нутаг, түүний баялагтай ихээхэн учир холбогдолтой байдаг. Газар нутаг нь уламжлал, зан үйлийн зорилгоор ашиглагдаж, тийм зорилгоор өмчлөгдсөн байдаг. Хэдийгээр нутгийн уугуул иргэд газар нутгийг хуулийн дагуу эзэмшдэггүй байж болох боловч, улирлын чанартай нүүдэллэн амьдрах, соёл, зан үйл, шүтлэгийн зорилгоор ашиглаж, эзэмшиж байгаа нь баримттай, нотолгоотой, батлагдах боломжтой байдаг. Хэрвээ аливаа төсөл нь: (а) нутгийн уугуул иргэдийн амьдарч ирсэн газар нутгийг хууль ёсны дагуу өмчлөх шаардлагатай үйл ажиллагаа явуулах бол, (б) тухайн газар нутгийн хууль ёсны өмчлөл, ашиглалтыг олж авахдаа зээлдэгч тал нь нутгийн уугуул иргэдийн зан заншил, уламжлал, газар эзэмших ёс жаягт нь хүндэтгэлтэй хандах зохистой төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Ийм төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилт нь (а) нутгийн уугуул иргэдийн газар эзэмших ёс жаягийг хуулийн хүрээнд бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрүүлэх; эсвэл (б) газар эзэмших уламжлалт эрхийг нийтийн ба/эсвэл хувийн эзэмшилд шилжүүлэх. Тухайн улсын хуулинд энэ хоёрын аль нь ч тохирохгүй байвал нутгийн уугуул иргэдийн байнгын буюу урт хугацаагаар тухайн газар нутгаа харгалзан хамгаалагч нь байх хууль ёсны эрхийг хүлээн зөвшөөрүүлэх төлөвлөгөө гаргаж болно.

### **Уламжлалт, зан үйлийн зорилгоор ашиглаж, эзэмшдэг газраас нь нутгийн уугуул иргэдийн нүүлгэн шилжүүлэх**

Газар нутаг, түүний байгалийн баялгийг уламжлалт байдлаар, эсвэл зан үйлийн зорилгоор ашигладаг нутгийн уугуул иргэдийг нүүлгэн шилжүүлэхээс зээлдэгч тал аль болох зайлсхийнэ. Хэрвээ нүүлгэн шилжүүлэхээс өөр аргагүйд хүрвэл зээлдэгч тал дээр дурдсанчлан зөвшөөрөл авсны үндсэн дээр л үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой юм. Зээлдэгч тал хүчээр нүүлгэн шилжүүлэх, БОНС5-ын шаардлагад нийцээгүй нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг явуулах боломжгүй. Боломжтой тохиолдолд нутгийн уугуул иргэдийг оршин сууж буй газраас нь нүүлгэн шилжүүлэхэд хүргэсэн төслийн үйл ажиллагаа дуусаж, тухайн газар орон чөлөөтэй болсон тохиолдолд эргэн ирэх боломжтой.

## **ХАВСРАЛТ 8: НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШИГ АГУУЛАМЖ**

Нутгийн уугуул иргэдэд зориулсан төлөвлөгөөний жишиг агууламж дараах байдалтай байна:

*Иж бүрэн НУИТ-ний үндсэн элементүүд нь дараах болно. Нутгийн уугуул иргэд төсөл, төслийн хүрээнд хэрэгжиж буй ажлууд, жижиг нөлөөллүүдээс үр өгөөжийг хүртэж байгаа нөхцөлд НУИТ-ний зарим элементүүдийг Газар өмчилж авах төлөвлөгөө, БОНМТ-нүүдэд нэгтгэн оруулж болно. Тэдгээр элементүүд нь:*

- a. НУИТ-ний Ерөнхий удиртгал.** Чухал баримт, судалгааны чухал үр дүн, санал болгох ажлуудыг товчхон дурдсан байна (НУИТ тусдаа баримт бичиг болон боловсруулагдаж буй тохиолдолд);
- b. Нутгийн уугуул иргэдэд нөлөөлөх төсөл, эсвэл төслийн аливаа үйл ажиллагааны үнэлгээ.** Тэдгээр нөлөөллийн мөн чанар, хамрах хүрээг тодорхойлсон байна. Үүнд:
  - i. Төслийн агуулгад тохирсон, нутгийн уугуул иргэдтэй холбоотой хууль, эрх зүй, институтын орчинг тодорхойлох.*
  - ii. нөлөөнд өртөж буй бүлгүүдийн хүн ам, нийгэм, соёл, улс төрийн шинж чанарыг харуулсан суурь судалгаа; тэдгээр иргэдийн уламжлалт хэлбэрээр эзэмшдэг газар нутаг, ашиглан амьжиргаагаа залгуулдаг байгалийн баялгийн тухай мэдээлэл.*
  - iii. Төслийн гол оролцогч талуудыг тодорхойлж, төслийн бэлтгэл, хэрэгжилтийн бүх үе шатанд уугуул иргэдийн соёлд хүндэтгэлтэй хандахаас гадна жендэрийн мэдрэмжтэй байдлаар зөвлөлтөгөөнийг зохион байгуулах, ингэхдээ суурь судалгаа, мэдээллийг харгалзан үзэх.*
  - iv. Нөлөөнд өртөж буй бүлгүүдтэй хийсэн зөвлөлтөгөөнд үндэслэн гарч болох сөрөг, эерэг нөлөөг үнэлэх. Нутгийн уугуул иргэдэд тулгардаг эмзэг байдал, тухайн газар нутаг, түүний байгалийн баялгаас ихээхэн хамааралтай байдаг учраас нийгмийн бусад бүлгийнхэнд байдаг боломж бололцоог эдэлж чаддаггүй гэх мэт бэрхшээлүүдэд жендэрийн мэдрэмжтэй дүгнэлт хийх.*
  - v. Нутгийн уугуул иргэдийн төслийн талаарх ойлголт, нийгэм, эдийн засаг, соёлын байдалд нь нөлөөлөх нөлөөллийн тухай сэтгэгдлийн жендэрийн мэдрэмжтэйгээр үнэлэх.*
  - vi. Төслийн хүрээнд нутгийн уугуул иргэд соёлыг нь хүндэтгэсэн байдлаар ашиг тус хүртсэн байхаар зохицуулалт хийж, тэдгээр уугуул иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр сөрөг нөлөө гарахаас сэргийлэх, хэрвээ боломжгүй бол сөрөг нөлөөг аль болох бууруулах арга хэмжээг тодорхойлж, санал болгох.*
- c. Урьдчилсан зөвшөөрөл авах шаардлагатай нөхцөл байдлыг үнэлэх, сөрөг нөлөөллөөс сэргийлэх сонголтот хувилбар (чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрлийн талаарх хэсгийг уншина уу).**
- d. Мэдээлэл ил болгох, зөвлөлдөх, оролцоог хангах.** Энэ хэсэгт:

- i. Төслийн бэлтгэл үед зохион байгуулж болох, мэдээлэл ил болгох, уугуул иргэдтэй зөвлөлдөх, тэдгээр иргэдийг оролцуулах зэрэг ажлуудыг тодорхойлох;
  - ii. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд өгсөн нэмэлт тайлбар, сэтгэгдэл, зөвлөлгөөний үед гарсан саналууд, төслийн зураг төсөлд хэрхэн шингээж болохыг нэгтгэн хураангуйлах;
  - iii. Зөвшөөрөл шаардах нөхцөл байдлын тухайд, нөлөөнд өртөж буй уугуул иргэдтэй хийсэн зөвлөлгөөний үр дүн, үйл явц, тэндээс гарсан аливаа тохиролцоо, төслийн үйл ажиллагааг зохицуулах эрсдлийн удирлагын арга хэмжээг баримтжуулах;
  - iv. Төслийг хэрэгжүүлэхэд уугуул иргэдийн оролцоог хангах, зөвлөлгөөн ба оролцооны механизмыг тодорхойлох;
  - v. Баримт бичгүүдийг төсөл байдлаар болон эцсийн байдлаар нутгийн уугуул иргэдэд үзүүлж, ил болгох;
- e. Үр ашгийг хуваалцах зохицуулалтууд.** Уугуул иргэдийн соёлд хүндэтгэлтэй, жендэрийн мэдрэмжтэй байдлаар төслөөс нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нь хүртээх арга хэмжээг нарийн тодорхойлно.
- f. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ.** нутгийн уугуул иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг нарийн тодорхойлох; хэрвээ сөрөг нөлөөг арилгах боломжгүй бол бууруулах, учруулсан хохирлыг нөхөн төлөх гэх мэт арга хэмжээ.
- g. Чадавхжуулах.** Энэ хэсэгт (а) төслийн байршил дахь нутгийн уугуул иргэдийн асуудлыг шийдвэрлэх төрийн байгууллагууд, (б) нөлөөнд өртөж буй иргэд, байгууллагуудын эрсдийн менежментийн үйл ажиллагаанд оролцох нийгэм, эрх зүй, техникийн чадавхыг сайжруулах арга хэмжээг тодорхойлно.
- h. Эргэх холбоо ба санал, гомдол шийдвэрлэх механизм.** Нутгийн уугуул иргэдээс ирсэн санал, гомдлыг шийдвэрлэх горимыг энэ хэсэгт танилцуулна. Уугуул иргэдийн соёлд хүндэтгэлтэй, жендэрийн мэдрэмжтэй хэлбэрээр хэрхэн нутгийн уугуул иргэдэд хүргэх талаар тайлбартай байна.
- i. Тайлагнах, хянаж, үнэлэх.** НУИТ-г хэрэгжүүлэхэд төслийн хувьд тохиромжтой жишгийг танилцуулж, төслийн хэрэгжилтийг хянаж, үнэлэн, тайлагнах механизмыг тайлбарлана. ХШУ-ний тайланг бэлтгэх, батлах үйл явцад уугуул иргэдийн оролцоог хэрхэн хангах талаар мөн тайлбарласан байна.
- j. Институцын зохицуулалтууд.** НУИТ-нд заасан эрсдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх институцын зохицуулалтууд, механизмыг энэ хэсэгт тодорхойлсон байна. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн ТББ болон бусад байгууллагуудыг оролцуулах үйл явцыг тайлбарлана.
- k. Төсөв, санхүүжилт.** НУИТ-нд багтсан бүх үйл ажиллагааны төсвийг харуулна.

БОННУ хийх явцад зөвшөөрөл авах шаардлагатай нөхцөл үүссэн тохиолдолд зөвшөөрөл авах зорилгоор хөндлөнгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах шаардлагатай. Уугуул иргэдээс санал, гомдлыг нь сонсох зорилгоор оролцогч талуудын санал гомдол, эргэх холбооны механизмыг боловсруулна.

## ХАВСРАЛТ 9: ХӨДӨЛМӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖИШИГ ГОРИМУУД

---

Ажиллах хүч, хөдөлмөрийн нөхцлийн тухай БОНС2 стандартын хүрээнд зээлдэгч тал хөдөлмөрийн менежментийн горим (ХМГ)-ыг боловсруулна. ХМГ нь төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд туслах зорилготой. Зээлдэгч талд төслийн ажлыг зохион байгуулах шаардлагатай ажиллах хүчийг хаанаас татах, үүнтэй холбогдон гарах эрсдлийг олж тогтоох зэрэг асуудлуудыг өөртөө багтаана. ХМГ-ыг төслийн бэлтгэл үед боловсруулдаг бөгөөд төсөл хэрэгжих явцад шинэчлэгдэн, хөгжиж явдаг “амьд” баримт бичиг юм.

Хөдөлмөр эрхлэлтийг төлөвлөх, зохион байгуулахад зээлдэгч талд дэмжлэг болох хэлбэрээр боловсруулагдсан байна. Агуулга нь төслийн аль асуудал дээр хөдөлмөр эрхлэлт хөндөгдөж байна түүнийг ХМГ-аас харж болохоор боловсруулагдана. Зарим асуудал хамааралгүй байж болно. Тухайлбал зарим төслийн бэлтгэл үед анхаарлаа хандуулах ёстой илүү чухал асуудал байж болно. БОНС2-ын шаардлагуудыг тухайн улсын хуульд зааж өгсөн байгаа бол ХМГ-д заавал дахин давтаж оруулах шаардлагагүй. ХМГ-ыг нэг бол тусдаа баримт бичиг хэлбэрээр, эсвэл байгаль орчин, нийгмийн менежментийн баримт бичгийн нэг хэсэг болгон боловсруулж болно.

Төсөл хэрэгжүүлэх нэгж, гэрээт компаниуд, гэрээт ажилтнууд, төслийн ажилтнууд гэх мэт янз бүрийн оролцогч талуудад төслийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар тодорхой ойлголттой болоход тус болно. Төслийн төрлөөс болон хэр их мэдээлэл байгаагаас хамааран ХМГ-ын нарийвчлал тодорхойлогдоно. Хэрвээ хэрэгтэй мэдээлэл нь байхгүй байсан бол ХМГ-д энэ тухай тэмдэглэж, мэдээллийг шуурхай олж авахад анхааран ажиллана.

ХМГ боловсруулах, шинэчлэх ажлыг гүйцэтгэхдээ зээлдэгч тал тухайн улсын хууль, БОНС2 дахь шаардлагууд, БОНС2 дахь зөвлөмжид үндэслэнэ. Энэхүү загварт БОНС2, Зөвлөмжийн аль алианаас нь эшлэл авав.

*Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө (ХМГ)-ний жишиг загварын хураангуй:*

### 1. ТӨСЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АСУУДАЛ

Байгаа мэдээлэлд үндэслэн, энэ хэсэгт дараах асуудлыг тодорхойлно:

- a. Төслийн ажилтнуудын тоо: Төслийн хүрээнд ажиллуулах ажилтнуудын тоо, төрөл: шууд ажилтнууд, гэрээт ажилтнууд, нийгмийн ажилтнууд. Тоо тодорхой болоогүй бол барагцаагаар оруулна.
- b. Төслийн ажилтнуудын шинж чанар: орон нутгийн ажилтнууд, дотоод, гадаадын цагаач иргэд, эмэгтэй ажилтнууд, залуу ажилтнууд (18 нас) зэрэг бүх төрлийн ажилтнуудын онцлог шинжийг дэлгэрэнгүй тайлбарласан байна.
- c. Хөдөлмөр эрхлэлтийн цаг хугацааны шаардлага: Ажилтнуудын тоо, ажиллах байршил, ажлын төрөл, шаардагдах үр чадвар зэрэг хөдөлмөр эрхлэлтийн цаг хугацаа, эрэмбэ дараалал.
- d. Гэрээт ажилтнууд: Төслийн гэрээ байгуулах зохион байгуулалт, гэрээт ажилтны тоо, төрөл, гэрээт ажил тухай бүрт авч ажиллуулах ажилтны тоо. Хэрвээ гэрээт ажилтнуудыг зуучлагч, агентлагаар дамжуулан хөлслөх бол хэдэн ажилтан авч ажиллуулах талаар баримжаалсан тоо.
- e. Цагаач ажилтнууд: Хэрвээ төсөлд дотоод, гадаадын цагаач ажилтнууд ажиллах бол энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.

## **2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГОЛ ЭРСДЛҮҮД**

Байгаа мэдээлэлд үндэслэн, энэ хэсэгт дараах зүйлсийг тодорхойлно:

- a. Төслийн үйл ажиллагаа: Төслийн төрөл ба байршил, төслийн ажилтнуудын гүйцэтгэх ажил.
- b. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гол эрсдлүүд: Төсөлтэй холбоотой хөдөлмөр эрхлэлтийн эрсдлүүд (БОНС2, Зөвлөмжид заасан жишээг үзнэ үү). Тухайлбал:
  - Битүү орчин, өндөрт ажиллах, хүнд машин, механизм ашиглах, аюултай эд материалтай харилцах гэх мэт аюултай үйл ажиллагааны горим
  - Салбар байршлаас хамаарсан, хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлтийн эрсдэл
  - Цагаач болон улирлын чанартай ажилчдын тоо
  - Ажиллах хүчний илүүдэл, жендэрт суурилсан хүчирхийлэл
  - Ажлын байрны осол, гэмтэл, салбар, байршлаар
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын тухай ерөнхий ойлголт, хэрэгжилт

## **3. ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТУХАЙ ХУРААНГУЙ: НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

Ажлын нөхцөл, шаардлагатай үялдуулан тухайн улсын хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн заалтууд төрөл бүрийн ажилтнуудад хэрхэн үйлчлэх тухай ерөнхий ойлголтыг өгнө. БОНС2-ын заалтуудтай холбоотой хууль, тогтоомжийн хураангуй тайлбар (тухайлбал, цалин, шимтгэл, урамшуулал гэх мэт).

## **4. ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТУХАЙ ТОВЧ ХУРААНГУЙ: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ**

Энэ хэсэгт тухайн улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалтай холбоотой хууль, тогтоомж, тэдгээр нь 1-р хэсэгт тусгасан төрөл бүрийн ажилтнуудад хэрхэн үйлчлэх талаарх гол ойлголтуудыг өгнө. Энэ нь БОНС2-ын 24-30 дахь хэсэгт заасан зүйлстэй холбоотой хуулийн заалтуудад хамааралтай. The overview focuses on legislation which relates to the items set out in ESS2, paragraphs 24 to 30.

## **5. ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТНУУД**

Энэ хэсэгт дараах ажлуудыг хариуцаж, гүйцэтгэх албан тушаалтан, хувь хүнийг тодорхойлсон байна :

- a. Төслийн ажилтнуудын оролцоо, зохион байгуулалт
- b. Гэрээт ажилтан, туслан гүйцэтгэгчдийн оролцоо, зохион байгуулалт
- c. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)
- d. Ажилчдын сургалт
- e. Ажилчдын санал, гомдлыг шийдвэрлэх

Зарим төсөлд, гэрээт болон туслан гүйцэтгэгч нарыг гуравдагч тал хөлслөн ажиллуулж байгаа бол гэрээт компанийн албан тушаалтнуудаас хариуцагчийг сонгож, томилно.

## **6. ДҮРЭМ, ЖУРАМ**



Энэ хэсэгт ХАБЭА, тайлагнах, хяналт, шинжилгээ, үнэлгээ, болон төслийн бусад дүрэм журмыг танилцуулна. Мөн холбогдох хуулийн заалтуудыг тусгаж өгнө.

2-р хэсэгт томоохон эрсдэл үүсэх нь тодорхой болбол тухайн эрсдлийг шийдвэрлэх арга замыг танилцуулна. Мөн албан хөдөлмөр эрхлэлтийн эрсдэл үүсвэл хэрхэн шийдвэрлэх талаар заалтуудыг оруулна (БОНС2, 20-р хэсэг, холбогдох Зөвлөмжүүд). Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх эрсдэл үүсэхээр байвал, шийдлийг 7-р хэсэгт танилцуулсан байна.

Зээлдэгч тал хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар тусдаа баримт бичигтэй бол бусад баримт бичгийн хамтаар ХМГ-д эшлэж оруулах, эсвэл хавсралтаар оруулж болно.

## **7. ХӨДӨЛМӨРИЙН НАС**

Энэ хэсэгт дараах зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл орно:

- a. Төсөл дэх хөдөлмөрийн насны доод хязгаар
- b. Төслийн ажилтнуудын насыг баталгаажуулах горим
- c. Төслийн ажилд хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ажиллаж байгаа нь илэрсэн тохиолдолд дагаж мөрдөх горим
- d. Хөдөлмөрийн насны доод хязгаарт байгаа ажилтнуудтай холбоотой учрах эрсдлийг үнэлэхэд дагаж мөрдөх горим

БОНС2, 17-19-р хэсгүүд, холбогдох Зөвлөмжүүдийг үзнэ үү.

## **8. НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

Энэ хэсэгт дараах зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл орно:

- a. Цалингийн хэмжээ, ажлын цаг, төслийн хүрээнд тавигдах бусад нөхцлүүд
- b. Төслийн хүрээнд баримтлах ажлын цагийн дээд хязгаар
- c. Төслийн хүрээнд нийтээр зөвшөөрсөн аливаа тохиролцоо. Ийм тохиролцоо хийгдсэн бол жагсаалт гаргаж, тухайн тохиролцоо нэг бүрийн шинж чанар, заалтуудыг баримтжуулах
- d. Бусад нарийвчилсан нөхцөл, шаардлагууд

## **9. САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ**

Үндсэн ба гэрээт ажилчдын санал, гомдлыг шийдвэрлэх, шийдвэрлэх үйл явцыг ажилчдад мэдэгдэх горим зэргийг энэ хэсэгт танилцуулна.

Нийгмийн ажилтнууд төслийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа тохиолдолд тэдний санал, гомдлыг шийдвэрлэх механизмын тухай мэдээлэл 11-р хэсэгт орсон болно.

## **10. ГЭРЭЭТ АЖИЛТАН/ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН МЕНЕЖМЕНТ**

Энэ хэсэгт дараах зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл орно:

- a. БОНС2, 31-р хэсэг, Зөвлөмжийн 31.1-д заасан гэрээт ажилтан, туслан гүйцэтгэгч шалгаруулах ажиллагаа
- b. Гэрээт, туслан гүйцэтгэгч нартай холбоотой хөдөлмөрийн асуудлууд, тухайлбал БОНС2, 32-р хэсэг, Зөвлөмж 32.1-т заасан ХАБЭА-н талаарх гэрээний заалтууд
- c. БОНС2, 32-р хэсэг, Зөвлөмж 32.1-т заасан гэрээт, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг хянах, удирдах ажиллагаа

#### **11. Нийгмийн ажилтнууд**

Төслийн үйл ажиллагаанд нийгмийн ажилтнууд оролцох тохиолдолд, нийгмийн ажил нь сайн дурын үндсэн дээр явагдаж байгаа эсэхийг хянах аргачлал, нийгмийн ажлын нөхцөл шаардлага зэрэг багтана. Нийгмийн ажлыг ямар гэрээнд тулгуурлаж, баримтжуулах талаар Зөвлөмж 34.4-т заасан болно.

Мөн нийгмийн ажилтнуудын санал, гомдлыг шийдвэрлэх, нийгмийн ажилтнуудын үүрэг, хариуцлага, хяналтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. БОНС2, 36, 37-р хэсгийг үзнэ үү.

#### **12. АНХАН ШАТНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН АЖИЛТНУУД**

Анхан шатны нийлүүлэгч компанид хүүхдийн болон албадан хөдөлмөрийн асуудал гарсан тохиолдолд үүнийг хянах, мэдээлэх горимыг энэ хэсэгт танилцуулна.

## ХАВСРАЛТ 10: ЖЕНДЭР

---

Дэлхийн Банк жендэрийн асуудлыг шийдэхдээ “Дэлхийн Банк Группын Жендэрийн стратеги” (FY16-23), ОР4.20: “Жендэр ба Хөгжил” баримт бичгүүдийг баримталдаг. “Жендэрийн стратеги” нь бүс нутгийн жендэрийн асуудлаарх үйл ажиллагааны төлөвлөгөө, улс орны тандалт судалгаа (зарим бүс нутагт улс орны онцлогт тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөө, платформууд) зэрэг улс орон, салбарыг хамарсан арга хэрэгслүүд, “Даян дэлхийн жендэрийн стратеги”-ийн дагалдах баримт бичгүүдээр баталгааждаг.

Төслийн хэмжээнд БОНБББ дэх жендэрийн талаарх заалтууд нь жендэрийн тэгш эрх, оролцоог, ялангуяа эмзэг бүлгийнхний хүрээнд, тухайлбал жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдлийг бууруулах гэх мэт асуудалд илүү анхаарсан. Томоохон барилгын ажил хийгдэх хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй бэлгийн дарамт, хүчирхийлэл, заналхийллийн эрсдлийг зөв удирдах талаар 2018 оны Жендэрт суурилсан хүчирхийллийг арилгах талаар Сайн түршлагын тэмдэглэлд зөвлөмж тусгасан байна. Жендэрийн тэгш байдлын зөрүүг төслийн хэмжээнд арилгах боломжуудыг БОНБББ-үүдэд бас тусгаж өгсөн.

Зээлдэгч тал БОНС стандартын шаардлагуудыг биелүүлэх үүрэгтэй бол Дэлхийн Банк БОНБББ-ийн хүрээнд хяналт, шалгалтаа хэрэгжүүлнэ. БОНБББ-ийн дагуу, Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжиж буй төслийг БОНС стандартад нийцүүлэн хэрэгжүүлэхэд нь Зээлдэгч талд Дэлхийн Банк туслалцаа үзүүлнэ. БОНБББ-ийн хэрэгжилт нь зээлдэгч талын жендэрийн тэгш бус байдал гэх мэт БОНБББ-т тусгагдсан асуудлуудыг хэр сайн ухамсарлаж, үйл ажиллагаандаа тусгаснаас ихээхэн хамаарна. Үүний тулд, Дэлхийн Банкны зүгээс төсөл хэрэгжүүлэх нэгжийн хамт олонд БОНБББ дэх жендэрийн шаардлагууд болон төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацааны туршид тэгш байдлыг хангах асуудлыг хянах тал дээр техникийн сургалт өгөх зэргээр туслалцаа үзүүлж ажиллана.

Төсөл сонгох, үнэлэх, БОННУ хийх, батлуулах, хэрэгжүүлэх, хянах гээд төслийн бүхий л үе шатанд жендэрийн тэгш байдлыг хангах, тэгш оролцоог дэмжих боломжийг дараах таван тусгай механизмаар бүрдүүлж байна. Үүнд:

- a. жендэрийн тэгш бус байдлаас урган гарах гэх мэт эрсдэл, нөлөөллийг эхний байдлаар **тодорхойлох**;
- b. байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг **үнэлэх**, тэдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахдаа жендэрийн тэгш бус байдлыг аль болох бага байлгах зарчмыг баримтлах (БОНС-уудад заасны дагуу БОННУ, БОНМТ, НШТ, ХМГ, ТОДТ гэх мэт). Жендэрийн тэгш байдлын талаарх иж бүрэн дүн шинжилгээ хийх шаардлага гарч болзошгүй;
- c. төсөл хэрэгжиж эхэлснээс дуусах хүртэл бүхий л хугацаанд жендэрийн тэгш бус байдалд өртөх эрсдэлтэй **оролцогч талуудыг** зөвлөлгөөнд оролцуулж, мэдээллээ хуваалцаж, хохирлыг барагдуулах механизмдаа эргэх холбоотойгоор (ТОДТ-нд заасны дагуу) **хамруулах**;
- d. БОНАТ дэх жендэрийн мэдрэмжийн асуудлаар **үүрэг амлалтыг хүлээн зөвшөөрөх**;
- e. төслийн жендэртэй холбоотой **дасан зохицох эрсдлийн удирлага ба хяналт**.